

ГАРЧИГ

Гарчиг	1
Ерөнхий тойм	2
Бүлэг-1 Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	3-81
1. Байгаль орчныг хамгаалах бодлогын хэрэгжилтийг хангах гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	4-25
2. Газар, газрын хэвлийн, тусгай хамгаалалттай газар нутаг, байгаль орчны ерөнхий үнэлгээ гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	26-30
3. Ойн ашиглалт, хамгаалалт, ойн нөхөн сэргээлт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	31-44
4. Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	45-46
5. Амьтан ашиглалт, тоо толгойг тогтоох, агнуурын бүсүүдийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ	47-52
6. Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр арга хэмжээ	53-57
7. Хот суурин газрын орчны бохирдлын хэмжээг бууруулах ага хэмжээ гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ	58-59
8. Байгаль орчны чиглэлийн сургалт сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ, шинэлэг арга хэмжээ, хяналт шалгалт, мэдээллийн санг баяжуулах гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ	60-81
Бүлэг-2 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын албан даалгаврын хэрэгжилт	82-94
1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/70 тоот албан даалгавар	83-90
2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017.06.06-ны өдрийн 1/3395 албан тоот	91
3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 3-р сарын 19-ны өдрийн 2 дугаар албан даалгавар	92-94
Хавсралтууд	95-145

Ерөнхий тойм Удирдлага зохион байгуулалт, төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн талаар

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2017 оны жилийн эцсийн байдлаар удирдах ажилтан 2, гүйцэтгэх ажилтан 42 , үйлчлэх ажилтан 3 ний 47 хүний орон тоотой ажиллаж байна.

2017 онд иргэн болон холбогдох байгууллагуудаас нийт 27 өргөдөл ирснийг хянан шийдвэрлэсэн байна.

2017 онд төрийн захиргааны байгууллага болон бусад холбогдох байгууллагаас нийт 544 албан бичиг ирснийг хүлээн авч албан хэрэг хөтлөлтийн бүртгэлд бүртгэн хяналтын карт хөтлөж шийдвэрлэлтэнд хяналт тавьж 282 хугацаатай бичгийн хариуг хүргүүлж ажиллаа. 350 албан бичгийг төр захиргааны байгууллага болон бусад холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Мөн мэргэжилтэнгүүд өдөр тутмын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг гарган газрын даргад танилцуулж, байгаль хамгаалагч нар сар,хагас жилийн тайланг гэрээнд заасан хугацааны дагуу сумын ЗДТГазрын дарга болон БОХУБайцаагчаар хянуулан баталгаажуулан ирүүлсэн.

Хагас жилийн тайланг гарган Байгаль орчин, аялал жуулчлалын яамны цахим хаягаар хүргүүлж ажиллалаа. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хийж гүйцэтгэсэн 7 хоногийн мэдээг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж ажиллав.

БҮЛЭГ-1

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

1. “Байгаль орчныг хамгаалах бодлогын хэрэгжилтийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ
2. “Газар, газрын хэвлий, тусгай хамгаалалттай газар нутаг, байгаль орчны ерөнхий үнэлгээ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ
3. “Ойн ашиглалт, хамгаалалт, ойн нөхөн сэргээлт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ
4. “Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ
5. “Амьтан ашиглалт, тоо толгойг тогтоох, агнуурын бүсүүдийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ
6. “Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр арга хэмжээ
7. “Хот суурин газрын орчны бохирдлын хэмжээг бууруулах арга хэмжээ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ
8. “Байгаль орчны чиглэлийн сургалт сурталчилгаа, хяналт шалгалт, мэдээллийн санг баяжуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ

1. “Байгаль орчныг хамгаалах бодлогын хэрэгжилтийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ

- 1.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Бүх нийтээр мод тарих” үндэсний өдрийг зарлах тухай 63 дугаар зарлиг, Хууль бус мод бэлтгэлийг эрчимжүүлэх тухай 48 дугаар зарлиг, Засгийн газарт чиглэл өгөх тухай 178 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах
- 1.2 Монгол улсын Засгийн газрын байгаль орчинтой холбоотой гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах
- 1.3 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах
- 1.4 Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй байгаль орчны чиглэлийн үндэсний хөтөлбөрийн биелэлтийг ханган ажиллана
- 1.5 БОАЖСайдтай аймгийн Засаг даргын 2017 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллана
- 1.6 Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт
- 1.7 Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, ИТХ-ын хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах
- 1.8 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт байгаль орчны чиглэлээр тусгагдсан арга хэмжээний биелэлт, үр дүн

1.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг зарлах тухай 63 дугаар зарлиг, Хууль бус мод бэлтгэлийг эрчимжүүлэх тухай 48 дугаар зарлиг, Засгийн газарт чиглэл өгөх тухай 178 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар зарлагдсан “**Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр**” 2017 оны 05 сарын 13, 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдлаа. Тус өдрийг Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумдын Засаг даргын Тамгын газар, “Өндөрхаан хот тохижилт” ОНТҮГ, ОБГ, “Хэнтий –Ус” ХХК хамтран зохион байгуулж ажиллалаа. Тус үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэд идэвхи санаачлага гарган оролцож, мод тарих үүргээ биелүүлж аймгийн хэмжээнд нийт 21126 мод тарив. Тус үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 3577 иргэн, 652 байгууллага, ААН оролцож 58,5 сая төгрөгийг зарцуулсан байна. Тарьсан модыг цаашид усалж арчлан ургуулах чиглэл өгч ажилласан.

Аянд нэгдэн мод тарьж буй иргэн, төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд Зураг:1



“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” тохиож байгаатай холбогдуулан Чингис хот болон хээрийн бүсийн сумдыг модны тарьц, суулгацаар хангах зорилгоор үзэсгэлэн худалдааг 05-р сарын 11-13, 10 сарын 12-14 өдрүүдэд “Эвт худалдааны төв” –д зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд “Биндэр -Ой” сум дундын ойн анги, “Батширээт” сум дундын ойн анги, Хэнтий шинэс ойн анги, Жимсний баяжмал нөхөрлөл, Хэрлэнгийн ногоон төгөл нөхөрлөл, Дархан хатдын үзэсгэлэн ТББ болон Улаанбаатар хотоос иргэд оролцож Нарс, Шинэс, Өрөл, Долоогоно, Нохойн хошуу, Үхрийн нүд, Тэхийн шээг, Хайлаас, Монос, Шар хуайс, Далийн Ягаан, Улиас, Гүйлс, Интор, Чацаргана, Гүзээлзгэнэ зэрэг нийт 21 төрлийн 10,0 мянган ширхэг мод худалдаалсан байна.

Модны үзэсгэлэн худалдаа Зураг:2



1.2 Монгол улсын Засгийн газрын байгаль орчинтой холбоотой гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах Хүснэгт:1

1.3 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах

2017 онд Ойгоос мод бэлтгэх дээд хязгаар батлах тухай А-111 тоот тушаал

БОАЖСайдын 2016 оны А/111 тоот "2017 онд ойгоос мод бэлтгэх хязгаар батлах тухай" тушаалыг үндэслэн аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Хэнтий аймгийн "2017 ойд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай" 04 тоот тогтоолоор нийт 101131м3 модыг 888 га талбайгаас бэлтгэхээр сум тус бүрээр хувиарлан баталуулсан. Одоогийн байдлаар 34156 м3 мод бэлтгэн 160,0 сая төгийг төсөвт төвлөрүүлсэн.

Журам батлах тухай-"Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журам" А-223 тоот тушаал

Ойн мэргэжлийн байгууллагын эрх сунгуулах хүсэлт гаргасан 5 аж ахуй нэгжид дүгнэлт гарган, ойн мэргэжлийн байгууллагын эрх шинээр авах 1 аж ахуйн нэгжид дүгнэлт тус тус гарган БОАЖЯ-д хүргүүлсэн.

Журам батлах тухай-"Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам" А-153 тоот тушаал

2017 онд ой сум, сум болон сум дундын ойн ангиуд ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг 4528 ширхэг, мод модон материалын гарал үүслийн гэрчилгээ 2102 ширхэгийг тус тус журмын дагуу олгосон.

Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллого хийх ажлын удирдамж А-71 тоот тушаал

Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан сумын Засаг дарга болон байгаль орчны хяналтын улсын байцаагч байгаль хамгаалагч нарт чиглэл өгч уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн орхигдсон талбайн урьдчилан судалгааг гаргуулах ажлыг эхлүүлээд байна. 2018 оны байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал төсвийг суулган эвдэрсэн газрын тооллого судалгааг хийхээр төлөвлөж байна.

"Тусгай болон ахуйн зориулалтаар амьтан агнах, барих хуваарь батлах тухай" А-149 тоот тушаал

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 12-р сарын 27-ны өдрийн А/149 тоот "Тусгай болон ахуйн зориулалтаар амьтан агнах, барих хуваарь батлах тухай" тушаалыг үндэслэн аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 01 тоот тогтоолоор Хэнтий аймгийн 2017 онд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоосон. Энэхүү тогтоолоор Хэнтий аймгийн хэмжээнд ахуйн зориулалтаар 30 зэрлэг гахай, 60 бор гөрөөс, 110 цагаан зээр, 1000 загас болон тусгай зориулалтаар 50 цагаан зээр, 3 бор гөрөөс, 5 зэрлэг гахай, 80 тул загас, 150 шувуу агнуулах, бариулахаар хувиарлагдсан. 2017 онд 736 толгой загас, 28 толгой бор гөрөөс, 24 толгой зэрлэг гахай, 1 толгой цагаан зээрийг ахуйн зориулалтаар агнуулсан.Тусгай зориулалтаар 80 толгой тул, 800 толгой бусад загас бариулсан,3 толгой угалз, 5 толгой цагаан зээр, 50 толгой агнуурын шувуу ,180 толгой хөхвөр тагтаа агнуулсан, 50 толгой идлэг шонхор амьдаар гадаад улсад гаргасан бөгөөд орон нутгийн төсөвт нийт 491228,32 мян.төгрөг төвлөрсөн.

"Статистик мэдээллийн сан үүсгэх" тушаалын хэрэгжилтийг ханган ажиллана А-361 тоот тушаал

БОХ-4-Усны ашиглалт хамгаалалт, бохир ус цэвэрлэх байгууламж, усны чанар төлөв байдлын тайлан, БОХ-5-Ойн нөөц, түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн тайлан, БОХ-6- Амьтны аймгийн нөөц, түүний ашиглалт, хамгаалалтын тайлан, БОХ-7- Хатуу хог хаягдал болон хог хаягдал дахин боловсруулалтын тайлан, БОХ-8 Орчны болон агаарын чанарын төлөв байдлын тайлан, БОХ-9 Гамшгийн тайлан, БОХ-10 Байгалийн ургамлын нөөц, ашиглалт, хамгаалалтын тайланг <http://geodata.mne-ngic.mn/box/>-хаягт нэгтгэсэн. 2017 оны эхний улиралд 2016 оны БОХ-1, БОХ-2, БОХ-3 тайлангуудыг <http://geodata.mne-ngic.mn/box/>-хаягт нэгтгэсэн.

1.4 Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй байгаль орчны чиглэлийн үндэсний хөтөлбөрийн биелэлтийг ханган ажиллана

1.Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр Хүснэгт-2

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр 2011.09.21-ний өдөр №277 тогтоол	Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэн нэн ховор,ховор амьтдын тоо толгой цөөрөх, амьдрах орчин доройтохоос сэргийлж, байгалийн жамаар хэвийн өсөж үржих нөхцөлийг нь хангах , зориудаар үржүүлж, цөм сүргийг хамгаалах замаар тэдгээрийн тоо толгой тархац нутгийг нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх зорилготой.			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Орон нутгийн төсөв, агнуурын бүс нутаг хариуцагчдийн хөрөнгө			
3	Хэрэгжүүлэгч байгууллага / хэрэгжих нийт хугацаа/	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: аймгийн ЗДТГазар, агнуурын бүс хариуцагчид			
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: сумын ЗДТгазар , иргэдийн нөхөрлөл			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	<p>Зорилт-1 Нэн ховор, ховор амьтдын тархац нутгийг улсын, орон нутгийн тусгай хамгаалалтанд авах</p> <p>Зорилт-2. нэн ховор, ховор амьтдын зүйл бүрийг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн урт, богино хугацааны зорилтыг тодорхойлсон ан амьтны менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ;</p> <p>Зорилт-3. ан амьтны менежментийн төлөвлөгөөг үндэслэн нэн ховор, ховор амьтны байршил нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн орон нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагад хариуцуулан хамгаалах эрх зүй, эдийн засгийн үндсийг бүрдүүлж, хэрэгжүүлнэ;</p> <p>Зорилт-4. Ховор амьтдын байршил /аргаль, буга/ нутгийн булаг, шандыг ширгэхээс сэргийлж усан сан, худаг гаргах</p> <p>Зорилт-5 Ган зудны гамшиг тохиолдохоос сэргийлж ховор амьтдад биотехникийн арга хэмжээ авах орон нутгийн төсөвт зардлыг тусгах</p> <p>Зорилт-6 Нэн ховор, ховор амьтдын талаар олон нийтэд сурталчлах</p>			
5	Зардал	Төсөв мян.төг	40 492,0		
		Үүнд:	Төсөв 2017 /мян.төгрөг/	Гүйцэтгэл /мян.төгрөг/	Хувь
		Багц 1	0	0	90
		Багц 2	20000,0	19800,0	100
		Багц 3	0	0	100
		Багц 4	8500,0	8500,0	100
		Багц 5	8992,0	8992,0	100
Багц 6	3000,0	3000,0	100		

6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ						
	1-р зорилтын хүрээнд:		Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага сумдын хил дамансан “Хурх хүйтний хөндий” орчмын газрын 190332.9 га талбайг Улсын тусгай хамгаалаттай газрын байгалын нөөц газрын ангиллаар авах саналыг Аймгийн ИТХурын дөрөвдүгээр хуралдааны 02 дугаар тогтоолоож дэмжүүлж, Батширээт, Биндэр сумдын хил дамансан “Гутайн даваа” орчмын газрын 39930.03 га талбайг Улсын тусгай хамгаалаттай газрын байгалын нөөц газрын ангиллаар авах саналыг Аймгийн ИТХурын Тавьдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоож дэмжүүлж “Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлээд байна.						
	2-р зорилтын хүрээнд:		Хэнтий аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, агнуурын бүсүүд, менежментийн төлөвлөгөөг/2018-2022/ ажлын хэсэг актаар хүлээн авч 2017 оны аймгийн ИТХ-н тэргүүлэгчдийн хуралдааны 83-р тогтоолоор дэмжин БОАЖЯамаар батлуулахаар уламжлаад байна.						
	3-р зорилтын хүрээнд:		Ховор амьтан тулын өлгий нутаг Онон голын загас агнуурын бүсийн менежментийг хариуцагч Онон голын Загасчдын клуб ТББайгууллага,Ховор амьтан аргаль, буга нутагдаг "Мөрөн","Баян-Уул" агнуурын бүсийн менежментийг хариуцагч "Ханомаро тур"ХХК-ны 2017 оны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг БОАЖГазар дүгнэн эдгээр агнуурын бүс хариуцагч нарын менежмент хариуцах гэрээнүүдийг 10 жилийн хугацаагаар сунган ажилласан.						
	4-р зорилтын хүрээнд:		Батширээт сумын Бэлийн булгийн эхийг Навчит хайрхан нөхөрлөлөөр 500,0мянган төгрөгөөр хашиж хамгаалах ажлыг гүйцэтгүүлсэн.Биндэр сумын 4 багийн 10 булгийн эхийг иргэд, ойн нөхөрлөлтэй хамтран 3,0 сая төгрөгөөр хашиж хамгаалсан.Норовлин сумын Цагаан хошууны булгийг 250м тойруулан шургаагаар 1500,0мянган төгрөгөөр, Бэрхийн булгийн эхийг 160м тойруулан шургаагаар 1500,0мянган төгрөгөөр, Буянт булгийн эхийн 2 ундаргыг тус бүр 120м тойруулан тулгууртай модон шонтой шургаагаар 1500,0 мянган төгрөгөөр тус тус Нарс, Бэрх, Баян ойн нөхөрлөлүүд хашаажуулсан.Мөрөн сумын Хөндлөн булгийн эхийг 2 иргэнээр 500,0 мянган төгрөгөөр хашаажуулсан.						
	5-р зорилтын хүрээнд:		Аймгийн Галшар, Баянхутаг, Баянмөнх, Дархан, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дадал, Норовлин, Мөрөн, Бор-Өндөр сумдын нутагт нутагших ховор амьтдын байршил 29 газарт сумдад олгосон байгаль хамгаалах зардал болох 8992,0мян.төгрөгөөр нийт 12 шуувай шүү, 6 шуудай хийвэг, 400кг улаан буудай, 500кг давс, 1320 боодол өвс, 18,1тн хужир тавьсан.						
6-р зорилтын хүрээнд:		Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархац нутаг нь хумигдаж, тоо толгой нь цөөрч устах аюулд орсон биологийн төрөл, зүйлүүдийн талаар мэдлэг, мэдээлэл олгох, байгаль хамгаалах үйлсэд сурагчдын оролцоог нэмэгдүүлэх, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах төлөвшил олгох зорилго бүхий “Улаан номыг хэн сайн мэдэх вэ?” танин мэдэхүйн уралдаант тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 2017 оны 05-р сарын 11-ний өдөр Хан Хэнтий цогцолбор сургууль дээр зохион байгуулсан.							
7	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6
		97%	6	90	90	100	100%	100%	100%
8	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ		Нэгдсэн үнэлгээ						
	(ЗГХЭГ-ын үнэлгээ)		97%						

2. Ус үндэсний хөтөлбөр Хүснэгт-3

д/д	Хөтөлбөр төслийн агуулга	Гүйцэтгэл 2017			
1	"Ус" үндэсний хөтөлбөр 2010 оны 05 сарын 20 өдөр Монгол Улсын Их Хурлын 24 тоот тогтоол	Монгол орны усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглан улс орны хөгжлийн түлхүүр болгох, монгол хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Орон нутгийн төсвийн хөрөнгө			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч: Байгаль орчин, аялал жуулчлалын газар Хамтран хэрэгжүүлэгч: Сумын ЗДТГазар, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. 3.1.6.булаг, шандны эхийг хамгаалах ажлыг үргэлжлүүлэн хийж, жилд 140-өөс доошгүй (тухайн аймаг дахь булаг, шандны тооноос хамааран 1 -8) булаг, шандны эхийг тохижуулж хамгаалах ажлыг хийх			
		Зорилт 2. 3.2.3.газар доорхи усны хяналт-шинжилгээний улсын сүлжээг шинээр байгуулж, уул уурхайн хяналтын цооногууд, нийслэл, аймгийн төвийн ус хангамжийн эх үүсвэрийн дэвсгэр талбайг хамарсан хяналт-шинжилгээний цооногуудыг өрөмдөж тоноглон улсын сүлжээнд холбох, орчин үеийн холбооны системийг ашиглан мэдээлэл, өгөгдлийг шуурхай дамжуулах технологид шилжүүлэх;			
		Зорилт 3 3.3.26. монгол орны нутаг дэвсгэрт хөв, цөөрөм байгуулж ашиглах боломжийн талаархи хайгуул, судалгааны үр дүн, орон нутгийн эрэлт хэрэгцээ, захиалга дээр үндэслэн 130-аас доошгүй газарт хөв, цөөрөм байгуулж ашиглах			
		Зорилт 4 3.3.17.хөдөөгийн хүн ам, мал аж ахуйн ус хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийг усжуулах арга хэмжээг тасралтгүй явуулж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, бэлчээр ашиглагч, фермерийн аж ахуй, хөдөө аж ахуйн салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулан жилд 800-1000 худгийг шинээр гаргаж, сэргээн засварлах;			
		Зорилт 5 3.5.1. аж ахуйн үйл ажилгааны нөлөөлөл, ачаалал ихтэй голуудын сав газрын зөвлөл, захиргаадыг байгуулан ажиллуулна. Усны нөөц болон бусад нөөцийг зохистой ашиглах, хамгаалах цогц үйл ажиллагаатай уялдуулан менежментийн цогцолбор төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх			
		Зорилт 6 3.6.1.нийслэл, аймгийн төв, сум, суурин, баг, хот айлын хэмжээнд ойр орчныхоо усны эхийг хамгаалах, цэвэр ариун байдлыг хангах, сөрөг нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг жилд 2 удаа зохион байгуулж хэвшүүлэх;			
5	Төсөв (Нийт шаардагдах зардал) 46,5 сая				
		Багц 1	14,5	14,5	100
		Багц 2	23,5	23,5	100
		Багц 3	2,5	2,5	100
		Багц 4	3	3	100
		Багц 5	0	0	100
		Багц 6	3	3	100
	Төсөл, хөтөлбөрийн зорилтуудын хэрэгжилт				
6	1-р зорилтын хүрээнд	Аймгийн хэмжээнд нийт 17 булгийн эх хамгаалагдсан. Үүнд: Жаргалтхаан сум Хааны булаг, Батноров сумын "Ардын хөв"-ийг тэтгэгч булаг, Хэрлэн сум Нарангийн булаг, Галшар сум Хөвөрийн бүрдний эх, Бор-Өндөр сум Далангүрүүний рашаан, Норовлин сум Цагаан хошууны булаг, Батширээт сум Бэлийн булаг, Биндэр сум 10 булгийн эхийг тус тус хашаажуулснаар ундаргыг малын хөлд дарагдах, байгалийн аясаар нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлэн ажилласан.			
7	2-р зорилтын хүрээнд	Чингис хотын хүн амын унд ахуйн усны эх үүсвэрийн газрын доорхи усны ордын ашиглалтын байдалд хяналт- шинжилгээ хийх 2 цооногт БОАЖЯ-ны захиалгаар мэдээлэл дамжуулах ком суурилуулсан. Мөн Чингис хотын хүн амын ундны усны 3			

		эх үүсвэрт онцгой хамгаалалтын бүсээр нь хамгаалалтын хашаа барьлаа.							
8	3-р зорилтын хүрээнд	2017 онд хөв цөөрөм байгуулах төсөв зардалд тусгагдаагүй тул хийгдээгүй. Харин Экосистемд түшиглэсэн дасан зохицох үйл ажиллагааг уур амьсгалын өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь МОН12 төлийн санхүүжилтээр байгуулсан "Ардын хөв/10000м3/"-ийг усаар тэжээдэг Дундбүрдийн голын эхийг хашлаа.							
9	4-р зорилтын хүрээнд	Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар Бор-Өндөр сумд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 2 гар худаг 3,0 сая төгрөгөөр гаргуулсан. 2018 онд Мөрөн, Цэнхэрмандал, Баян-Овоо, Галшар сумдад бэлчээрийг усжуулах зориулалтаар худгийн зөвшөөрөл олгогдсон.							
10	5-р зорилтын хүрээнд	Аймгийн ИТХ-ын 13 дугаар тогтоолоор Нийт 129 гол горхи, 935 булаг, 417 нуур, 73 худгийн онугой болон энгийн, эрүүл хамгаалалтын бүсийг тогтоосон. Хэрлэн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд тэмдэг тэмдэглэгээ суурилуулах ажлыг Дархан, Баянмөнх, Баян-Овоо сумдаас эхэлсэн бөгөөд 2018 онд бусад сумдад хийхээр төлөвлөсөн болно.							
11	6-р зорилтын хүрээнд	Хэрлэн, Онон, Улз голын менежментийн төлөвлөгөө батлагдсан бөгөөд Умард голын гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа менежментийн төлөвлөгөөг батлуулсан. Харьяа сав газрын захиргаатай хамтран батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн усан сан бүхий газрын хог хаягдлын цэвэрлэгээг жилд 2 удаа зохион байгуулдаг төдийгүй эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангахыг зорин ажилладаг. Бор-Өндөр сумын Нархан цэцэрлэгт ус цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулсан.							
13	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Ололттой тал: 1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал тусгаж, байгаль орчныг хамгаалах нэн шаардлагатай ажлууд хийгдэж чадаж байна. Дутагдалтай тал: 1. Усны орлогод төлөвлөгдөөгүй орлого орсон тохиолдолд тодотголоор Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд тусгуулдаггүй.							
14	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хамтран ажиллах тал дээр бүх талууд сайн ажилласан.							
15	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6
		90%	6	100%	100%	100%	90%	70%	80%

3.Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр Хүснэгт-4

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр	Цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах гэж цөлжих эрсдэлтэй газар нутгийг цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, элсний нүүдлийг зогсоох, уул уурхайн нөхөн сэргээлт хийх, тариалангийн талбайн хөрс хамгаалах, усалгааны систем, ойн зурвас байгуулах, бэлчээрийн даацыг тохируулах болон цөлжиж байгаа газар нутгийг нөхөн сэргээх, мод, бут тарих, ургамалжуулах, усан сан байгуулах, гангийн нөлөөг бууруулах зэрэг үйл ажиллагааг
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Орон нутгийн төсөв, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал
3	Хэрэгжүүлэгч байгууллага / хэрэгжих нийт хугацаа/	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Аймгийн ЗДТГазар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сумын ЗДТгазар , Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд
4	Төсөл, хөтөлбөрийн	7.1. Байгууллагын чадавхийг бэхжүүлэх;

	тэргүүлэх чиглэлүүд	7.2. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;						
		7.3. Шинжлэх ухаан, технологийн мэдлэгийн хүрээг өргөжүүлэх;						
		7.4. Сурталчилгаа, оролцоог нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих;						
		7.5. Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх бодит арга хэмжээг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.						
5	Зардал	Төсөв	45,950.0					
		Үүнд:	Төсөв 2017 /мян.төгрөг/	Гүйцэтгэл /мян.төгрөг/		Хувь		
		Багц 4	7,800.0	7,800.0		100		
		Багц 5	38,150.0	38,150.0		100		
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ					
	4-р тэргүүлэх чиглэлийн хүрээнд: Хүрэх үр дүн 1:		Хэнтий аймгийн хэмжээнд Байгальд ээлтэй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, хэрэглээг нэвтрүүлж буй ААН-ийг жил бүр шалгаруулж, урамшуулах, сурталчилах уралдаан зарлаж шалгаруулах ажил хийгдэж байна.					
	Хүрэх үр дүн 2:		Эко сум, суурингийн шалгуур үзүүлэлтүүдийг гарган байгальд ээлтэй сумдыг шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж шалгаруулалтын ажил хийгдэж байна.					
	Хүрэх үр дүн 3:		ЕБСургуулийн багш, сурагчдын дунд "Тогтвортой хөгжлийн боловсролын олимпиад"-ыг зохион байгуулсан.					
	Хүрэх үр дүн 4:		Өндөрхаан ТВ-ээр 4-5 сард цөлжилтийн талаархи шторктийг өдөр бүр нэвтрүүлсэн.					
	5-р тэргүүлэх чиглэлийн хүрээнд: Хүрэх үр дүн 1:		Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар нийт 7 сая төгрөг зарцуулан үүлэнд нөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэсэн ба нийт 26 удаагийн гаргалт гарч 81 удаагийн харвалт хийсэн.					
	Хүрэх үр дүн 2:		Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнгийн 1 га талбайд мод тарьж, ногоон байгууламж байгуулсан. Амьдралт 90% -тай ургаж байна.					
Хүрэх үр дүн 3:		Хэрлэн сумын ногоон байгууламжийг услах зорилгоор шинээр гүн өрлийн худаг гаргасан. Одоогоор Чингис хотын ногоон байгууламжны усыг тус эх үүсвэрээс хангаж байна.						
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		Хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх шаардлагатай					
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		Хамтран ажиллах тал дээр бүх талууд сайн ажилласан.					
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		80%	2	-	-	-	90%	100%
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ		Нэгдсэн үнэлгээ					
	(ЗГХЭГ-ын үнэлгээ)		95%					

4.4. Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын жилийн үйл ажиллагааны тайлан 1997-2030 1 255

1. “Хэнтий аймгийн ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026” бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор энэ сарын 30-нд “Тогтвортой хөгжлийн боловсролын олимпиад”-ыг БСУГ, МСУТ, БОАЖГ хамтран зохион байгууллаа. Уг олимпиадад 13 сумын сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургууль, МСУТ-ийн нийт 32 сурагч, 20 багш оролцлоо. “Байгаль хамгаалах уламжлал” сэдэвт гар зураг, “Албан байгууллагын гадаад болон дотоод орчны үнэлгээ” сэдвээр бичил судалгааны ажлын илтгэлийг сурагчид, “Байгаль хамгаалах уламжлал” сэдвээр багш нар илтгэл тавилаа. Гар зургийн уралдаанд байгаль хамгаалах уламжлалт аргыг илэрхийлсэн агуулгатай, уриаг үгээр илэрхийлж, тайлбарлах ба багш нар байгаль хамгаалах уламжлал, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тусгасан нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулан хэлэлцүүлсэн байна. Багш нарын “Байгаль хамгаалах уламжлал” сэдэвт илтгэлээр нэгдүгээр байрыг Хэрлэн 1-р сургуулийн биологийн багш Д.Жимсээ, 2-р байрыг Бор-Өндөр Энхжин цэцэрлэгийн багш М.Адьяа, 3-р байрыг Хан Хэнтий цогцолбор сургуулийн багш Г.Цэгмид нар тус тус шалгарчээ.

“Байгаль хамгаалах уламжлал” сэдэвт зураг, “Байгууллагын гадаад, дотоод орчны үнэлгээ” бичил судалгааны ажлын илтгэлийн төрөлд Мөрөн сумын ЕБС-ийн сурагч Г.Мөнххэрлэн тэргүүлж, Батширээт сумын ЕБС-ийн сурагч Б.Энхтуул, Норовлин сумын ЕБС-ийн сурагч О.Цэлмүүн нар удааллаа.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархац нутаг нь хумигдаж, тоо толгой нь цөөрч устах аюулд орсон биологийн төрөл, зүйлүүдийн талаар мэдлэг, мэдээлэл олгох, байгаль хамгаалах үйлсэд сурагчдын оролцоог нэмэгдүүлэх, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах төлөвшил олгох зорилго бүхий “Улаан номыг хэн сайн мэдэх вэ?” танин мэдэхүйн уралдаант тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 2017 оны 05-р сарын 11-ний өдөр Хан Хэнтий цогцолбор сургууль дээр зохион байгууллаа.

Тэмцээнд Хэрлэн, Биндэр, Өмнөдэлгэр, Батноров сумдын ерөнхий боловсролын 7 сургуулийн 8 багийн 40 ахлах ангийн сурагч оролцсон.

1-р байр Хан хэнтий цогцолбор сургуулийн Хотон шувуу баг эзэлж БОАЖСайдын өргөмжлөл, 400000 төгрөгний мөнгөн шагнал,

2-р байр Хэрлэн 1-р сургууль Хувьсал баг эзэлж БОАЖСайдын өргөмжлөл ,300000 төгрөгний шагнал,

3-р байр Өмнөдэлгэр сумын Изал баг эзэлж БОАЖСайдын өргөмжлөл 200000 төгрөгний мөнгөн шагнал,

Тусгай байрыг Тэмүүжин цогцолбор сургууль Тэмжүүжин-1 баг эзэлж БОАЖСайдын өргөмжлөл ,100000 төгрөгний мөнгөн шагнал тус тус авсан.

Тэмцээнийг анх 2016 онд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын ивээл дор Улаанбаатар хотын 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд

амжилттай явуулж, оролцсон сурагчид, багш нар тус Улаан номд бүртгэгдсэн амьтан, ургамлын талаар сонирхолтой асуулт хариулт, жүжигчилсэн тоглолт хэлбэрээр явагддаг тэмцээн нь танин мэдэхүйн болон бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд өндөр ач холбогдолтой хэмээн үнэлж байв.

Улаан номыг хэн сайн мэдэх вэ? тэмцээн нь 2 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд энэ жилийн тэмцээн нь орон нутагт хийж байгаагаараа онцлог юм.

Улаан ном хэн сайн мэдэх вэ уралдаан Зураг-3



5.Ойн цэвэрлэгээ хөтөлбөр 2014-2020, №30

БОАЖСайдын 2016 оны 11 дүгээр сарын 23 ны өдрийн А/111 тушаалаар "2017 онд ойгоос мод бэлтгэх хязгаар батлах тухай" тушаалын 3 дугаар хавсралтаар 2017 онд Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд 888 гаталбайгаас 26640 м3 модыг бэлтгэхээр тусгагдсан. Уг тушаалыг үндэслэн 2016 оны 12 дугаар сарын 2 -ны өдрийн Аймгийн Иргэдтйн Төлөлөгчдийн хурлын 04 дүгээр тогтоолоор ой бүхий 8 суманд хуваарилан ойннөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр төлөвлөн ажилласан.

Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ой сумдын иргэд ойн нөхөрлөл ойн мэргэжлийн байгууллагууд 20085 м3 модыг цэвэрлгээний ажлаар бэлтгэсэн байна.

Ойн цэвэрлэгээ Зураг-4




1.5 БОАЖСайдтай аймгийн Засаг даргын 2017 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллана. Хүснэгт-5

1.6 Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт

1.Хэнтий аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөөг батлуулна

Хэнтий аймгийн нутагт ерөнхий агнуур зохион байгуулалт хийх /орон нутгийн төсвийн хөрөнгө 20,0 сая төгрөг/ ажлыг тендерт шалгарсан мэргэжлийн байгууллага болох "Эко үйлчилгээ" ТББайгууллага гэрээний дагуу гүйцэтгэсэн. Хэнтий аймгийн хөхтөн, шувуу, Хэрлэн голын загасны агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөө боловсруулагдсан ба Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр дэмжигдэж БОАЖЯаманд батлуулахаар уламжлаад байна.

Амьтдын тархац нутаг Зураг-5



2. Чингис хотын ногоон байгууламж, "Гоёлын мод" нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

Орон нутгийн төсвийн хөрөнгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар Чингис хотын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор 3 дугаар багт байрлах Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнгийн 1 га талбайд ногоон байгууламжийн ажлыг 5,8 сая төгрөгний төсөвт өртгөөр "Өндөрхаан хот тохижилт" ОНТҮГ гүйцэтгэлээ. Шинэс, хайлаас, нохойн хошуу, Өрөл, монос зэрэг нийт 1900 ш модыг гоёлын зориулалтаар тарьсан ба амьдралт 90,0 хувьтай ургаж байна. Дараа жилүүдийн арчилгаа, усалгааг "Өндөрхаан хот тохижилт" ОНТҮГ газар хариуцан ажиллана. Мөн дээрх цэцэрлэгт хүрээлэнд Чингис хотын ногоон байгууламжийн усалгаанд зориулж инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргав. Гүйцэтгэгчээр "Буян-Уул"ХХК ажилласан ба Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 14,2 сая төгрөгөөр санхүүжүүлээ.

Ногоон байгуулмжын усалгаанд зориулан шинээр гаргасан худаг Зураг-6



3. Дадал, Биндэр сумдын нутагт хийгдсэн түймрээс хамгаалах 175 км урттай шороон зурвасыг арчлан сэргээнэ.

Хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2013-2016 онд хилийн бүс нутаг болох Дадал, Биндэр сумдад түймрээс хамгаалах 175 км урттай, 10 м өргөнтэй харлуулсан шороон зурвас байгуулагдсан билээ. Дээрх зурвасыг 2017 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр дараах байдлаар арчлан сэргээж, зурвасыг өргөнийг нэмэгдүүлэхээр Хилийн 0287 дугаар ангитай 2017 оны 5 дугаар сарын 15 ны өдөр гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

2017 оны байгаль хамгаалах нөхөн сэргээх 20.0 сая.төгрөгийн зардлаар хил дамнасан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зурвасын өргөнийг нэмэгдүүлэх зорилгоор 10 м-ийн өргөнтэй нийт 86 км зурвасыг шинээр байгуулсан. БОАЖЯамны санхүүжилтээр 45 км зурвас шинээр байгуулан, 175 км урт, 10 м-ийн өргөнтэй түймрээс хамгалах шороон зурвасыг шатаах аргаар арчлан сэргээсэн.

Тус ажлыг 11 дүгээр сарын 08-ны өдөр БОАЖЯ-ны дэд сайд Ц.Батбаяр, БОАЖЯ-ны ойн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Ч.Чулуунбаатар, аймгийн БОАЖГ-ын дарга Б.Дархантөр мэргэжилтэн Б.Нямхатан, мэргэжилтэн Б.Санчир нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг харлуулсан шороон зурвасын гүйцэтгэлийн ажилтэй танилцан гүйцэтгэлийг хүлээн авсан.

Түймрээс хамгаалсан харлуулсан шороон зурвас Зураг-7



4. Хэрлэн сумын ундны усны эх үүсвэрийг хашиж хамгаална.

Чингис хотын хүн амын ундны усны эх үүсвэрийн хашаа барих ажилд ИТХ-ын 02-р тогтоолоор батлуулан, тендер сонгон шалгаруулалт Хэнтий -Ус ХХК шалгарч бетонон блокоор 1,8м өндөр, 900м урт хашааг барих ажлыг гүйцэтгэсэн. Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 23,5 сая төгрөг зарцуулаад байна.

Ундны усны эх үүсвэрийг хамгаалсан хашаа Зураг-8



5.Аймгийн хэмжээнд хөрсний бохирдлын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ

Аймгийн хэмжээний төв суурин газрын хөрсний бохирдлын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэхээр ИТХ-ын 2017 оны 02-р тогтоолоор 5,0 сая төгрөг тусгуулснаас, ИТХ-ын 56 тогтоолоор чиглэл өөрчлөгдөн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт үерийн улмаас учирсан хохирлыг арилгуулахаар "Өндөрхаан хот тохижилт" ОНӨҮГ-тай гэрээ байгуулж ариутгал хийгдсэн. Тус газар нь үерийн усаар бохирдсон Баянмөнх багийн 120, Булаг багийн 81 өрхийн 840тн хог хаягдлыг 10 ачааны машинаар тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хаясан. Мөн үерийн усаар бохирдсон газар болон сургууль цэцэрлэгийн 2.1га талбайд НISOP4:8 ариутгалын уусмалаар ариутгаж, халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

6.Байгаль хамгаалагчдыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана.

Байгаль хамгаалагчдыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ажлыг Аймгийн Засаг даргын тамгийн газрын даргын 2017 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн А/33 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан тендер сонгог шалгаруулалтаар "Хай ресус" ХХК шалгарч 2017 оны 11 дугаар сарын 24-ны өдөр № (БО/2017/26) гэрээ байгуулж 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Мотоцикл 12 ширхэг, Гар станц 5 ширхэг, Гар станцын уут 5 ширхэг, Машины станц 1 ширхэг, Цахилгаан бороохой 18 ширхэг, Мотоциклын бичиг баримт 12 ширхэг техник, тоног төхөөрөмж олгох нийлүүлэлтийг чанар болон тоо хэмжээг 100 хувийн үнэлгээтэйгээр хүлээн авлаа. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр Байгаль хамгаалагчдад нийт 8 сая төгрөгний 5 мотоциклийг олгоод байна.

Байгаль хамгаалагч нарт олгох техник, тоног төхөөрөмж Зураг-9



7.Хэрлэн голын эрэг дагуух орчиныг сайжруулах ажил, Хэрлэн сумын "Хутагт уул" орон нутгийн тусгай хамгаалалттай газарт тэмдэгжүүлэлтийн ажлыг хийнэ

Аймгийн ИТХ-ын 56 тогтоолоор чиглэл өөрчлөгдөн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт үерийн улмаас учирсан хохирлыг арилгуулахаар "Өндөрхаан хот тохижилт" ОНӨҮГ-тай гэрээ байгуулж ариутгал хийгдсэн.

8.Мянганы суут хүн хэмээн өргөмжлөгдсөн Чингис хааныг дотоод болон гадаадад сурталчлан таниулах "Чингис брэнд" хөтөлбөрийг батлуулах, тус хөтөлбөрийн хүрээнд Чингис хотод "Жуулчдын гудамж"-ийг байгуулах санаачилгыг дэмжинэ.

Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу Чингис брэнд хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 09-ний А/99 дугаарын захирамжаар батлууллаа.

Чингис брэнд Дэд хөтөлбөрийг 2017 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 17 дугаар хуралдаанаар батлуулсан.

9. Мартагдаж буй өв соёлыг сэргээх, дотоод, гадаадын жуулчдыг татах, нутгийн иргэдийг эдийн засгаар дэмжих зорилгоор "Гал шарын хурдан адууны баяр", "Ёохорын наадам", "Талын түмэн адууны баяр" зэрэг эвент арга хэмжээг зохион байгуулна.

Мартагдаж буй өв соёлыг сэргээх, дотоод, гадаадын жуулчдыг татах, нутгийн иргэдийг эдийн засгаар дэмжих зорилгоор "Гал шарын хурдан адууны баяр", "Ёохорын наадам", "Талын түмэн адууны баяр" зэрэг эвент арга хэмжээг зохион байгуулна.

Ёохорын наадам: Буриад Монголчуудын уламжлалт ардын тойрон бүжиг Ёохорыг судалж сурталчлах, уламжлал өвлүүлэх, хөгжүүлэх ажлыг орон нутгийн соёл урлаг, боловсролын байгууллага, уран бүтээлч, ардын авьяастнуудын дунд өрнүүлэн дэлгэрүүлж улмаар улсынхаа болон олон улсын түвшинд Ёохор бүжгийн эзлэх байр суурийг бэхжүүлэх зорилготой "Ёохор 2017" Ардын урлагийн наадам энэ сарын 17-ны өдөр Батширээт суманд 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа.

Тус наадмыг Батширээт сумын ИТХ, ЗДТГ, "Батширээт хөгжлийн сан" зохион байгуулж, Хэнтий аймгийн ЗДТГ ивээн тэтгэсэн бөгөөд аймгийн Засаг дарга Н.Ганбямба, ТЗУХ-ийн дарга Ж.Гантулга нар оролцлоо.

Ёохорын наадам Зураг-10



Тогорууны баяр: Хэнтий аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх гадаад дотоодын жуулчидад мэдээлэл олгох байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах зорилгоор "Тогорууны баяр-2017" аялал жуулчлалын эвент үйл ажиллагааг Олон улсын тогорууны сан, Зэрлэг амьтан хамгаалах төвөөс санаачлан БОАЖЯ, Биндэр сумын ЗДТГ, ИТХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран жил бүрийн 6 сард зохион байгуулдаг билээ. Энэхүү үйл ажиллагаа нь Монголд болон дэлхийн хэмжээнд ховордож байгаа Цэн тогоруу, мөн ус намгархаг газрын хамгааллын тухай нутгийн иргэдэд таниулах зорилготой юм. Дэлхий дээр 5 төрөлд хамаарах 15 зүйл тогоруу байдаг бөгөөд Монгол оронд нэг төрлийн 6 зүйл тогоруу байдаг билээ. Энэ жилийн Тогорууны баяр нь 2017 оны 06 дугаар сарын 13 ны өдөр Биндэр суманд зохион байгуулагдлаа.

Галшарын хурдан адууны баяр: Аймгийн Засаг даргын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "ГАЛШАР АДУУНЫ БАЯР – 2017" аялал жуулчлалын эвент арга хэмжээ Галшар адууг

үндэслэгч Их шинжээч, төр нийгмийн зүтгэлтэн Хардэл жанжин бэйс М.Пүрэвжавын хурдан хүлэг морьдоо уяж сойдог байсан халхын суут Шөрмөсөн чулуут довонд 07 сарын 26-27-ны өдөр зохион байгуулагдлаа. Монгол улсад адууны анхны үүлдэрээр Галшар адуугаа баталгаажуулж Галшар сум “Хоёр түмэн адуу”-тай болсон, Хардэл бэйсийн унага уяачдын холбооны 20 жилийн ойн баяраа Галшарын ард түмэн, уяачид хамтатган тэмдэглэсэн.

Хурдан адууны баяр Зураг-11



Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Талын түмэн адууны баяр-2017 наадам: Мөнх Харилцаа ТББайгууллагын санаачилсан “Талын Түмэн Адуу” өвлийн адууны эвент арга хэмжээ 4 дэх удаагаа 2017 оны 11 сарын 3, 4, 5-ний өдрүүдэд Хүлэг Боорчийн нутаг Батноров сумын Хөхүүрийн талд амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү арга хэмжээг Мөнх харилцаа төрийн бус байгууллага, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Батноров сумын Засаг даргын тамгын газар, Соёлын төв, Сэцэн ханы ордон музей хамтран зохион байгууллаа .

Талын түмэн адууны баяр Зураг-12



Зохион байгуулахдаа сумын төвийн 4-р багийн нутаг дэвсгэрт нутаглаж буй малчдын 2000 –аад адууг цуглуулж гадна дотноос мал болон адуучдыг оролцуулаагүй гаднаас ирж байгаа тээврийн хэрэгсэлд ариутгал хийж байснаараа өмнөх жилүүдээс онцлогтой байлаа. Талын түмэн адуу 2017 эвент арга хэмжээг гадаад дотоодын төлөөлөл үзэж сонирхосноос гадна Улсын их хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ ирж нээлтийн ажиллагаанд оролцсон юм.Тус арга хэмжээг зохион байгуулахад гадаад, дотоодын олон

байгууллага хувь хүмүүс дэмжиж ажилласан бөгөөд ерөнхий зохион байгуулагчаар Хэнтий аймгийн Батноров сумын ЗДТГ, Хөвсгөл нуурын баруун эргийн Арт88 ресорт нар ажилласан бөгөөд дэмжиж, хамтран ажилласан бусад байгууллагуудыг танилцуулахад Нийслэлийн Аялал Жуулчлалын Газар, Дэлхийн Зөн –Бор-Өндөр 2 ОУБ-ийн Хэнтий аймаг дахь салбар, Тэрхийн цагаан нуурын эрэгт байрлах Майхан Толгой жуулчны бааз, аялал жуулчлалын тур оператор Dream Mongolia болон Inspire Mongolia, Voajum Expeditions компаниуд болон Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сэцэн ханы ордон музей, Монголын Залуучуудын Холбоо, Хэнтий аймгийн мэргэжлийн гэрэл зургийн S studio зэрэг 20 байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд энэхүү эвент санхүүгийн хувьд бат суурьтай, төлөвлөсөн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах боломж бүрдсэн болно. Харин арга хэмжээний зохион байгуулалтын ар талд Батноров сумын засаг даргын тушаалаар байгуулагдсан 11 ажлын хэсгийн 50 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаа.Тус эвентийг 2017 оны 8 сараас гадаад, дотоодын олон сувгаар эвентийн тухай мэдээллийг эрчимтэй цацаж, тасралтгүй ажилласан нь үр шимээ өгч зорин ирэх гадаад, дотоодын үзэгчдийн тоо 3 өдрийн хугацаанд 1000 гаруйд хүрсэн байна. Үүнээс 250 гаруй буюу нийт оролцогчдын 20 гаруй хувь нь зорьж очиж мөнгө төлж үзсэн гадаад, дотоодын жуулчид байсан бөгөөд Герман, АНУ, Их Британи, Австрали, Польш, Франц, Хятад, Япон зэрэг 10 орчим орны жуулчид байв.

10.ИТМ-2017 аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд орон нутгаа сурталчилан оролцоно.

Монголын аялал жуулчлалын холбооноос БОАЖЯ-тай хамтран жил бүрийн хавар уламжлал болгон зохион байгуулдаг “Ай Ти Эм-2017” үзэсгэлэн Улаанбаатар хотноо Мишээл Экспогийн шинэ үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдлаа. 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд нийт 3 өдөр үргэлжилсэн тус үзэсгэлэн нь Монголын хамгийн том аялал жуулчлалын үзэсгэлэн төдийгүй, 21 аймгийн төлөөлөл хүрэлцэн ирж аймаг орон нутгийнхаа бүтээгдэхүүн, эвент арга хэмжээгээ сурталчлан танилцуулдагаас гадна аялал жуулчлалын бизнес эрхлэгчид шинэ бүтээгдэхүүнээ сурталчлах, борлуулах, түншлэлийн гэрээ хэлэлцээр хийх, гадаад, дотоодын аялал жуулчлалын салбарын судлаачдын семинарт оролцох зэрэг боломжоор хангагддаг билээ.

Хэнтий аймгийн хувьд 2009 оноос хойш аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр 9 дэх жилдээ энэхүү үзэсгэлэнд оролцож байна. Үзэсгэлэнд оролцоноор өөрийн аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг олон нийтэд сурталчилан танилцуулж, жилээс жилд туршлагжан талбай, зохион байгуулалт, тохижилт, үйл ажиллагаагаа өргөжүүлсээр ирсэн болно. Үзэсгэлэнд Хэнтий аймгийн нутгийн зөвлөлийн тэргүүн Улсын их хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал болон нутгийн зөвлөлийн гишүүд ирж өөрийн аймгийн үйл ажиллагаатай танилцан ирэх жиийн үзэсгэлэнд нутгийн зөвлөл дэмжин оролцохоо илэрхийллээ. Хэнтий аймгийн үзэсгэлэнг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Б.Баясгалан ахлан зохион байгуулсан. Энэ жил Батширээт-5, Биндэр-1, Дадал-1 нийт 3 сумын 7 жуулчны, Чингис хотод үйл ажиллагаа явуулдаг Эзэнт гүрэн зочид буудал оролцсон. Түүнчлэн аймгийн ХОХБ-ын хэлтэсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ, Биндэр, Дадал сумын удирдлагууд, Дадал сумын Байгаль орчны байцаагч, Онон Балжийн БЦГ-ын мэргэжилтэн, Баян-Адарга

сумын Хатадын өргөөний менежер нар ирж өөрийн аймгийн үзэсгэлэн болон бусад аймгийн туршлагатай танилцсан. 36м² талбайг түрээслэн авч Батширээт суманд зохион байгуулагддаг “Ёохор-2017” эвент, Биндэр суман зохион байгуулагддаг Тогорууны баярыг харуулж буриад ахуй, шувуудыг харуулж талбайг тохижуулсан үзэсгэлэнд оролцлоо.

ИТМ-2017 үзэсгэлэн Зураг-13



11. Байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, сум сууринг дэмжин шалгаруулна. Аймгийн Засаг даргын батлагдсан удирдамжийн дагуу Эко сум, төрийн болон аж ахуй нэгж байгуулагыг шалгаруулах уралдааныг аймгийн хэмжээнд зарлаад байна. Уг уралдаанаар эко 2 сум, эко 2 төрийн болон аж ахуй нэгж байгууллагыг шалгаруулна. Баян-Адарга сум, Баян-Овоо сум, Баянмөнх сум, Хэрлэн сумын 4-р цэцэрлэг шалгаруулалтанд оруулах тайлангаа ирүүлээд байна. 12-р сарын 22-нд шалгаруулалтыг хийнэ.

12. ЕБС-ийн багш, сурагчдын дунд "Тогтвортой хөгжлийн боловсрол"-ын олимпиадыг зохион байгуулна.


“Хэнтий аймгийн ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026” бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор энэ сарын 30-нд “Тогтвортой хөгжлийн боловсролын олимпиад”-ыг БСУГ, МСУТ, БОАЖГ хамтран зохион байгууллаа. Уг олимпиадад 13 сумын сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургууль, МСУТ-ийн нийт 32 сурагч, 20 багш оролцлоо. “Байгаль хамгаалах уламжлал” сэдэвт гар зураг, “Албан байгууллагын гадаад болон дотоод орчны үнэлгээ” сэдвээр бичил судалгааны ажлын илтгэлийг сурагчид, “Байгаль хамгаалах уламжлал” сэдвээр багш нар илтгэл тавилаа. Гар зургийн уралдаанд байгаль хамгаалах уламжлалт аргыг илэрхийлсэн агуулгатай, уриаг үгээр илэрхийлж, тайлбарлах ба багш нар байгаль хамгаалах уламжлал, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тусгасан нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулан хэлэлцүүлсэн байна. Багш нарын “Байгаль хамгаалах уламжлал” сэдэвт илтгэлээр нэгдүгээр байрыг Хэрлэн 1-р сургуулийн биологийн багш Д.Жимсээ, 2-р байрыг Бор-Өндөр Энхжин цэцэрлэгийн багш М.Адъяа, 3-р байрыг Хан Хэнтий цогцолбор сургуулийн багш Г.Цэгмид нар тус тус шалгарчээ.

“Байгаль хамгаалах уламжлал” сэдэвт зураг, “Байгууллагын гадаад, дотоод орчны үнэлгээ” бичил судалгааны ажлын илтгэлийн төрөлд Мөрөн сумын ЕБС-ийн сурагч Г.Мөнххэрлэн тэргүүлж, Батширээт сумын ЕБС-ийн сурагч Б.Энхтуул, Норовлин сумын ЕБС-ийн сурагч О.Цэлмүүн нар удааллаа.

13. Экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий 5-аас доошгүй газрыг орон нутгийн хамгаалалтанд авна.

Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага сумдын хил дамнансан “Хурх хүйтний хөндий” орчмын газрын 190332.9 га талбайг Улсын тусгай хамгаалаттай газрын байгалын нөөц газрын ангиллаар авах саналыг Аймгийн ИТХУрын дөрөвдүгнээр хуралдааны 02 дугаар тогтоолоож дэмжүүлж, Батширээт, Биндэр сумдын хил дамнансан “Гутайн даваа” орчмын газрын 39930.03 га талбайг Улсын тусгай хамгаалаттай газрын байгалын нөөц газрын ангиллаар авах саналыг Аймгийн ИТХУрын Тавьдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоож дэмжүүлж “Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлээд байна.

Улсын тусгай хамгаалалтанд авах газрууд Зураг-14



Мөрөн сумын “Зөөлөн” гэх газрын 7418.973 га талбайг Түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах, доройтсон орчныг нөхөн сэргээх зорилгоор Мөрөн сумын ИТХ-ын 02 дугаар тогтоолоор, “Өлзийт” орчмын газрын 2834.28 га талбайг Түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах, доройтсон орчныг нөхөн сэргээх зорилгоор Мөрөн сумын ИТХ ын 03 дугаар тогтоолоор, “Бүрээт” орчмын газрын 29301.233 га талбайг Байгалийн унаган төрх хадгалах зорилгоор Мөрөн сумын ИТХ-ын 04 дугаар тогтоолоор сумын хамгаалалтанд тус тус авч Ашигт малтмал, газрын тосны газрын кдастарын хэлтэст бүртгүүлэхээр хүргүүлээд байна.


14. Байгаль орчны салбарын албан хаагчдын зөвлөгөөн зохион байгуулна.

2017 оны 12 дугаар сард 18-19 нд Онон балжын байгалын цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Хэрлэн голын сав газрын захиргаа, сумдын байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагчдийг оролцуулан “Байгаль орчны салбар”-ын ажилтнуудын зөвлөгөөнийг зохион байгуулна. Уг арга хэмжээнд 90албан хаагч оролцож 15,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна.

15. Үүлдэнд нөлөөлөн, бороо оруулж хуурайшилт, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

Орон нутгийн төсвийн хөрөнгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 7.0 сая төгрөг зарцуулан цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлыг гүйцэтгэлээ. Нийт 26 удаагийн экспедиз гарч, 81 удаа үүлэнд нөлөөлж, 3 удаа газрын генератор ажиллуулсан. Тус үйл ажиллагаанд ой хээрийн түймрийг унтраах зорилгоор 8 удаа, газар тариалангийн бүсэд 12 удаа, отрын болон бэлчээрийн бүсэд 6 удаа тус тус тундас нэмэгдүүлж ажиллав.

Үүлэнд нөлөөлөх ажил Зураг-15



1.7 Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, ИТХ-ын хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2017 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРИЙН “ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” 01 ТООТ АЛБАН ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиудыг Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолын хэрэгжилт, техник багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангуулан ажиллах.

Хэнтий аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслүүд дараах үзүүлэлттэй байна.

Түймрээс хамгаалах багаж, хэрэгслийн жагсаалт Хүснэгт-7

№	Шаардагдах багаж хэрэгслийн нэр	Заагдсан хэмжээ	Бэлэн байгаа багаж хэрэгслийн тоо	Хувь
1	Холбооны хэрэгсэл	15	35	+20
2	Үлээгч аппарат	53	216	+163
3	Ус шүршигч	150	66	-84
4	Усны сав	23	34	+11
5	Цуравдагч	30	18	-12
6	Моторт хөрөө	30	30	0
7	Чиргүүл	8	23	+15
8	Галд тэсвэртэй хувцас	106	200	+94

Үүнээс гадна 1779 цохиур, 679 тросон шүүр, 320 хүрз, 127 сүх, 10-20 л цэвэр усны зөөврийн сав 40, мотопомп 12 байгаа ба нийт багаж хэрэгслийн нөөцийн бэлэн байдал болон хадгалалт хамгаалалтыг жил бүр аймгийн комисс газар дээр нь очиж шалган ажиллаж байна.

2. Хавар, намрын хуурайшилтын улирал 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд Цаг уурын орчны шинжилгээний газраас цаг агаарын мэдээлэл, сансрын хиймэл дагуулын мэдээгээр авсан ой хээрийн гал түймрийн голомт, тархалтын зураг, хуурайшилтын мэдээг Ойн тухай хуульд заасны дагуу /баяр амралтын өдрүүдэд/ шуурхай боловсруулан Онцгой байдлын газарт хүргүүлэх

-ИСС.mn цахим сайтанд хиймэл дагуулын сансрын зургийн мэдээллийг цаг уурын үндэсний төвөөс боловсруулан өдөрт 3-аас доошгүй удаа шинэчлэн гаргадаг ба үүнийг аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон нийт сумдууд үйл ажиллагаандаа тогтмол авч ашиглаж байна.

3. Ой хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй хуурайшилтын “аюултай”, нэн аюултай” зэрэгт хүрсэн үед Цаг уур орчны шинжилгээний газрын цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардлагатай техник тоног төхөөрөмж бүх төрлийн сумны нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих

-Орон нутгийн төсвийн хөрөнгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 2017 онд 5,0 сая төгрөгийг цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсний дагуу аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газартай гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

4. Ойн тухай хуульд заасны дагуу хавар, намрын хуурайшилтын улиралд ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах баялгийг ашиглах, аялал зугаалгаар явах, бусад үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах, холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хамтран хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах, хууль дүрэм, журмыг зөрчсөн аж ахуйн нэгж байгууллага ард иргэдэд авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 134 тоот албан бичгээр сумдад чиглэл өгсний дагуу ой бүхий 8 сумаас 7 суманд сумын Засаг даргын захирамжаар ойг хааж шийдвэр гарч ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах баялгийг ашиглах, аялал зугаалгаар явах, бусад үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарласан.

Ойг хаасан шийдвэр Хүснэгт-8

Д/д	Сумдын нэр	Сумын Засаг даргын захирамж	
		Он сар өдөр	Дугаар
1	Биндэр	2017-04-13	А/43
2	Батширээг	2017-04-11	А/43
3	Жаргалтхаан	2017-04-09	А/29
4	Дадал	2017-03-31	А/39
5	Цэнхэрмандал	2017-04-01	А/47
6	Өмнөдэлгэр	2017-04-28	А/64
7	Норовлин	2017-05-01	А/43

Захирамжийн хэрэгжилтэнд сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хяналт тавьж ажиллаж байна.

5. Ой хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр бүх шатны Засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудтай хамтран ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах

-Сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, ойн ангийн ойн мэргэжлийн байгууллага болон ойн нөхөрлөлүүдтэй байгуулсан мод бэлтгэх гэрээнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусган ажиллаж байна. Мөн ойн нөхөрлөлүүд эзэмшлийн талбайд түймрийн морин эргүүл хийж мэдээг нөхөрлөлийн холбоо болон сумын Засаг даргын тамгын газарт тогтмол мэдээлж ажиллаж байна.

6. Ой хээрийн гал түймрээс хамгаалах хамгаалалтын шороон болон ойн зурвасыг сэргээх, шинээр бий болгох, ойд цэвэрлэгээ хийх ажлыг орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах

-Хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2013-2016 онд хилийн бүс нутаг болох Дадал, Биндэр сумдад түймрээс хамгаалах 175 км урттай, 10 м өргөнтэй харлуулсан шороон зурвас байгуулагдсан билээ. Дээрх зурвасыг 2017 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр дараах байдлаар арчлан сэргээж, зурвасыг өргөнийг нэмэгдүүлэхээр Хилийн 0287 дугаар ангитай гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Түймрийн харлуулсан шороон зурвас Зураг-16



Хэнтий аймаг нь 2017 онд ойн цэвэрлэгээний ажлаар 3716 га талбайгаас 77480 м³ модыг цэвэрлэгээний ажлаар бэлтгэхээр хуваарилагдсан ба ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүд болон сумын иргэд ойд цэвэрлэгээ хийж байна. Одоогийн байдлаар 9975 м.куб модыг цэвэрлэгээний ажлаар бэлтгэсэн байгаа бөгөөд гүйцэтгэл 13 хувь байна. 7. Иргэд түймэрт өртөж нас барах, түлэгдэж гэмтэх, эд материалын их хэмжээний хохирол учирч байгаа тул сумдын Засаг даргатай хамтран иргэдийн оролцоотой, гал түймрээс хамгаалах зурвас татах, иргэдийн амь нас, эд хөрөнгийг түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, ой

хээрийн гал түймрийн үед ажиллах сургалт дадлагыг хавар намрын улиралд зохион байгуулж телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах

-Аймгийн Өндөрхаан телевизээр ой хээрийн түймрээс сэргийлэх шторк сэрэмжлүүлгийг 04-05 сард 2 сарын турш нэвтрүүлсэн. Мөн Хэнтий мэдээ сонинд ой хээрийн түймрээс түймрээс урьдчилан сэргийлэх мэдээллийг нийтлүүлсэн.

-Орон нутгийн төсвийн хөрөнгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 2,0 сая, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас 2,0 сая төгрөгийг тус тус зарцуулан Онцгой байдлын газартай гэрээ байгуулж түймрийн хуурайшилттай улиралд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 шуурхай бүлгийг ажиллуулсан.

-2017 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлын ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөрийн орлогын 40 хувь болох 50,2 сая төгрөгийг ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар төлөвлөн аймгийн ИТХ-аар батлуулж сумдад олголоо.

-Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран “Мод дагаж ус, ус дагаж амьдрал” аяныг Онон голын сав газарт өрнүүлж байгаа ба үүний хүрээнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зурагт хуудсыг хэвлэлтэнд өгөөд байна.

8. Аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг хийх ажлын удирдамжийн дагуу бүх сумдад үзлэг шалгалтыг явуулж ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж дүнг танилцуулах

-Хаврын хуурайшилттай улирал эхэлсэнтэй холбогдуулан Орон нутгийн төсвийн хөрөнгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар хамтран “АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА”-ын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Хэнтий аймгийн 18 сум, 5 тосгонд 4 дэхь удаагаа зохион байгуулж ажиллаа. Тус үзлэгээр сум, тосгодын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар хийсэн ажил болон сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, түймрийн 1,2,3-р ээлжийн бие бүрэлдэхүүн, машин техник болон түймэр унтраах багаж хэрэгсэлийн бэлэн байдлыг шалгаж дүгнэв. Дээрхи үйл ажиллагаанд Баянмөнх -90.15, Баянхутаг -92.15, Бор-Өндөр -92.3, Галшар -80.0, Дархан- 80.0, Дэлгэрхаан -92.1, Мөрөн- 85.65, Жаргалтхаан – 85.0, Өлзийт- 90.4, Хэрлэнбаян-Улаан- 82.5, Цэнхэрмандал- 90.4, Баян-Адрага -83.3, Баян-Овоо -96.8, Батноров -86.5, Батширээт -95.4, Биндэр- 95.8, Бэрх- 92.3, Гурванбаян- 87.0, Дадал- 97.9, Норовлин-95.4, Өмнөдэлгэр- 82.9 хувийн үнэлгээтэйгээр хангалттай дүгнэгдлээ.

1.8 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт байгаль орчны чиглэлээр тусгагдсан арга хэмжээний биелэлт, үр дүн Хүснэгт-9

**2.”Газар, газрын хэвлий, тусгай хамгаалалттай газар нутаг, байгаль
орчны ерөнхий үнэлгээ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг
хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ**

2.1 Орон нутгийн экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий газруудыг улс, аймаг, орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх

Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага сумдын хил дамансан “Хурх хүйтний хөндий” орчмын газрын 190332.9 га талбайг Улсын тусгай хамгаалалттай газрын байгалын нөөц газрын ангиллаар авах саналыг Аймгийн ИТХурын дөрөвдүгнээр хуралдааны 02 дугаар тогтоолоож дэмжүүлж, Батширээт, Биндэр сумдын хил дамансан “Гутайн даваа” орчмын газрын 39930.03 га талбайг Улсын тусгай хамгаалалттай газрын байгалын нөөц газрын ангиллаар авах саналыг Аймгийн ИТХурын Тавьдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоож дэмжүүлж “Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлээд байна. *Зураг-14*

Мөрөн сумын “Зөөлөн” гэх газрын 7418.973 га талбайг Түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах, доройтсон орчныг нөхөн сэргээх зорилгоор Мөрөн сумын ИТХ-ын 02 дугаар тогтоолоор, “Өлзийт” орчмын газрын 2834.28 га талбайг Түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах, доройтсон орчныг нөхөн сэргээх зорилгоор Мөрөн сумын ИТХ ын 03 дугаар тогтоолоор, “Бүрээт” орчмын газрын 29301.233 га талбайг Байгалийн унаган төрх хадгалах зорилгоор Мөрөн сумын ИТХ-ын 04 дугаар тогтоолоор сумын хамгаалалтанд тус тус авч Ашигт малтмал, газрын тосны газрын кдастарын хэлтэст бүртгүүлэхээр хүргүүлээд байна.

2.2 “Хэрлэн тооно” Улсын тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөг эхлүүлэх.

Дэлгэрхаан сумын “Хэрлэн тооно” Улсын тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа итвэхжүүлэх ажлыг ТНС олон улсын багуулагтай хамтран хэрэгжүүлж байна.

2.3 Аймгийн хамгаалалттай газар нутагт тэмдэгжүүлэлтийн ажил хийх

Хэрлэн сумын "Хутагт уул" орон нутгийн тусгай хамгаалалттай газарт тэмдэгжүүлэлтийн ажлыг хийхээр ИТХ-ын 2017 оны 02-р тогтоолоор 5,0 сая төгрөг тусгуулснаас, ИТХ-ын 56 тогтоолоор чиглэл өөрчлөгдөн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт үерийн улмаас учирсан хохирлыг арилгуулахаар" Өндөрхаан хот тохижилт" ОНӨҮГ-тай гэрээ байгуулж ариутгал хийгдсэн.

2.4 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг сайжруулах хамгаалалтын горим, дэглэмийг тогтоож, Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулсан байна.

1.2017 оны 4 сарын 12-13-ны өдөр Чингис хотод Тосон Хулстайн байгалийн нөөц газрын хамтын менежментийн зөвлөлийн хурал зохион байгуулагдсан. Энэхүү хуралд Хэнтий, Дорнод аймгийн БОАЖГазар, УЦУОШГазар, Дорнод хамгаалалтын захиргаа, Хэрлэн голын сав газрын захиргааны дарга, мэргэжилтнүүд, Монголын байгаль орчны иргэнийн зөвлөлийн Дорнод аймгийн зохицуулагч, Норовлин, Баян-Овоо, Баянтүмэн, Хөлөнбуйр, Цагаан-Овоо сумдын ИТХ-н дарга, Засаг дарга, байгаль хамгаалагчид, нөхөрлөлийн гишүүд, ТНС хөтөлбөрийн газрын зохицуулагч, мэргэжилтнүүд буюу нийт 49 хүн оролцлоо.

Менежментийн төлөвлөгөө хэлэлцэх үеэр Зураг-17



2.2017 оны 4 сарын 14-ны өдөр Чингис хотод Түмэнхаан-Шалзын орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамтын менежментийн зөвлөлийн хурал зохион байгуулагдлаа Энэхүү хуралд Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ MON/13/303 төслийн зохицуулагч, мэргэжилтнүүд, Биологийн хүрээлэнгийн эрдэмтэд, Хэнитй, Дорнод аймгийн БОАЖГазрын дарга, мэргэжилтнүүд, Дорнод УТХГазрын хамгаалалтын захиргааны төлөөлөл, Онон Балжийн УТХГазрын хамгаалалтын захиргааны төлөөлөл, Цагаан овоо, Баян-Уул, Норовлн сумын төлөөлөл буюу 32 оролцогч оролцсон.

3. 2017 оны 5 сарын 29-30-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Хурх тосгон, Биндэр суманд Хурх Хүйтний хөндийн орон нутгийн хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах анхан шатны хэлэлцүүлгийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран сумын ЗТДГазрын ажилчид болон нөхөрлөлийн гишүүд, иргэдийг хамруулан хийсэн. Уг хэлэлцүүлэгт нийт 100 орчим оролцогч оролцсон.

2.5 Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих

Аймгийн Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн удирдамжийн дагуу Батширээт сумын нутаг дэвсгэр Гутайн орд газарт үйл ажиллагаа явуулж буй “Ю-энд-Би” ХХК, “Айвуун тэс” ХХК, “Гутайн даваа” ХХК-иудад уурхайн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллаа.

“Гутайн даваа” ХХК:

Гутайн даваа орд газарт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Гутайн даваа” ХХК-ий хувьд сүүлийн 3-5 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй хамгаалалтын 3 ажилтан компаний төлөөлөл нэг иргэн талбай дээрээ байсан, босоо амыг бетондон тагласан байдалтай байлаа.

“Айвуун тэс” ХХК:

“Айвуун тэс” ХХК-ий хувьд 2010 онд

“Тол мөрний урсац бүрэлдэх эх,усан бүхий газрын хамгаалалтын бүс,ой сан бүхий газарт ашигт малтмал хайх,ашиглахыг хориглох тухай” хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл нь цуцлагдаж энэ хуулийн дагаж

мөрдөх хуулийн журманд өөрчлөлт орсноор 2016 онд ашиглалтын тусгай зөвшөөрлөө сэргээн авсан. Өнөөгийн байдлаар тус компани нь 17 ажилтантай, эксватор 4, ковш 2, угаах төхөөрөмж 1, ачааны 6 Нордвенз машинтайгаар дотоод овоолгоо угааж цаашид уулын ажлын төлөвлөгөөний дагуу үндсэн шороон ордод уулын ажил болон олборлолтын ажил явуулахаар ажиллаж байлаа. Уул уурхайн холбогдолтой бичиг баримтын бүрдэл сайн. 2017 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө БОАЖЯ-амаан дээр батлагдахаар хүлээгдэж /гарын үсэг дутуу/ байгаа талаар тус уурхайн менежер Л.Алтангэрэл танилцуулсан болно. Энэ талаар тус сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчид хугацаатай улсын байцаагчийн зөвлөмж өгөх үүрэг даалгавар өгч ажиллаа.

“Ю-энд-Би” ХХК:

Ю-энд-Би ХХК-ий хувьд 2016 оны 09 дүгээр сард 2 удаа хяналт шалгалт хийгдэж байсан ба шалгалтаар уулын ажлын холбогдолтой бичиг баримтын бүрдэл дутуу байсан учир тус сумын Засаг дарга, холбогдох мэргэжилтнүүд, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний хөдөлгөөний төлөөлөлүүд, иргэдийн төлөөлөл, тус компаний удирдлагыг оролцуулсан үүсээд байгаа асуудлын талаархи ярилцлагыг аймгийн Цагдаагийн газрын эдийн засгийн ахлах төлөөлөгчтэй хамтран зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч улсын байцаагчийн зөвлөмж өгч ажиллаж байсан болно. Гэвч тус компани нь улсын байцаагчийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй учир зөрчил арилгах хүртэл түр хугацаагаар үйл ажиллагааг нь зогсоож экологид учруулсан хохирлыг тооцуулж эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр Цагдаагийн газарт шилжүүлж байсан. Тус компани нь газар дээрээ 48 ажилтантай үүнээс 12 ажилтанг орон нутгаас авч ажлуулж байгаа, ковш 2, эксватор 4, угаах төхөөрөмж 1, ачааны 5 машинтайгаар уулын ажил явуулж байлаа.

Ю-Энд-Би ХХК-н талбай Зураг-18



Батширээт сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдөр 22/04/328/01 тоот 7 заалт бүхий хугацаатай улсын байцаагчийн албан шаардлагыг өгч биелэлтийг 2017 оны 06 дугаар сарын 14 –ний өдөр гаргаж ирүүлэхээр хүргүүлсэн байна. Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдөр ажлын хэсэг компаний захирал О.Батулгад танилцуулж улсын байцаагчийн албан шаардлагын хариу ирүүлээгүй, албан шаардлагад дурдагдсан зөрчлийг арилгаагүй тохиолдолд дараагийн

шатны арга хэмжээ авагдахыг танилцуулж хууль эрх зүй, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан. Мөн аймгийн засаг даргын 2017 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн хяналт шалгалт хийх удардамжын дагуу мэргэжлийн байгууллагатай хамтран Хэнтий аймгийн хэмжээнд уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжид 2017 оны 09 дугаар сарын 25-ны өдрөөс 10 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ. /Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1,0 сая төгрөг/

Ю энд Би” ХХК-ийн хууль бус үйл ажиллагаа явуулж, байгалийн нөөц баялагт их хэмжээний хохирол учруулж буй талаарх аймгийн мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 9/1134 тоот албан бичгээр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд уламжлаад байна.

Ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуй нэгжийн 14 төсөлд байгаль орчны ерөнхий үнэлгээ хийсэн. Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын А-05 дугаар тушаалаар Уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа "Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 4.1. дэх заалтанд /Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 2-р хавсралтын дагуу гаргаж, төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлнэ/ байдаг ба Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлийн ажлыг аймгийн Засаг даргын 2014 оны А/493 дугаар захирамжаар байгуулсан ажлийн хэсэг 5 аж ахуй нэгжийн ажилаад байна.

**3. “Ойн ашиглалт, хамгаалалт, ойн нөхөн сэргээлт, ногоон
байгууламжийг нэмэгдүүлэх” гэсэн байгууллагын стратегийн
зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ**

3.1 2017 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах, 2018 онд ойгоос бэлтгэх модны саналыг хүргүүлэх

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 12 дугаар сарын 02 ны өдрийн “2017 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” А/111 тушаалаар Хэнтий аймаг 101131 м.куб модыг бэлтгэхээр хувиарлагдсан. Уг тушаалыг үндэслэн аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Хэнтий аймгийн “2017 ойд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” 04 тоот тогтоолоор сум тус бүрээр хувиарлан баталсан.

Хэнтий аймгийн 2017 онд бэлтгэхээр батлагдсан модны хэмжээ, ойн орлогын хэмжээ Хүснэгт-9


№	Сумын нэр	Хэрэглээ, м3	Түлээ, м3	Нийт дүн	Ойн нөөцөөс орох орлого /мян, төг/
1	Батширээт	7048	11280	18328	50762,8
2	Баян-Адрага	1133	3380	4513	8235,5
3	Биндэр	6986	10038	17024	40380
4	Дадал	2590	11014	13604	23925
5	Жаргалтхаан	700	3414	4114	3640,9
6	Норовлин	2550	5364	7914	11042,3
7	Өмнөдэлгэр	4295	16909	21204	39624,9
8	Цэнхэрмандал	3650	10050	13700	19006,7
9	Дэлгэрхаан		700	700	600
10	Баянмөнх	3	27	30	
	Бүгд	28955	72176	101131	197218,1

2017 оны мод бэлтгэл болон ойн орлогын гүйцэтгэл Хүснэгт-10


/ 2017 оны 11 дугаар сарын 24 ны байдлаар/

№	Сумын нэр	Бэлтгэх модны хэмжээ, м3	Бэлтгэсэн модны хэмжээ, м3	Хувь	Төвлөрүүлэх нийт ойн орлого /мян төг/	Төвлөрсөн нийт орлого /мян төг/	Хувь
1	Батширээт	18328	3885	21,20	50762,8	28800,7	56,7
2	Биндэр	17024	5888	34,59	40380,0	28446,0	70,4
3	Дадал	13604	2725	20,03	23925,0	25682,0	107,3
4	Дэлгэрхаан	700		0,00	600,0		0,0
5	Цэнхэрмандал	13700	4653	33,96	19006,7	17185,0	90,4
6	Жаргалтхаан	4114	339	8,24	3640,9	1655,2	45,5
7	Норовлин	7914	3167	40,02	11042,3	11345,8	102,7
8	Баян-Адрага	4513	3153	69,86	8235,5	13497,1	163,9
9	Өмнөдэлгэр	21204	10420	49,14	39634,9	32251,4	81,4
10	Баянмөнх	30		0,00			
	Нийт дүн	101131	34230	33,85	197228,1	158863,2	80,5

Мод бэлтгэлийн гүйцэтгэл График-1



Ойн орлогын гүйцэтгэл График-2



Хэнтий аймгийн 2018 оны мод бэлтгэх саналыг сумын менежментийн төлөвлөгөө, ойн нөөцийн болон сумын бодит хэрэгцээг үндэслэн ой бүхий сумдын Засаг дарга, ИТХ-ын даргаар баталгаажуулж ирүүлсэн санлыг Ойн тухай хууль, Ойгоос мод бэлтгэх журмын 2.3-т зааснаар БОАЖЯ-д албан бичгээр хүргүүлсэн.

3.2 Сум болон сум дундын ойн ангийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, мэргэжил аргазүйгээр тасралтгүй хангах

Монгол Улсын Ойн тухай хууль, түүнтэй холбогдон гарсан дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор сум дундын ойн ангийн дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан.

Сум болон сум дундын ойн инженер, ойн техникч нарын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор орон нутаг болон төсөл хөтөлбөрөөс зохион байгуулсан ойн аж ахуйн арга хэмжээний 12 удаагийн сургалтанд хамруулсан.

3.3 Ойн нөхөрлөлийг чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулах

“Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх нь” GCP/MON/008/GFF төсөл нь Хэнтий аймгийн ой бүхий 8 сумын 26 ойн нөхөрлөлийн гишүүдийн чадавхижуулах сургалтыг зохион байгуулж байна. 2017 онд 26 ойн нөхөрлөлийн 250 гишүүдэд:

Ойн 1,2 дугаар насны ангийн ойд гэрэлжүүлэх, тохируулах хэлбэрийн ажлын сургалт

Ойн хөрөөчны сургалт 2 удаа

Компьютерийн анхан шатны сургалт 2 удаа

Санхүүгийн анхан шатны сургалт

Ойн хөнөөлт шавьж таних арга зүй, тэмцэх ажлын сургалт 2 удаа нийт 9 удаагийн сургалт хий нөхөрлөлийн гишүүдийг ойн аж ахуйн арга хэмжээ хэрэгжүүлэх мэдлэг боловсрол олгосон байна.

Нөхөрлөлийг чадавхжуулах сургалт Зураг-19



Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөүүдийн 2 дугаар чуулган:

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Улаанбаатар хотноо 4 дүгээр сарын 20, 21 -ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөүүдийн Үндэсний 2 дугаар чуулган”-нд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Ганбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Б.Дархантөр, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны мэргэжилтэн Э.Батсайхан, мэргэжилтэн Б.Гүрсүрэн, жолооч Б.Соронзонболд нарын бүрэлдэхүүнтэй оролцлоо.

“Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөүүдийн Үндэсний 2 дугаар чуулган”-ны хүрээнд Сүхбаатарын талбай дээр зохион байгуулсан “Экологид ээлтэй бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаанд Хэнтий аймгийн 6 сумын 20 нөхөрлөлийн 23 гишүүдийн ойн цэвэрлэгээний модоор хийсэн гэрийн мод, модон аяга, таваг, тэвш, шанага, ширээ, сандал, бэлэг дурсгалын битүү мод, ваар сав, цэцгийн тавиур, үйсээр хийсэн сав, уран модон таваг, түлхүүрийн оосор зэрэг бэлэг дурсгал, ахуйн хэрэгцээний зүйлс мөн савалсан цөцгий, байгалийн жимс, жимсгэнэ, эмийн ургамал, эсгий урлал зэрэг 20-иод нэр төрлийн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаанд оролцож нийт 2.800.000 төгрөгийн борлуулалт хийсэн.

Улсын хэмжээнд зохион байгуулсан “Экологид ээлтэй бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаанд мод, модны үндэс ашиглан хийсэн шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулахад 1 дүгээр байранд Дадал сумын Амирлангуй нөхөрлөлийн гишүүн Ц.Баярсайханы бүтээл шалгарч 1.500.000 төгрөг, цахилгаан үүсгүүр, 3 дугаар байранд Норовлин сумын Бэрх нөхөрлөлийн гишүүн С.Туулын бүтээл шалгарч 800.000 төгрөг, модны харуул зэрэг мөнгөн болон тоног төхөөрөмжөөр шагнагдсан бол аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нөхөрлөл, нөхөрлөлийн гишүүдээ амжилтай зохион байгуулж оролцуулсан байгууллагын шагналаар шагнагдлаа.

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөүүдийн 2 дугаар чуулган Зураг-20



3.4 Хэнтий аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах

Хэнтий аймгийн ойн санд 2013 онд ойн зохион байгуулалтын ажил хийгдсэнтэй холбогдуулан аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг 2016 оны байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас тендерт шалгарсан Нью грийн форест ХХК нь 13,250,0 мян.төг –ийн төсөвт өртөгөөр гүйцэтгэсэн.

Хэнтий аймгийн 2017-2026 онд хэрэгжүүлэх ойн менежментийн төлөвлөгөө БОАЖЯ-ны дэргэдэх ойн нөөцийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хурлаар хэлэлцэн баталсан.

Ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ойн аж ахуйн арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төсөвийг аймгийн ИТХ-аар хэлэцүүлэн батлуулан ажилласан.

3.5 Шинээр батлагдсан ойгоос мод бэлтгэх журмыг ой бүхий сумдад сурталчлах зөвлөгөөн зохион байгуулах

Хэнтий аймгийн ой бүхий Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Дадал, Норолин сумдын ИТХ, ЗДТГ, сум болон сум дундын ойн ангиас хамтран зохион байгуулсан “Ойн хуулийг таниулах, ойн менежментийг сайжруулахад талуудын оролцоо” сэдэвт сум бүрт зохион байгуулсан зөвлөгөөнд Ойн албаны дарга, ой, ургамлын ашиглалт хамгаалалт хариуцсан мэргэжилтэн нар 2017 оны 2 дугаар сарын 6 –ны өдрөөс 2 дугаар сарын 12 -ний өдрүүдэд оролцсон.

Уг зохион байгуулсан зөвлөгөөнд Ойн албанаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 12 дугаар сарын 13 ны өдрийн А/133 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ойгоос мод бэлтгэх журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Бэлтгэх модны санал ирүүлэх хүснэгтийн загвар”, 3 дугаар хавсралтаар батлагдсан “Мод бэлтгэх гэрээний загвар”, 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Мод тээвэрлэх хяналтын хуудасны загвар”, 5 дугаар хавсралтаар батлагдсан “Ойгоос мод бэлтгэх эхлэл, төгсгөлийн актын загвар” 6 дугаар хавсралтаар батлагдсан “Мод бэлтгэх технологийн картын загвар” хавсралтуудын танилцуулага, ОББЦГ-ын захиргаанаас 2016 оны үйл ажиллагааны тайлан, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь зүүн бүсийн салбар, аймгийн БОАЖГ-аас хамтран зохион байгуулж буй Мод дагаж ус-Ус дагаж амьдрал аяны танилцуулага, Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, ойн тогтвортой ойн менежмент, нүүстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн Хэнтий аймаг дахь зохицуулагч З.Ууганбаяр Төслийн үйл ажиллагаа, 2017 оны төлөвлөгөө зэрэг илтгэл, мэдээ мэдээлэлийг зөвлөгөөнд оролцсон сумын удирдлагууд, иргэд, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудад дэлгэрэнгүй байдлаар танилцуулсан.

Шинээр гарсан “Ойгоос мод мод бэлтгэх журам”-ын танилцуулгатай холбоотой түгээмэл тавигдсан асуултууд:

Шинээр гарсан “Ойгоос мод мод бэлтгэх журам”-д уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид шаардлагатай модоо ямар хэлбэрээр авах вэ?

Багийн иргэд ахуйн хэрэгцээний байшингийн модоо авахдаа багийн Засаг даргад хэрхэн өргөдөл гаргах вэ?, Нөхөн сэргээлтийг ямар байдлаар хийх вэ?

Ахуйн хэрэгцээний байшингийн мод авахад талбай тусгаарлаж авах уу. Ойн мэргэжлийн байгууллагаар мод унгаалгах хөлс нь хэдэн төгрөг байх вэ?

Ой хээрийн хуурайшилтийн үед ойд зорчих, мод бэлтгэх хөдөлгөөнийг ямар тушаал шийдвэрээр түр хориглодог вэ?

“Биндэр-ой” СДОА нь талбай тусгаарлалт хийхдээ 1 га-ийн нөөцийг 25 м³ –ээр бодож талбай тусгаарлалтын материал дээр гаргаж байгаа нь зөв үү

Иргэдийн ахуйн хэрэгцээний түлээ, байшингийн модонд, гарал үүслийн гэрчилгээ олгогдох уу ?

Нөхөрлөлийн эзэмшилийн талбайгаас ойн дагалт баялаг ашиглаж байгаа иргэдээс хэрхэн хураамж авах боломжтой вэ.

“Ойгоос мод бэлтгэх журам”-д малын хашаа, өвөлжөөний шургаагийг ямар байдлаар авах вэ.

Биндэр сумын Зүүн манхаадай гэх газарт гарсан Бургасны хортонтой энэ жил тэмцэлийн ажил хийгдэх үү зэрэг холбоотой асуултанд Ойн тухай хуулийн 17 дугаар зүйл, “Ойгоос мод бэлтгэх журам”-ын 2,3 дугаар хэсгийг дэлгэрэнгүй тайлбарлан, асуусан асуултанд тухайн бүрт хариулт өгсөн.

Зөвлөгөөнд ОББЦГ, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь зүүн бүсийн салбар, “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, ойн тогтвортой ойн менежмент, нүүстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн Хэнтий аймаг дахь зохицуулагч зэрэг байгуулага, байгууллагын төлөөлөлтэй хамтран мэдээлэл солилцон, хамтран ажилласан.

“Ойн хуулийг таниулах, ойн менежментийг сайжруулахад талуудын оролцоо” сэдэвт зөвлөгөөнд ой сумдын иргэн, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудын 354 хүн оролцож ойн тухай хууль, бусад дүрэм журмын мэдээ мэдээлэлээр хангагдсан.

Ойн зөвлөгөөн Зураг-2



3.6 Хуш модны самрын ургалтын үед хяналтын постуудыг ажиллуулж, их ургацтай газруудад хяналтыг хүч нэмэгдүүлэн ажиллана.

Хуш модны самрын хяналтын цэгийг аймгийн ОБГ, Цагдаагийн газар, Хан Хэнтий ТХГ-н захиргаа, БОАЖГазар сумын ЗДТГ хамтран Өмнөдэлгэр сумын Их даваа”, Сайханы гол”, Батширээт сумын Шар өндөрийн байц, Эг нэртэй нийт 4 газарт 2017 оны 9-р сарын 17-с 10-р сарын 8 нд 21 хоногийн хугацаатайгаар ажлуулсан. Тус хугацаанд нийт 101 машин 534 хүн постоор өнгөрч, нийт 2865000 төгрөгний эрхийн бичиг бичсэн байна. Постонд гарч байхад хэрэг зөрчил гараагүй байна. 2017.12.5 –ны өдрөөс дээрх газарт хяналтын цэгүүдийг дахин ажиллуулж эхлээд байна.

Хяналт шалгалтын пост Зураг-22



Өмнөдэлгэр, Батширээт сумдууд тус бүр 600 тн самрын гэрээг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахаар байгуулж, орон нутгийн төсөвт нийт 281,5 сая төгрөг төвлөрүүлээд байна.

Самрын орлого Хүснэгт-11

№	Аж ахуй нэгж байгууллагын нэр	Гэрээ хийсэн			Гэрээний дагуу бэлтгэсэн самар		
		Он сар өдөр	Бэлтгэх хэмжээ тн	Төлөх мөнгөн дүн /мян,төг/	Бэлтгэсэн хэмжээ тн	Төлсөн мөнгө мян.төг	Төлсөн он сар өдөр
1	Буман боргоцой ХХК-ОМБ	2017.09.13	300 тн	240000,0	60	48000,0	2017.9.18
2	ЭН ЭЙЧ ТРЕЙД ХХК-ОМБ	2017.09.12	300 тн	240000,0	50	40000,0	2017.9.25
					50,5	40400,0	2017.10.27
3	Ахуйн хэрэглээ				2,25	1125,0	
			600	480000,0	150	129525,0	

Самрын орлого Хүснэгт-12

№	ААН-ын нэр	Гэрээ хийсэн тонн	Төлөх ёстой орлого	Төлсөн үнэ
1	“Альянс Минерал”ХХК	100	80000000	44000000
2	Баялагт хос эрдэнэ ХХК	100	80000000	16000000
3	Тайхарын цуурай ХХК	100	80000000	24000000
4	Эн эйч трейд ХХК	100	80000000	8000000
5	Буман борогцой ХХК	100	80000000	30000000
6	Мофко групп	100	80000000	30000000
7	Нийт дун	600	480000000	152000000

3.7 Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, техник технологийн түвшинд үзлэг хийж магадлан итгэмжлэлд хамрагдаж бэлтгэлийг хангуулах

2017 оны 10 дугаар сарын 06- ны өдөр “Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл” ТББ-тай хамтран Биндэр суманд “Ойн магадлан итгэмжлэл” сэдэвт сургалт семинарыг зохион байгуулсан. Сургалтанд Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж буй нийт 27 ойн мэргэжлийн байгууллагыг бүрэн хамруулж ойн магадлан итгэмжлэлийн тухай ойлголтыг түгээн дэлгэрүүлж “Ойн магадлан” итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажлыг хангасан.

Ойн мэргэжлийн байгууллагад үзлэг хийв. Зураг-23



3.8 Хортны тархалтын судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийх

2017 оны ойн хөнөлт шавьжийн судалгаагаар голомттой талбайн хэмжээ 66,0 мянган га талбай байсан ба БОАЖЯ-наас улсын төсвийн хөрөнгийн 515.8 сая төгрөгийн санхүүжилтээр Хэнтий аймгийн Дадал сумын ойн сангийн 9570 га талбайд агаарын хөлгөөр бактерийн бэлдмэл ашиглан Сибирийн хүр эрвээхэйн голомттой газар тэмцэлийн ажлыг 76,1 хувийн үр дүнтэйгээр хийж гүйцэтгэлээ.

Ойн хортонтой тэмцэх ажил Зураг-24



Мөн БХНСЗ-ын 3.5 сая төгрөгөөр Биндэр сумын нутагт 387 га талбайд тэмцлийн ажлыг химийн хор ашиглан, үүргийн шүршигч ашиглан хийж гүйцэтгэв. Гүйцэтгэгчээр “Биндэр Ой” СДОАнги ажилласан ба 82.0 хувийн үр дүнтэй ажиллав.

3.9 Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулан ажиллана.

Шуурхай бүлэг:

Хаврын хуурайшилт ихсэж байгаатай холбогдуулан 2017 оны Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шуурхай бүлгийг Байгаль орчин аялал жуулчлалын газартай байгуулсан гэрээг үндэслэн 2017 оны 04-р сарын 11-ны өдөр Онцгой байдлын газрын даргын 2017 оны А/29 дүгээр тушаалаар Биндэр суманд, Дэлхийн Байгаль хагаалах сангийн дэмжлэгтэйгээр Бэрх тосгон, Дадал, Норовлин, Баян-Овоо, Батноров сумдад байршин ажиллаж, төв болон хөдөөгийн малчин айл өрх, ард иргэдэд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх хор уршгийг арилгах талаар мэдлэг олгож, заавар зөвлөгөө өгөх 22 бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажилласан.

Ой хээрийн түймрийн ажлын хэсэг Зураг-25



Сумын төвийн аж ахуйн нэгж байгууллага, айл өрхөд гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, 332 иргэнд Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 онд шинэчлэн

найруулагдсантай холбогдуулан хууль таниулах, болзошгүй гамшгаас өөрийгөө болон бусдыг хамгаалах, “ Гал унтраах багаж хэрэгслийн ажиллах зарчим, техникийн үзүүлэлт”, “Гамшгийн үед холбоо зарлан мэдээллийг дамжуулах, хүлээн авах журам”, “Нэрвэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх арга ажиллагаа”, “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” зэрэг сэдвүүдээр сургалт явуулж, гал унтраагуураар гал унтраах дадлага сургууль хийлгэсэн.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа Зураг-26



Сумын багуудын малчин айл өрхүүдээр явж ой хээрийн түймэр, гамшиг ослын аюулаас урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж баталгаа гаруулан Биндэр сумын төвөөс гарах, орох төв замд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 2 ш самбар байршуулсан.

Шуурхай бүлгийг ой хээрийн түймрийн эрсдэл бүхий сумдад ажиллуулаж төвийн болон хөдөгийн малчин айл өрхүүдэд 8571 ширхэг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж анхааруулга тарааж, гал түймэр гарч болзошгүй 92 зөрчлийг газар дээр нь арилгуулан ажилласан байна.

Аймгийн Засаг даргын нэрэмжит ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлын үзлэг: Хаврын хуурайшилттай улирал эхэлсэнтэй холбогдуулан Орон нутгийн төсвийн хөрөнгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар хамтран “АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА”-ын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Хэнтий аймгийн 18 сум, 5 тосгонд 4 дэхь удаагаа зохион байгуулж ажиллаа. Тус үзлэгээр сум, тосгодын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар хийсэн ажил болон сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, түймрийн 1,2,3-р ээлжийн бие бүрэлдэхүүн, машин техник болон түймэр унтраах багаж хэрэгслийн бэлэн байдлыг шалгаж дүгнэв. Дээрхи үйл ажиллагаанд Баянмөнх -90.15, Баянхутаг -92.15, Бор-Өндөр -92.3, Галшар -80.0, Дархан- 80.0, Дэлгэрхаан -92.1, Мөрөн- 85.65, Жаргалтхаан – 85.0, Өлзийт- 90.4, Хэрлэнбаян-Улаан- 82.5, Цэнхэрмандал- 90.4, Баян-Адрага -83.3, Баян-Овоо -96.8, Батноров -86.5, Батширээт -95.4, Биндэр- 95.8, Бэрх- 92.3, Гурванбаян-87.0, Дадал- 97.9, Норовлин-95.4, Өмнөдэлгэр- 82.9 хувийн үнэлгээтэйгээр хангалттай дүгнэгдлээ.

3.10 2017 оны төлөвлөгөөт ойжуулалтыг бүрэн хийлгэх

Орон нутгийн төсвийн хөрөнгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар Норовлин сумын Баянгол нэртэй газрын 10 га талбайд навчит модоор ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Гүйцэтгэгчээр “Биндэр-Ой” СДОА ажилласан бөгөөд ажлыг нийт 6950,0 мян/төг -өөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ба 2017 онд урьдчилгаа төлбөр 3500,0 мян/төг –өөр санхүүжүүлсэн ба 2018 онд гүйцэтгэлийн дүнгээр үлдэгдэл санхүүжилтийг олгоно. Мөн ААН, Ойн ангиудын өөрийн хөрөнгөөр нийт 58,6 га талбайд ойжуулалт хийгдсэн байна. Ойжуулалт хийгдсэн жагсаалтыг хүснэгтээр үзүүлэв.

3.11 Ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлж, ногоон байгууламжийн тооллогыг зохион байгуулна.

Орон нутгийн төсвийн хөрөнгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар Чингис хотын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор 3 дугаар багт байрлах Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнгийн 1 га талбайд ногоон байгууламжийн ажлыг 5,8 сая төгрөгний төсөвт өртгөөр “Өндөрхаан хот тохижилт” ОНТҮГ гүйцэтгэлээ. Шинэс, хайлаас, нохойн хошуу, Өрөл, монос зэрэг нийт 1900 ш модыг гоёлын зориулалтаар тарьсан ба амьдралт 90,0 хувьтай ургаж байна. Дараа жилүүдийн арчилгаа, усалгааг “Өндөрхаан хот тохижилт” ОНТҮГ газар хариуцан ажиллана.

3.14 Онон голын сав газарт ойн талбайг нэмэгдүүлэх компаниг ажил өрнүүлээ.

Онон голын сав газрын ойг хамгаалах, ойн доройтлыг бууруулах, байгальд ээлтэй ногоон бизнесийг дэмжих замаар нутгийн иргэдийн амжиргааны эх үүсвэрийг нэмэгдүүлж ногоон хөгжлийн загвар бүс нутаг болгох зорилгоор Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн Жижиг төслийн хөтөлбөр, Онон-Балжийн БЦГ-ын Хамгаалалтын захиргаа, Хэнтий аймгийн БОГ зэрэг байгууллагууд удирдан зохион байгуулахаас гадна сум дундын ойн ангиуд, Онон голын нөхөрлөлүүдийн нэгдсэн холбоо ТББ, нөхөрлөлүүд, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Дадал, Баян-Овоо, Батноров, Норовлин сумдын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, Ойн мэргэжлийн байгууллагууд хамтран “МОД ДАГАЖ УС – УС ДАГАЖ АМЬДРАЛ” аяныг зохион байгуулж байна. Тус аян нь 2017-2020 хугацаанд явагдана.

Ойжуулалтын ажил

2017 оны 5 дугаар сарын 6-ны өдөр МОД ДАГАЖ УС-УС ДАГАЖ АМЬДРАЛ аяны хүрээнд Дадал сумын Устай Цээнэтэй хэмээх газарт 5 га талбайд ойжуулалтын ажлыг Хэнтий аймгийн БОГ, ОББЦГ-ын хамгаалалтын захиргаа, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Биндэр сум дундын ойн анги, тус сумын ИТХ, ЗДТГ-ууд хамтран зохион байгууллаа. Энэ үйл

ажиллагаанд ААН, албан байгууллага, нөхөрлөлийн гишүүд зохион байгуулагчид гээд нийт 150 гаруй хүн оролцож 22750ш суулгацыг тарисан. Уг үйл ажиллагаа нь сав газрын хэмжээнд хамгийн анхны бүх нийтээрээ ойжуулалт хийж байгаа мөн хамгийн анхны удаа ойжуулалтын ажилд хөрш зэргэлдээ сумынхаа үйл явдал болов. Ийнхүү хаврын тарилтаар нийт 11500 ширхэг тарьцыг 5 га талбайд байгууллага тус бүрт хувиарлан өгсөн бөгөөд байгууллагууд намрын тарилтаар нийт 5000 ш тарьц нэмж тарив. Мөн Баян-Адрага сумын Дуурлиг нарс нэртэй газарт намрын тарилтаар 2,5 га талбайд шан татаж нийт 6250 тарьцыг бүх нийтийн оролцоотойгоор тарьж ойжуулалтын ажлыг хийлээ. Дээрх ойжуулалтанд таригдсан тарьцнууд нь зохион байгуулагч байгууллагуудын хандиваар бүрдсэн болно.

Аяны нээлт, “Өрх бүр жимсний аж ахуйтан болцгооё”

Аяны нээлтийн арга хэмжээг 2017 оны 5-р сарын 06-ны өдөр Хэнтий аймгийн Дадал эхлэн Өмнөдэлгэр, Батширээт, баян-Адрага, Биндэр, Дадал, Норовлин, Баян-Овоо, Дорнод аймгийн Баян-Уул сумдад тус тус зохион байгууллаа. Нээлтийн арга хэмжээний хүрээнд сумдын удирдлагууд болон 2016 онд “Өрх бүр жимсний аж ахуйтан болцгооё” аянд хамрагдан жимсний мод авсан өрхүүдийн төлөөлөлтэй уулзаж өмнөх жилийн ажлаа дүгнэхээс гадна энэ жилийнхээ аяны зорилго зорилтыг танилцуулсан. Мөн өмнөх жилийн аянд хамрагдсан 305 өрхөөс хамгийн сайн жимсний модыг ургуулсан, мөн цаашид жимсний аж ахуйтан болох хүсэл эрмэлзэлтэй 78 өрхийг сонгон өрх тус бүрт үхрийн нүдний 10 сулгацыг зохион байгуулагчид өөрсдтэй нь хамтран эзэмшлийн хашаанд тариалж, тайралтыг нь хийж, арга зүйн зөвлөгөө өгч дадлага сургалтыг хослуулан ажиллахаас гадна тэдэнтэй хамтран ажиллах гэрээг байгууллаа.

“Мод дагаж ус- Ус дагаж амьдрал” аяны 2017 оны ажлын төлөвлөгөөнд иргэдээс санал авах.

“Ойн менежментийг сайжруулахад талуудын оролцоо” сэдэвт уулзалт 2017 оны 2 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд Хэнтий аймгийн Биндэр, Баян-Адрага, Норовлин, Дадал сумдад тус тус зохион байгуулагдсан. Сум болгоны уулзалтад оролцогчидод “Мод дагаж ус-Ус дагаж амьдрал” аяны уриа, зорилго, чиглэлийг танилцуулж, оролцогч талуудаас санал авч, тэдгээрээс уриалга гаргуулан ажиллалаа. Уулзалт зохион байгуулагдсан сумдын иргэдийн анхаарлыг татаж, санааг нь зовоож буй асуудлуудыг энэхүү аяныг хэрэгжих хугацаанд уриалга болгож бүх талууд хамтран гүйцэтгэж, баримтлахаар боллоо. Мөн 2016 онд зохион байгуулагдсан Дадал сумын ойн талуудын уулзалтнаас гарсан Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг иргэдэд танилцуулсан.

Мэдлэг хандлагын судалгаа

Онон голын сав газрын сумдын иргэдээс мэдлэг хандлага, дадал заншлын судалгааг 2017 оны 6 сарын 3-наас 6-ны өдрүүдэд нийт 552 иргэнээс авч судалгааг нэгтгэж танилцуулсан.

Ногоон хөгжлийн загвар сум болгох анхны хэлэлцүүлэг

Ногоон хөгжлийн загвар сум болгох анхны хэлэлцүүлгийг Хэнтий аймгийн Дадал сумын ИТХ, ЗДТГ-аас санаачилсны дагуу Хэнтий аймгийн ЗДТГ, БОАЖГ болон Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн бусад талуудтай хамтран 2017 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр тус суманд зохион байгуулсан. Анхны хэлэлцүүлгийн зорилго нь “Хэнтий аймгийн ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026” урт хугацааны бодлогын баримт бичгийн хүрээнд ногоон хөгжлийн талаарх ойлголтыг Дадал сумын холбогдох хүмүүст өгөх, тус сумыг ногоон хөгжлийн загвар сум болгоход чиглэсэн бодитоор хэрэгжүүлэхүйц үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлохоор төрийн болон төсөвт байгууллагууд, иргэдийн төлөөллийн нийт 44 хүн оролцсон.

Онон голын сав газарт ойн талбайг нэмэгдүүлэх компани-ажил Зураг-27



4.”Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт”гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ

4.1. Ус ашиглалтын үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд:

Аймгийн хэмжээнд ус ашиглагч томоохон уул уурхайн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг ажиллаж, нийт 12 уул уурхайн аж ахуйн нэгжид зөвлөн туслах зорилгоор заавар зөвлөмж өгч ажилласан. Энэ жилд нийт 16 сумын 30 гаруй иргэн, ААН ус ашиглах үйл ажиллагаа явуулж, усны нөөц ашигласны төлбөрт 711,8 сая төгрөг төвлөрүүлсэн.

4.2. Усны нөөцийн хамгаалалтын ажлыг сайжуулах ажлын хүрээнд:

Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалд усны нөөцийг хамгаалах зорилгоор PUROFLO брэндийн ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмжийг Бор-Өндөр сумын Нархан цэцэрлэгт суурилуулаад байна.

Аймгийн хэмжээнд нийт 8 сумдын 17 булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд Жаргалтхаан сум Хааны булаг, Батноров сумын “Ардын хөв”-ийг тэтгэгч булаг, Хэрлэн сум Нарангийн булаг, Галшар сум Хөөврийн бүрдний эх, Бор-Өндөр сум Далантүрүүний рашаан, Норовлин сум Цагаан хошууны булаг, Батширээт сум Бэлийн булаг, Биндэр сум 10 булгийн эхийг тус тус хашиж, ундаргыг малын хөлд дарагдахаас сэргийлэн ажилласан.

5.”Амьтан ашиглалт, тоо толгойг тогтоох, агнуурын бүсүүдийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ

5.1 Амьтны нөөцийн ашиглалтын хүрээнд

2017 оны 2-р сарын 2-ний өдрийн аймгийн ИТХ-н дөрөвдүгээр хуралдааны 01-р тогтоолоор аймгийн хэмжээнд 110 толгой цагаан зээр, 60 толгой бор гөрөөс, 30 толгой зэрлэг гахай, 1000 толгой загас агнуулахаар батласан. 2017 оны 11-р сарын 27-ны өдрийн байдлаар 736 толгой загас, 28 толгой бор гөрөөс, 24 толгой зэрлэг гахай, 1 толгой цагаан зээрийг ахуйн зориулалтаар агнуулсан. *Хүснэгт-13*

Тусгай зориулалтаар 80 толгой тул, 800 толгой бусад загас бариулсан, 3 толгой угалз, 5 толгой цагаан зээр, 50 толгой агнуурын шувуу, 180 толгой хөхвөр тагтаа агнуулсан, 50 толгой идлэг шонхор амьдаар гадаад улсад гаргасан бөгөөд орон нутгийн төсөвт нийт 491228,32 мян.төгрөг төвлөрсөн. *Хүснэгт-14-18*

5.2 Амьтны нөөцийн хамгаалалтын хүрээнд

Биотехникийн арга хэмжээ:

Аймгийн Галшар, Баянхутаг, Баянмөнх, Дархан, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дадал, Норовлин, Мөрөн, Бор-Өндөр сумдын нутагт нутагших ховор амьтдын байршил 29 газарт сумдад олгосон байгаль хамгаалах зардал болох 8390,0 мян.төгрөгөөр нийт 12 шуувай шүү, 6 шуудай хийвэг, 400кг улаан буудай, 500кг давс, 1320 боодол өвс, 18,1тн хужир тавьсан. Үүнд:

- Галшар сумын Галшар уул, Их Арт уул, Бага Арт уулд нутагшдаг ховор амьтан болох аргальд 2тн хужир, 60 боодол өвс сумын ЗДТГазар иргэдтэй хамтран тавьсан./335,0 иян.төгрөг/
- Баянхутаг сумын Тогоотын суврагатай ам, Завсар, Бага баян, Баян гэх газруудад 100 боодол өвс, 12 шуудай шүүг сумын ЗДТГазар иргэдтэй хамтран тавьсан./1233,0 мян.төг/
- Баянмөнх сумын Язаар ууланд нутагшдаг аргальд 50 боодол өвс, 1,4тн хужирыг Язаарын гурван овоот нөхөрлөл сумын ЗДТГазар хамтран татсан./400,0 мян.төг/
- Дархан сумын Дархан ууланд 6 цэгт 8тн хужир 8 иргэд тавьж гүйцэтгэсэн./602,0 мян.төг/
- Өмнөдэлгэр сумын Хар энгэр, Бөөн, Хавтгар, Өвөрцагаан, Нарийн гуя, Цагаан даваа гэх газруудад сумын байгаль хамгаалагчид 20 боодол өвс, 3 шуудай хивэг агнуурын амьтдад тавьсан./192,0 мян.төг/
- Биндэр сумын Ар, Өвөр тарвагатай гэх газар Амин нутаг нөхөрлөл 5тн өвс, 200 кг хужирыг агнуурын амьтдад тавьсан./1000,0 мян.төг/
- Баян-Адарга, Дадал,Норовлин сумдын нутагт Онон Балжийн БЦГазарт агнуурын амьтдад биотехникийн арга хэмжээг авч ажилласан. Үүнд 400кг улаан буудай, 5200кг давс, 500кг хужир, 8тн өвс тавьж өгсөн. /5000,0 мян. төг/
- Мөрөн сумын Өндөрхаан, Гамал, Салбар ууланд 6 тн хужир аргальд тавьсан./150,0 мян.төг/
- БОр-Өндөр сумын ЗДТГазар иргэдтэй хамтран Бор Өндөр хайрханд 20 аргальд 30 боодол өвс тавьсан. /80,0 мян.төг/

Биотехникийн арга хэмжээ Зураг-28



Шүлхий өвчинтэй тэмцэх ажлын талаар:

Хэнтий аймгийн Баян-Адарга, Норовлин сумдад цагаан зээр үхэж байна гэсэн мэдээллийн дагуу хийх БОАЖГ-н дарга Б.Дархантөрөөр ахлуулсан ажлын хэсэг / мэргэжилтэн Б.Санчир, Б.Нямхатан, аймгийн Мал эмнэлгийн албаны ариун цэврийн шинэжлэгч их эмч Ч.Зоригчулуун/ 2017 оны 11-р сарын 6-ны өдрөөс 9-ний өдөр хүртэл Баян-Адарга, Норовлин сумдын нутагт ажиллав. Ажлын хэсэг Баян-Адарга суманд шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээтэй танилцаад цагаан зээрийн тархац, тоо толгой, шилжилт хөдөлгөөнийг тодорхойлох, цагаан зээрээс шүлхий өвчний дээж авах, ариутгалын посттой танилцах ажлыг зохион байгууллаа. Үүнд:

Баян-Адарга сумын Сайхны хөндий гэх газарт 3000-4000 гаруй толгой цагаан зээр нутагшиж байсан бөгөөд уг сүргээс 3 дээж аван аймгийн Мал эмнэлгийн албанд хүргүүлсэн. Дээжийг аймгийн мал эмнэлгийн албаны их эмч Т.Сансарбаатар, Ч.Зоригчулуун, сумын малын эмч Оюунчимэг, аймгийн БОАЖГ-н мэргэжилтэн Б.Санчир нар авсан бөгөөд дээж авсан 3 зээрийн устгал ариутгалыг сумаас томилсон устгалын ажлын хэсэг устгаж ариутгав.

Сүргийн урд явсан шаргачингаас цус болон цуллаг эрхтний дээж авсан. Хэл болон хөлийн салааг үзэхэд цэврүү, яр шарх үүсээгүй байсан. /Дээж авсан цэг $111^{\circ}33'7.5'', 48^{\circ}33'31.4''$ /

Сүрэгт явсан ооноос цус болон цуллаг эрхтний дээж авсан. Хэл болон хөлийн салааг үзэхэд цэврүү% яр шарх үүсээгүй байсан/Дээж авсан цэг $111^{\circ}34'32,9'', 48^{\circ}36'12,4''$ /

Сүргээс хоцорсон хэвтээд босохгүй байсан ооноос цусны дээж авсан. Хэл болон хөлийн салааг үзэхэд цэврүү, яр шарх үүсээгүй байсан./ Дээж авсан цэг $111^{\circ}49'4,8'', 48^{\circ}45'7,0''$ /

Уг дээж авсан 3 зээрийг устгал ариутгал хийх төвлөрсөн цэгт авчран устгаж ариутгасан. /Устгалын цэг $111^{\circ}35'17,3'', 48^{\circ}31'15,8''$ /

Баян-Адарга сумын Сайхан гэх газарт байрлах устгал, ариутгал, хяналтын постын үйл ажиллагаатай танилцан ажиллав. /Постын байрлал 111°35'23,6", 48°31'11,2"/

Цагаан зээрээс шүлхий өвчний дээж авлаа Зураг-29



Хэнтий аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт хийв

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016.12.02-ны өдрийн 3 дугаар хуралдааны 2 дугаар тогтоолын 7-р хавсралтаар Байгаль хамгаалах зардлаар Хэнтий аймгийн нутагт ерөнхий агнуур зохион байгуулалт хийх /20,0 сая төгрөг/-ээр батлагдсан. Энэхүү ажлын хүрээнд 2017 оны 5-р сарын 3-нд уг ажлыг худалдан авах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын тамгын газрын А/15 тоот тушаалаар батласан.

Хэнтий аймгийн нутагт ерөнхий агнуур зохион байгуулалт хийх /орон нутгийн төсвийн хөрөнгө 20,0 сая төгрөг/ ажлыг тендерт шалгарсан мэргэжлийн байгууллага болох "Эко үйлчилгээ" ТББайгууллага гэрээний дагуу гүйцэтгэсэн. Хэнтий аймгийн хөхтөн, шувуу, Хэрлэн голын загасны агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөө боловсруулагдсан ба Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр дэмжигдэж БОАЖЯаманд батлуулахаар уламжлаад байна. /Зураг-5/

EZAGAS.MN цахим эрхийн бичиг олгож эхэллээ

2016 онд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Хэнтий аймгийн Байгаль орчны газар, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах барих зөвшөөрөл олгох системийг оновчтой болгох, хялбаршуулсан шийдлийг олж нэвтрүүлэх зорилгоор "EZAGAS.MN" веб сайтыг Хэнтий аймгийн Онон голын агнуурын бүс нутагт туршилтын хэлбэрээр ажиллуулсан.

Энэхүү ажил нь Монгол орны хэмжээнд анхдагч ажил болж байгаа юм. Байгаль орчны аялал жуулчлалын газар, Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран Ахуйн зориулалтаар загас барих

эрхийн бичгийн зөвшөөрлийг цахим хэлбэрээр /EZAGAS.MN вэб сайтаар/ олгох зааварчилсан сургалт, түүний эрх зүйн орчинд өөрчлөлт хийх дүн шинжилгээний хэлэлцүүлгийг 2017 оны 2-р сарын 1-ний өдөр Чингис хотод зохион байгуулсан. Хэнтий аймгийн Дадал, Батширээт, Биндэр, Баян-Адарга, Норовлин сумд болон Дорнод аймгийн Баян-Уул сумын ИТХ-н дарга, БОХУБайцаагч, байгаль хамгаалагч, Төрийн сангийн төлөөлөл, Татварын улсын байцаагчид, Онон, Хэрлэн голын загасчдыг клубын гишүүд болон аймгийн ИТХурлын дарга, Санхүү төрийн сангийн орлого хариуцсан мэргэжилтэн, Мэргэжлийн хяналтын газрын байгалийн нөөц хариуцсан БОХУБайцаагч, Татварын хэлтсийн Орлогын тасгийн дарга, Дэлхийн байгаль хамгаалах сангийн төлөөлөгчид, БОАЖГазар, Хэрлэн, Онон Улз голын сав газрын захиргааны дарга мэргэжилтнүүд нийт 60 гаруй албан тушаалтан, гишүүд хамрагдлаа.

Мөн 2017 оны 5-р сарын 25-26-ны өдөр Дадал суманд Ахуйн зориулалтаар загас барих цахим эрхийн бичиг олгох, зааварчилгаа өгөх сургалтыг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран зохион байгуулсан. Энэхүү сургалтанд Хэнтий аймгийн Дадал, Биндэр, Батширээт, Биндэр, Норовлин сумдын болон Дорнод аймгийн Баян-Уул сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид, Онон Балжийн Байгалийн цогцолборт газрын мэргэжилтнүүд, Онон голын загасчдын холбооны гишүүд хамрагдсан. 2017.06.16-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд EZAGAS.MN веб сайтын хэлэлцүүлгийг холбогдох талуудын оролцоотой хийлээ.

Ezagas.mn сургалт Зураг-30



Нэн ховор, ховор шувуудын өлгий нутаг болох Хурх хүйтний хөндийг улсын тусгай хамгаалалтанд авахаар уламжиллаа.

Нэн ховор, ховор шувуудын өлгий нутаг болох Хурх хүйтний хөндийг 2017 оны 2-р сарын 2-ны өдрийн аймгийн ИТХурлын 2-р тогтоолоор байгалийн нөөц газар ангилалаар улсын тусгай хамгаалалтанд авахаар

уламжлаад байна. Мөн 2017 оны 5 сарын 29-30-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Хурх тосгон, Биндэр суманд Хурх Хүйтний хөндийн орон нутгийн хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах анхан шатны хэлэлцүүлгийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран сумын ЗТД Газрын ажилчид болон нөхөрлөлийн гишүүд, иргэдийг хамруулан хийсэн. Уг хэлэлцүүлэгт нийт 100 орчим оролцогч оролцсон.

6.”Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр арга хэмжээ

6.1Хэнтий аймгийн аялал жуулчлалыг сурталчлах үйл ажиллагаа

Монголын аялал жуулчлалын холбооноос БОАЖЯ-тай хамтран жил бүрийн хавар уламжлал болгон зохион байгуулдаг “Ай Ти Эм-2017” үзэсгэлэн Улаанбаатар хотноо Мишээл Экспогийн шинэ үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдлаа. 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд нийт 3 өдөр үргэлжилсэн тус үзэсгэлэн нь Монголын хамгийн том аялал жуулчлалын үзэсгэлэн төдийгүй, 21 аймгийн төлөөлөл хүрэлцэн ирж аймаг орон нутгийнхаа бүтээгдэхүүн, эвент арга хэмжээгээ сурталчлан танилцуулдагаас гадна аялал жуулчлалын бизнес эрхлэгчид шинэ бүтээгдэхүүнээ сурталчлах, борлуулах, түншлэлийн гэрээ хэлэлцээр хийх, гадаад, дотоодын аялал жуулчлалын салбарын судлаачдын семинарт оролцох зэрэг боломжоор хангагддаг билээ.

Хэнтий аймгийн хувьд 2009 оноос хойш аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр 9 дэх жилдээ энэхүү үзэсгэлэнд оролцож байна. Үзэсгэлэнд оролцсоноор өөрийн аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг олон нийтэд сурталчилан танилцуулж, жилээс жилд туршлагжан талбай, зохион байгуулалт, тохижилт, үйл ажиллагаагаа өргөжүүлсээр ирсэн болно. Үзэсгэлэнд Хэнтий аймгийн нутгийн зөвлөлийн тэргүүн Улсын их хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал болон нутгийн зөвлөлийн гишүүд ирж өөрийн аймгийн үйл ажиллагаатай танилцан ирэх жиийн үзэсгэлэнд нутгийн зөвлөл дэмжин оролцохоо илэрхийллээ.

Хэнтий аймгийн үзэсгэлэнг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Б.Баясгалан ахлан зохион байгуулсан. Энэ жил Батширээт-5, Биндэр-1, Дадал-1 нийт 3 сумын 7 жуулчны, Чингис хотод үйл ажиллагаа явуулдаг Эзэнт гүрэн зочид буудал оролцсон. Түүнчлэн аймгийн ХОХБ-ын хэлтэсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ, Биндэр, Дадал сумын удирдлагууд, Дадал сумын Байгаль орчны байцаагч, Онон Балжийн БЦГ-ын мэргэжилтэн, Баян-Адарга сумын Хатадын өргөөний менежер нар ирж өөрийн аймгийн үзэсгэлэн болон бусад аймгийн туршлагатай танилцсан.

36м2 талбайг түрээслэн авч Батширээт суманд зохион байгуулагддаг “Ёохор-2017” эвент, Биндэр суман зохион байгуулагддаг Тогорууны баярыг харуулж буриад ахуй, шувуудыг харуулж талбайг тохижуулсан үзэсгэлэнд оролцлоо.

6.2 Чингис брэнд

Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу Чингис брэнд хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 09-ний А/99 дугаарын захирамжаар батлууллаа. Чингис брэнд Дэд хөтөлбөрийг 2017 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 17 дугаар хуралдаанаар батлуулсан.

6.3 Евэнт арга хэмжээ

Мартагдаж буй өв соёлыг сэргээх, дотоод, гадаадын жуулчдыг татах, нутгийн иргэдийг эдийн засгаар дэмжих зорилгоор "Гал шарын хурдан адууны баяр", "Ёохорын наадам", "Талын түмэн адууны баяр" зэрэг эвэнт арга хэмжээг зохион байгуулна.

Ёохорын наадам: Буриад Монголчуудын уламжлалт ардын тойрон бүжиг Ёохорыг судалж сурталчлах, уламжлан өвлүүлэх, хөгжүүлэх ажлыг орон нутгийн соёл урлаг, боловсролын байгууллага, уран бүтээлч, ардын авьяастнуудын дунд өрнүүлэн дэлгэрүүлж улмаар улсынхаа болон олон улсын түвшинд Ёохор бүжгийн эзлэх байр суурийг бэхжүүлэх зорилготой "Ёохор 2017" Ардын урлагийн наадам энэ сарын 17-ны өдөр Батширээт суманд 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа.

Тус наадмыг Батширээт сумын ИТХ, ЗДТГ, "Батширээт хөгжлийн сан" зохион байгуулж, Хэнтий аймгийн ЗДТГ ивээн тэтгэсэн бөгөөд аймгийн Засаг дарга Н.Ганбямба, ТЗУХ-ийн дарга Ж.Гантулга нар оролцлоо./Зураг-10/

Тогорууны баяр: Хэнтий аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх гадаад дотоодын жуулчидад мэдээлэл олгох байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах зорилгоор "Тогорууны баяр-2017" аялал жуулчлалын эвэнт үйл ажиллагааг Олон улсын тогорууны сан, Зэрлэг амьтан хамгаалах төвөөс санаачлан БОАЖЯ, Биндэр сумын ЗДТГ, ИТХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран жил бүрийн 6 сард зохион байгуулдаг билээ. Энэхүү үйл ажиллагаа нь Монголд болон дэлхийн хэмжээнд ховордож байгаа Цэн тогоруу, мөн ус намгархаг газрын хамгааллын тухай нутгийн иргэдэд таниулах зорилготой юм. Дэлхий дээр 5 төрөлд хамаарах 15 зүйл тогоруу байдаг бөгөөд Монгол оронд нэг төрлийн 6 зүйл тогоруу байдаг билээ. Энэ жилийн Тогорууны баяр нь 2017 оны 06 дугаар сарын 13 ны өдөр Биндэр суманд зохион байгуулагдлаа.

Галшарын хурдан адууны баяр: Аймгийн Засаг даргын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "ГАЛШАР АДУУНЫ БАЯР – 2017" аялал жуулчлалын эвэнт арга хэмжээ Галшар адууг үндэслэгч Их шинжээч, төр нийгмийн зүтгэлтэн Хардэл жанжин бэйс М.Пүрэвжавын хурдан хүлэг морьдоо уяж сойдог байсан халхын суут Шөрмөсөн чулуут довонд 07 сарын 26-27-ны өдөр зохион байгуулагдлаа. Монгол улсад адууны анхны үүлдэрээр Галшар адуугаа баталгаажуулж Галшар сум "Хоёр түмэн адуу"-тай болсон, Хардэл бэйсийн унага уяачдын холбооны 20 жилийн ойн баяраа Галшарын ард түмэн, уяачид хамтатган тэмдэглэсэн. /Зураг-11/

Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Талын түмэн адууны баяр-2017 наадам: Мөнх Харилцаа ТББайгууллагын санаачилсан "Талын Түмэн Адуу" өвлийн адууны эвэнт арга хэмжээ 4 дэх удаагаа 2017 оны 11 сарын 3, 4, 5-ний өдрүүдэд Хүлэг Боорчийн нутаг Батноров сумын Хөхүүрийн талд амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү арга хэмжээг Мөнх харилцаа төрийн бус байгууллага, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Батноров сумын Засаг даргын тамгын газар, Соёлын төв, Сэцэн ханы ордон музей хамтран зохион байгууллаа. /Зураг-12/

Зохион байгуулахдаа сумын төвийн 4-р багийн нутаг дэвсгэрт нутаглаж буй малчдын 2000 –аад адууг цуглуулж гадна дотноос мал болон адуучдыг оролцуулаагүй гаднаас ирж байгаа тээврийн хэрэгсэлд ариутгал хийж байснаараа өмнөх жилүүдээс онцлогтой байлаа. Талын түмэн адуу 2017 эвент арга хэмжээг гадаад дотоодын төлөөлөл үзэж сонирхосноос гадна Улсын их хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ ирж нээлтийн ажиллагаанд оролцсон юм.Тус арга хэмжээг зохион байгуулахад гадаад, дотоодын олон байгууллага хувь хүмүүс дэмжиж ажилласан бөгөөд ерөнхий зохион байгуулагчаар Хэнтий аймгийн Батноров сумын ЗДТГ, Хөвсгөл нуурын баруун эргийн Арт88 ресорт нар ажилласан бөгөөд дэмжиж, хамтран ажилласан бусад байгууллагуудыг танилцуулахад Нийслэлийн Аялал Жуулчлалын Газар, Дэлхийн Зөн –Бор-Өндөр 2 ОУБ-ийн Хэнтий аймаг дахь салбар, Тэрхийн цагаан нуурын эрэгт байрлах Майхан Толгой жуулчны бааз, аялал жуулчлалын тур оператор Dream Mongolia болон Inspire Mongolia, Boojum Expeditions компаниуд болон Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сэцэн ханы ордон музей, Монголын Залуучуудын Холбоо, Хэнтий аймгийн мэргэжлийн гэрэл зургийн S studio зэрэг 20 байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд энэхүү эвент санхүүгийн хувьд бат суурьтай, төлөвлөсөн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах боломж бүрдсэн болно. Харин арга хэмжээний зохион байгуулалтын ар талд Батноров сумын засаг даргын тушаалаар байгуулагдсан 11 ажлын хэсгийн 50 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаа.Тус эвентийг 2017 оны 8 сараас гадаад, дотоодын олон сувгаар эвентийн тухай мэдээллийг эрчимтэй цацаж, тасралтгүй ажилласан нь үр шимээ өгч зорин ирэх гадаад, дотоодын үзэгчдийн тоо 3 өдрийн хугацаанд 1000 гаруйд хүрсэн байна. Үүнээс 250 гаруй буюу нийт оролцогчдын 20 гаруй хувь нь зорьж очиж мөнгө төлж үзсэн гадаад, дотоодын жуулчид байсан бөгөөд Герман, АНУ, Их Британи, Австрали, Польш, Франц, Хятад, Япон зэрэг 10 орчим орны жуулчид байв.

10.ИТМ-2017 аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд орон нутгаа сурталчилан оролцоно.

Монголын аялал жуулчлалын холбооноос БОАЖЯ-тай хамтран жил бүрийн хавар уламжлал болгон зохион байгуулдаг “Ай Ти Эм-2017” үзэсгэлэн Улаанбаатар хотноо Мишээл Экспогийн шинэ үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдлаа. 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд нийт 3 өдөр үргэлжилсэн тус үзэсгэлэн нь Монголын хамгийн том аялал жуулчлалын үзэсгэлэн төдийгүй, 21 аймгийн төлөөлөл хүрэлцэн ирж аймаг орон нутгийнхаа бүтээгдэхүүн, эвент арга хэмжээгээ сурталчлан танилцуулдагаас гадна аялал жуулчлалын бизнес эрхлэгчид шинэ бүтээгдэхүүнээ сурталчлах, борлуулах, түншлэлийн гэрээ хэлэлцээр хийх, гадаад, дотоодын аялал жуулчлалын салбарын судлаачдын семинарт оролцох зэрэг боломжоор хангагддаг билээ.

Хэнтий аймгийн хувьд 2009 оноос хойш аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр 9 дэх жилдээ энэхүү үзэсгэлэнд оролцож байна. Үзэсгэлэнд оролцсоноор өөрийн аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг олон нийтэд сурталчилан танилцуулж, жилээс жилд туршлагжан талбай, зохион байгуулалт, тохижилт, үйл ажиллагаагаа өргөжүүлсээр ирсэн болно. Үзэсгэлэнд Хэнтий аймгийн нутгийн зөвлөлийн тэргүүн Улсын их хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал болон нутгийн зөвлөлийн гишүүд

ирж өөрийн аймгийн үйл ажиллагаатай танилцан ирэх жиийн үзэсгэлэнд нутгийн зөвлөл дэмжин оролцохоо илэрхийллээ. Хэнтий аймгийн үзэсгэлэнг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Б.Баясгалан ахлан зохион байгуулсан. Энэ жил Батширээт-5, Биндэр-1, Дадал-1 нийт 3 сумын 7 жуулчны, Чингис хотод үйл ажиллагаа явуулдаг Эзэнт гүрэн зочид буудал оролцсон. Түүнчлэн аймгийн ХОХБ-ын хэлтэсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ, Биндэр, Дадал сумын удирдлагууд, Дадал сумын Байгаль орчны байцаагч, Онон Балжийн БЦГ-ын мэргэжилтэн, Баян-Адарга сумын Хатадын өргөөний менежер нар ирж өөрийн аймгийн үзэсгэлэн болон бусад аймгийн туршлагатай танилцсан. 36м² талбайг түрээслэн авч Батширээт суманд зохион байгуулагддаг “Ёохор-2017” эвент, Биндэр суман зохион байгуулагддаг Тогорууны баярыг харуулж буриад ахуй, шувуудыг харуулж талбайг тохижуулсан үзэсгэлэнд оролцлоо./Зураг-13/

Аялал жуулчлалын сургалт:

ДЭЛХИЙН ЗӨН - БОР ӨНДӨР-2 ОУ-ын байгууллага, Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын ур чадварын мэргэжлийн сургуультай хамтран “Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын боловсрол олгох” сургалтыг Хэнтий аймгийн Биндэр суманд 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Сумын ЗДТГ-ын Иргэний танхимд ойролцоох сумдын орон нутгийн иргэдэд зохион байгууллаа.

Уг сургалтын зорилго: Аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зарчим, байгалийн нөөц, түүх, соёлын өвийг экологийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон ашиглах, аялагч жуулчдад үйлчлэх, тайлбар хийх хөтөчийг бэлтгэх, байгаль хамгаалах тухай шинэлэг арга туршлага, ур чадварыг эзэмшүүлэх, Орон нутгийн иргэдийн аялал жуулчлалаас хүртэх үр ашиг, иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих, салбарын сүүлийн үеийн мэдээ мэдээллийг тус орон нутгийн нөхөрлөлийн гишүүд, өрхийн аж ахуй эрхлэгчдэд хүргэх, харилцан санал солилцох, нэгдсэн ойлголт мэдээлэлтэй болгох зорилготой байсан.

Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, гар урлалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож урамшуулах сурталчлах ажлыг зохион байгуулах зорилгоор сумдаас судалгааг нэгтгэн авсан байна.

Нутгийн иргэдийг түшиглэн гар урлалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх үнэ цэнэтэй бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох зорилгоор Баялаг бүтээгч Хэнтийчүүд дэд хөтөлбөрийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчийн хуралдаанаар оруулан батлуулан ажиллаж байна. 2017 оны 4 сард ардын гар урчуудын судалгааг авч нэгтгэхэд 262 ардын гар урчууд байна.

**7.”Хот суурин газрын орчны бохирдлын хэмжээг бууруулах арга
хэмжээ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад
чиглэсэн арга хэмжээ**

Аймгийн хэмжээнд жилдээ 3-4 удаа нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж ажилласан. 365 аж ахуйн нэгж, байгууллагын, 16184 өрхийн иргэдийг дээрх ажилд татан оролцуулсан бөгөөд 25190тн хог хаягдлыг цэвэрлэж, төвлөрсөн хог хаягдлын цэгт хаясан.

Мөн Чингис хотын хуучин хогийн цэгт төвлөсөн хогийг ковш, бульдозороор баруун хойд болон хойд талаас 2000 м² хогийг дотогш түрж, 2812.5 м² талбайд нүх ухаж 3000 тн хогийг булж, 1600 м² шороогоор дарж булсан.

Хэрлэн сумын хуучин хогийн цэгийн хогийг булж байгаа байдал Зураг-31



Чингис хотын шинэ хогийн цэг нь 2 га ашигтай талбайтай, 150 метрийн урттай 5 н ширхэг нүхнээс бүрдсэн гүн нь 3 метр, дээшээ 3 метрийн өндөр далан бүхий цэг байгуулаад байна.

Шинэ хогийн цэг байгуулж буй байдал Зураг-32



8.”Байгаль орчны чиглэлийн сургалт сурталчилгаа, хяналт шалгалт, мэдээллийн санг баяжуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ

8.1 Байгаль орчны чиглэлийн сургалт сурталчилгаа

Уул уурхайн чиглэлээр:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой бичил уурхай” төсөл болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” дэд хөтөлбөрийн хүрээнд сургалт зохион байгуулахаар 2 ажлын хэсэг томилогдож 5 дугаар сарын 28-ны өдрөөс 5 хоногийн хугацаатай Галшар, Бор-Өндөр, Дархан, Цэнхэрмандал, Бэрх, Батноров, Баян-Адрага, Норовлин сумдад ажиллалаа.

2.Аймгийн ЗДТГ-аас “Бүх нийтийн эрх зүйн боловсрол”-ын хүрээнд хийгдэж буй ажлууд, БОАЖГ-аас “Бичил уурхайн хууль эрх зүйн орчин”, Татварын хэлтсээс “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, татвар төлөх, тайлагнах тухай”, ЦГ-аас Цагдаагийн албаны тухай хууль, ЭМНДХ-ээс “Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол, эрүүл мэнд, сайн дурын даатгалын тухай”, ЭМГ-аас Эрүүл ахуйн тухай хууль, “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн мэдээлэл, ГБХЗХГ-аас “Тэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга”, ХХҮГ-аас “Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн тухай”, ГХБХБГ-аас Газрын тухай хууль, түүний хэрэгжилтийн талаар, “Хэрлэнгийн Цэнхэр алс” ТББ-аас “Архидалтгүй Хэнтийчүүд” зэрэг сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулж, мэдээлэл өглөө. Сургалтад орон нутгийн бичил уурхай эрхлэгч нөхөрлөл, нөхөрлөл байгуулах сонирхол бүхий иргэд болон сумдын холбогдох зарим мэргэжилтнүүд зэрэг нийт 263 иргэн хамрагдсан байна.

3.Орон нутгийн Төр захиргааны байгууллагуудын удирдлага мэргэжилтнүүдэд зориулсан “Уул уурхайн үйл ажиллагаанд холбогдох талуудын оролцоог хангах боломж” сэдэвт сургалт зөвлөгөөнд 2017 оны 09 дугаар сарын 19-ны өдөр зохион байгууллаа. Сургалтын зорилго Төслийн хүрээнд боловсруулагдсан Хууль, эрх зүйн үнэлгээний тайлангийн үр дүнг талуудад түгээх ба Уул уурхайн шийдвэр гаргалтанд орон нутгийн талуудын тэгш оролцоог хангах хамтын ажиллагааны загвар тогтолцоог танилцуулан хэлэлцүүлэх чиглэлээр зохион байгууллаа. Сургалтанд аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид, Аймгийн цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Аж ахуй нэгжийн төлөөллийн нийт 91 хүн сургалтанд хамрагдсан.

Тусгай хамгаалалттай газар нутаг:

1.2017 оны 4 сарын 12-13-ны өдөр Чингис хотод Тосон Хулстайн байгалийн нөөц газрын хамтын менежментийн зөвлөлийн хурал зохион байгуулагдсан. Энэхүү хуралд Хэнтий, Дорнод аймгийн БОАЖГазар, УЦУОШГазар, Дорнод хамгаалалтын захиргаа, Хэрлэн голын сав газрын захиргааны дарга, мэргэжилтнүүд, Монголын байгаль орчны иргэнийн зөвлөлийн Дорнод аймгийн зохицуулагч, Норовлин, Баян-Овоо, Баянтүмэн, Хөлөнбуйр, Цагаан-Овоо сумдын ИТХ-н дарга, Засаг дарга, байгаль хамгаалагчид, нөхөрлөлийн гишүүд, ТНС хөтөлбөрийн газрын зохицуулагч, мэргэжилтнүүд буюу нийт 49 хүн оролцлоо.

2.2017 оны 4 сарын 14-ны өдөр Чингис хотод Түмэнхаан-Шалзын орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамтын менежментийн зөвлөлийн хурал зохион байгуулагдлаа Энэхүү хуралд Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ MON/13/303 төслийн зохицуулагч, мэргэжилтнүүд, Биологийн хүрээлэнгийн эрдэмтэд, Хэнитй, Дорнод аймгийн БОАЖГазрын дарга, мэргэжилтнүүд, Дорнод УТХГазрын хамгаалалтын захиргааны төлөөлөл, Онон Балжийн УТХГазрын хамгаалалтын захиргааны төлөөлөл, Цагаан овоо, Баян-Уул, Норовлн сумын төлөөлөл буюу 32 оролцогч оролцсон.

Усны асуудлаар:

1.2017.05.24-25-ны өдрүүдэд Дадал суманд болсон Зүүн бүсийн усны 3 сав газрын захиргаад, аймгуудын БОАЖГазрын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, чадавхжуулах, уулзалт, хэлэлцүүлэгт оролцов. Тус хэлэлцүүлэгт уригдан ирсэн Байгаль орчны гавъяат ажилтан, БОАЖСайдын усны бодлогын зөвлөх, доктор Ц.Балдандорж, доктор Г.Долгорсүрэн нарын олон жилийн туршлага, зөвлөмжийг сонсож, тулгарч буй бэрхшээл, ээдрээтэй асуудлын талаар хэлэлцэж, санал бодлоо солилцсон. Хэлэлцүүлэгт усны сав газрын захиргаадын 30 албан хаагчид оролцлоо.

2.2017.05.26-ны өдөр Дадал суманд Ахуйн хэрэглээний загасны зөвшөөрлийг цахимаар олгох, цахим сайттай ажиллах дадлагажуулах, зааварчлах сургалтыг Онон голын Загасчдын холбооны гишүүд, Батширээт, Биндэр, Дадал, Баян-Адрага, Норовлин, Баян-Уул сумдын Байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагчдыг оролцуулсан сургалтанд хамрагдлаа. Онон-Улз голын сав газрын захиргааны үйл ажиллагаатай Онон голын Загасчдын холбооны үйл ажиллагааг уялдуулан ezagas.mn сайтад мэдээлэл оруулж байх талаар саналаа солилцлоо. Сургалтад орон нутгийн удирдлага, албан хаагчид болон иргэд оролцсон 42хүн хамрагдсан.

3.2017.05.29-ны өдөр Умард Говийн Гүвээт – Халхын Дундад Талын сав газрын зөвлөлийн гуравдугаар хуралдаанд оролцлоо. Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах болон усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулахад санал солилцож, УННМТөлөвлөгөө боловсруулах багт саналыг хүргүүлэхээр зөвшилцөв. Нийт 8 аймаг, 1 дүүргийн 50 хүн оролцлоо.

Ойн чиглэлээр хийсэн сургалт:

1. Хэнтий аймгийн ой бүхий Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Дадал, Норолин сумдын ИТХ, ЗДТГ, сум болон сум дундын ойн ангиас хамтран зохион байгуулсан “Ойн хуулийг таниулах, ойн менежментийг сайжруулахад талуудын оролцоо” сэдэвт сум бүрт зохион байгуулсан зөвлөгөөнд Ойн албаны дарга, ой, ургамлын ашиглалт хамгаалалт хариуцсан мэргэжилтэн нар 2017 оны 2 дугаар сарын 6 –ны өдрөөс 2 дугаар сарын 12 -ний өдрүүдэд оролцсон.

Уг зохион байгуулсан зөвлөгөөнд Ойн албанаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 12 дугаар сарын 13 ны өдрийн А/133 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ойгоос мод бэлтгэх журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Бэлтгэх модны санал ирүүлэх хүснэгтийн загвар”, 3 дугаар хавсралтаар батлагдсан” Мод бэлтгэх гэрээний загвар”, 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Мод тээвэрлэх

хяналтын хуудасны загвар”, 5 дугаар хавсралтаар батлагдсан “Ойгоос мод бэлтгэх эхлэл, төгсгөлийн актын загвар” 6 дугаар хавсралтаар батлагдсан “Мод бэлтгэх технологийн картын загвар” хавсралтуудын танилцуулага, ОББЦГ-ын захиргаанаас 2016 оны үйл ажиллагааны тайлан, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь зүүн бүсийн салбар, аймгийн БОАЖГ-аас хамтран зохион байгуулж буй Мод дагаж ус-Ус дагаж амьдрал аяны танилцуулага, Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, ойн тогтвортой ойн менежмент, нүүстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн Хэнтий аймаг дахь зохицуулагч З.Ууганбаяр Төслийн үйл ажиллагаа, 2017 оны төлөвлөгөө зэрэг илтгэл, мэдээ мэдээлэлийг зөвлөгөөнд оролцсон сумын удирдлагууд, иргэд, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудад дэлгэрэнгүй байдлаар танилцуулсан.

Зөвлөгөөнд ОББЦГ, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь зүүн бүсийн салбар, “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, ойн тогтвортой ойн менежмент, нүүстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн Хэнтий аймаг дахь зохицуулагч зэрэг байгуулага, байгууллагын төлөөлөлтэй хамтран мэдээлэл солилцон, хамтран ажилласан.

“Ойн хуулийг таниулах, ойн менежментийг сайжруулахад талуудын оролцоо” сэдэвт зөвлөгөөнд ой сумдын иргэн, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудын 354 хүн оролцож ойн тухай хууль, бусад дүрэм журмын мэдээ мэдээлэлээр хангагдсан.

Амьтны чиглэлээр хийсэн сургалт:

1.2016 онд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Хэнтий аймгийн Байгаль орчны газар, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах барих зөвшөөрөл олгох системийг оновчтой болгох, хялбаршуулсан шийдлийг олж нэвтрүүлэх зорилгоор “EZAGAS.MN” веб сайтыг Хэнтий аймгийн Онон голын агнуурын бүс нутагт туршилтын хэлбэрээр ажиллуулсан.

Энэхүү ажил нь Монгол орны хэмжээнд анхдагч ажил болж байгаа юм.

Байгаль орчны аялал жуулчлалын газар, Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран Ахуйн зориулалтаар загас барих эрхийн бичгийн зөвшөөрлийг цахим хэлбэрээр /EZAGAS.MN вэб сайтаар/ олгох зааварчилсан сургалт, түүний эрх зүйн орчинд өөрчлөлт хийх дүн шинжилгээний хэлэлцүүлгийг 2017 оны 2-р сарын 1-ний өдөр Чингис хотод зохион байгуулсан.

Хэнтий аймгийн Дадал, Батширээт, Биндэр, Баян-Адарга, Норовлин сумд болон Дорнод аймгийн Баян-Уул сумын ИТХ-н дарга, БОХУБайцаагч, байгаль хамгаалагч, Төрийн сангийн төлөөлөл, Татварын улсын байцаагчид, Онон, Хэрлэн голын загасчдыг клубын гишүүд болон аймгийн ИТХурлын дарга, Санхүү төрийн сангийн орлого хариуцсан мэргэжилтэн, Мэргэжлийн хяналтын газрын байгалийн нөөц хариуцсан БОХУБайцаагч, Татварын хэлтсийн Орлогын тасгийн дарга, Дэлхийн байгаль хамгаалах сангийн төлөөлөгчид, БОАЖГазар, Хэрлэн, Онон Улз голын сав газрын захиргааны дарга мэргэжилтнүүд нийт 60 гаруй албан тушаалтан, гишүүд хамрагдлаа.

2. 2017 оны 5-р сарын 25-26-ны өдөр Дадал суманд Ахуйн зориулалтаар загас барих цахим эрхийн бичиг олгох, зааварчилгаа өгөх сургалтыг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль орчин ,аялал жуулчлалын газартай хамтран зохион байгуулсан.Энэхүү сургалтанд Хэнтий аймгийн Дадал, Биндэр,Батширээт, Биндэр, Норовлин сумдын болон Дорнод аймгийн Баян-Уул сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид,Онон Балжийн Байгалийн цогцолборт газрын мэргэжилтнүүд, Онон голын загасчдын холбооны гишүүд хамрагдсан.

3.2017 оны 5-р сарын 24-нд Хэрлэн суманд “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх” төслөөс Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд, Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн биологийн багш нарт Биологийн олон янз байдлын талаарх мэдээлэл өглөө.

4.2017 оны 5 сарын 29-30-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Хурх тосгон, Биндэр суманд Хурх Хүйтний хөндийн орон нутгийн хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах анхан шатны хэлэлцүүлгийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран сумын ЗТДГазрын ажилчид болон нөхөрлөлийн гишүүд, иргэдийг хамруулан хийсэн. Уг хэлэлцүүлэгт нийт 100 орчим оролцогч оролцсон.

Уул уурхайн чиглэлээр сургалт Зураг-33



Бусад сургалт:

1.2017.04.27-28-ны өдрүүдэд Тогтвортой хөгжлийн боловсрол төслөөс Эко сургууль сургалтыг Чингис хотод зохион байгуулж байна. Боловсрол, соёл, урлагий газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар мэдээлэл хийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын 1,2,3,4-р сургуулиуд болон Баян-Адарга, Дадал, Бор-Өндөр сумдын төлөөлөл оролцсон.

2.2017.04.26-ны өдөр Чингис хотод зохион байгуулагдсан сумдын багийн Засаг дарга нарын сургалтанд БОАЖГазрын дарга мэдээлэл хийлээ.

3.Монголын аялал жуулчлалын холбооноос БОНХАЖЯ-тай хамтран жил бүрийн хавар уламжлал болгон зохион байгуулдаг “Ай Ти Эм-2017” үзэсгэлэн Улаанбаатар хотноо Мишээл Экспогийн шинэ үзэсгэлэнгийн танхимд 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд нийт 3 өдөр зохион байгуулагдлаа. Хэнтий аймгийн үзэсгэлэнг аймгийн Байгаль орчин, газрын аялал жуулчлалын газрын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Б.Баясгалан ахлан зохион байгуулсан. Энэ жил Батширээт-5, Биндэр-1, Дадал-1 нийт 3 сумын 7 жуулчны бааз, Чингис хотод үйл ажиллагаа явуулдаг Эзэнт гүрэн зочид буудал оролцсон болно. Үзэсгэлэнд оролцсоноороо давхардсан тоогоор нийт 82 тур операторуудтай гэрээ хийн ажиллалаа. Хэнтий аймагт урьдчилсан байдлаар 5000 орчим жуулчид ирэх боломж нээгдсэн. Жилээс жилд өргөн хүрээтэй оролцож илүү туршлагажан ажиллаж байна. Тогорууны баяр, Ёохор, Адууны баяр, Бүтээлийн хурал, Хатдын наадам, Мөсний баяр гэх мэт үйл ажиллагаа сурталчилагдсан.

4.Ногоон хөгжлийн жишиг сум хэлэлцүүлэг Дадал суманд 2017.04.06-ны өдөр зохион байгуулагдсан. Энэхүү хэлэлцүүлэгт БОАЖГазрын дарга Б.Дархантөр, Ойн албаны дарга Д.Мөнгөнцэцэг нар оролцсон.

5.2017.04.10-12-ны өдөр БОАЖЯ-с зохион байгуулсан Төсөл, хөтөлбөрт хамрагдах, төсөл хөтөлбөр боловсруулах арга зүйн сургалтанд Ойн албаны дарга Д.Мөнгөнцэцэг хамрагдсан.

8.2 Олон нийтийн оролцоог хангах арга хэмжээнүүд

1. Улаан ном хэн сайн мэдэх вэ уралдаан

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархац нутаг нь хумигдаж, тоо толгой нь цөөрч устах аюулд орсон биологийн төрөл, зүйлүүдийн талаар мэдлэг, мэдээлэл олгох, байгаль хамгаалах үйлсэд сурагчдын оролцоог нэмэгдүүлэх, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах төлөвшил олгох зорилго бүхий “Улаан номыг хэн сайн мэдэх вэ?” танин мэдэхүйн уралдаант тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 2017 оны 05-р сарын 11-ний өдөр Хан Хэнтий цогцолбор сургууль дээр зохион байгууллаа. Тэмцээнд Хэрлэн, Биндэр, Өмнөдэлгэр, Батноров сумдын ерөнхий боловсролын 7 сургуулийн 8 багийн 40 ахлах ангийн сурагч оролцсон.1-р байр Хан хэнтий цогцолбор сургуулийн Хотон шувуу баг эзэлж БОАЖСайдын өргөмжлөл, 400000 төгрөгний мөнгөн шагнал, 2-р байр Хэрлэн 1-р сургууль Хувьсал баг эзэлж БОАЖСайдын өргөмжлөл ,300000 төгрөгний шагнал,

3-р байр Өмнөдэлгэр сумын Изал баг эзэлж БОАЖСайдын өргөмжлөл 200000 төгрөгний мөнгөн шагнал, Тусгай байрыг Тэмүүжин цогцолбор сургууль Тэмжүүжин-1 баг эзэлж БОАЖСайдын өргөмжлөл ,100000 төгрөгний мөнгөн шагнал тус тус авсан.Тэмцээнийг анх 2016 онд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын ивээл дор Улаанбаатар хотын 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд амжилттай явуулж, оролцсон сурагчид, багш нар тус Улаан номд бүртгэгдсэн

амьтан, ургамлын талаар сонирхолтой асуулт хариулт, жүжигчилсэн тоглолт хэлбэрээр явагддаг тэмцээн нь танин мэдэхүйн болон бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд өндөр ач холбогдолтой хэмээн үнэлж байв. Улаан номыг хэн сайн мэдэх вэ? тэмцээн нь 2 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд энэ жилийн тэмцээн нь орон нутагт хийж байгаагаараа онцлог юм. /Зураг-3/

2. Эх дэлхийн цаг арга хэмжээ

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх бодит мэдээллийг иргэд, олон нийтэд таниулах эх дэлхийгээ хайрлан хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Эх дэлхийн цаг”-ийг 2017.03.25-ны өдөр олон нийтийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний удирдамжийг боловсруулан батлуулж, удирдамжийн дагуу байгууллагуудын дунд зарласан “Эрчим хүчээ хэмнэхэд бидний оролцоо” сэдэвт илтгэлийн уралдаанд 1-р байрт Хэнтий Цахилгаан түгээх сүлжээ салбарын Хангах үйл ажиллагаа хариуцсан Ч.Ариунаагийн тавьсан илтгэл тэргүүлж, Мэдээлэл Холбоо сүлжээ ТӨК-ны инженер Х.Мөнхжаргал(2-р байрт), Хан Хэнтий цогцолбор сургуулийн багш Б.Заяа (3-р байр) нар удааллаа.

Мөн “Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл” сэдэвт богино хэмжээний видеог орон нутгийн Өндөрхаан телевизээр олон нийтэд болон уг арга хэмжээнд оролцогчдод үзүүлж мэдээлэл түгээлээ. Уур амьсгалын өөрчлөлтийг нэг оройн 60 хором ч болов бууруулах зорилгоор Чингисийн талбайд индэрийн өмнө Хэнтийчүүд нэгдэн “Хэнтий, Ногоон хөгжил, 60+” үгийг бичиж, лаагаар гэрэлтүүлэх арга хэмжээг 3 дугаар сарын 25-ны өдөр Чингисийн талбайд 19 цагаас 21 цагийн хооронд амжилттай зохион байгуулж ажиллаа. Уг арга хэмжээнд цугларан ирсэн 27 байгууллагын 724 ажилтан, албан хаагч, 200 гаруй иргэдэд “Эх дэлхийн цаг”-ийн ач холбогдлын талаар мэдээлэл өгч албан ёсоор аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнийн хэлсэн үгээр нээж, тэргүүлсэн илтгэлийг Цахилгаан түгээх сүлжээ салбарын Хангах үйл ажиллагаа хариуцсан Ч.Ариунаа иргэдэд уншиж танилцуулав.

Уг үйл ажиллагааны нэг чухал үйл явц болох байгууллагуудын дунд уриа, ирц, хувцас жигдрэлтийг харж дүгнэх уралдааныг явуулж, шүүгчээр Ус, цаг уур орчны шинжилгээний газрын дарга Л.Чулуун, Хэрлэн голын сав газрын захиргааны дарга Д.Жамбаа, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга Д.Мөнгөнцэцэг нар ажиллаа. Уралдаанд: “Бензин ялгаруулахгүй, Биенээсээ өөх ялгаруулж, Утаагүй орчинд Унадаг дугуйгаа унацгаая” уриатай 2 дугаар цэцэрлэгийн хамт олон 1-р байрт, “Өөрийн хийх ажлыг хүнд бүү үлдээ Өнөөдөр хийх ажлыг маргааш гэж бүү орхи Өөрчлөлтийг Өөрөсөө” уриатай Хэнтий ЦТССалбарын хамт олон 2-р байрт “Гарын минь халуун алга шиг Ганцхан миний эх орон” уриатай 1 дүгээр цэцэрлэгийн хамт олон 3-р байрт тус тус шалгарлаа. Энэхүү үйл ажиллагааг Дэлхий ээж дууг нийтээр дуулж, албан ёсоор хааж, түрүүлсэн байгууллагын “Бензин ялгаруулахгүй, Биенээсээ өөх ялгаруулж, Утаагүй орчинд Унадаг дугуйгаа унацгаая” хэмээх уриаг хамтдаа хэлж өндөрлүүлэ

Эх дэлхийн цаг Зураг-34



3.Нөхөрлөлийн үндэсний чуулганд оролцлоо

Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн үндэсний 2 дугаар чуулган Улаанбаатар хотноо 2017 оны 04 дүгээр сарын 20-ноос 21-ний өдрүүдэд зохион байгуулагдаж байна. Уг чуулганд Хэнтий аймгийн ЗДТГ, БОАЖГ, Хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөллөөс гадна ой бүхий сумдын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч болон байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн нийт 60 төлөөлөгч оролцож байна.

8.3 Шинэлэг арга хэмжээнүүд

1.Нөхөрлөл хөгжил наадам зохион байгуулагдлаа

Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлүүдийн хариуцан хамгаалж буй газар нутгийн байгалийн нөөцийн менежментийг сайжруулах, нөөц баялагаа зүй зохистой ашиглах замаар амжиргаагаа дээшлүүлэх, нөхөрлөлийн гишүүд, нөхөрлөл, нөхөрлөлийн холбоодын туршлага солилцох, нутгийн захиргаа, иргэд, нөхөрлөл, ААН-үүдийн хамтын ажиллагааг сайжруулах, Хэнтий аймгийн 2017 оны шилдэг нөхөрлөлийн холбоо, шилдэг нөхөрлөл, нөхөрлөлийн шилдэг бүтээгдхүүнүүдийг шалгаруулан нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан, ногоон хөгжлийн төлөө дэмжигч талуудтай хамтдаа дэвшин дээшлэх зорилгын хүрээнд **Аймгийн засаг даргын ивээл дор "НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА" НӨХӨРЛӨЛ ХӨГЖИЛ-2017** наадам Чингис хотод 2017.09.19-21-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.

Энэ удаагийн “Нөхөрлөл хөгжил” наадам нь:

- Байгаль орчны салбарын яам байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд
- Байгаль хамгаалах иргэдийн санаачлага өрнөж нөхөрлөл байгуулагдсаны 10 жилийн ойн хүрээнд,
- Хэнтий Аймгийн засаг даргын ивээл дор тус тус зохиогдон байгуулагдаж байгаагаараа
-
-

- Нутгийн иргэдийн хамгаалалттай газруудаас олон төлөөлөгчид зочлон ирж оролцсоноороо туйлын онцлог ач холбогдолтой наадам болж өнгөрлөө гэдгийг мөн дурдах нь зүйтэй юм.

Нөхөрлөл хөгжил наадам Зураг 35



Наадамд 8 аймгийн 23 сумдын 80-аад байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлүүд, нөхөрлөлийн холбоод оролцож туршлага солилцох, хамтын ажиллагааг сайжруулах, олон нийтэд сурталчлах зорилготой оролцов.

“НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” уриатай “НӨХӨРЛӨЛ ХӨГЖИЛ-2017” наадмын нээлтэнд:

- Хэнтий аймгийн Засаг дарга Н. Ганбямба
- НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч Аднан Кюеринш
- БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Н.Энхтайван
- НҮБ-ын ХХ-ийн Жижиг төслийн үндэсний зохицуулагч Б. Ганбаатар
- ДБХС-гийн /WWF/ МХГ-ын Амар мөрний хөтөлбөрийн мэргэжилтэн Б. Мөнхчулуун
- Хэнтий аймгийн БОАЖГ-ын дарга Б. Дархантөр
- БХНҮХолбооны тэргүүн Д. Гансэлэм
- ОМННХолбооны тэргүүн Ч. Чинбат

- ТНС-ий төслийн байгууллага, МХГ-ын мэргэжилтэн Б. Ганхуяг
- НҮБХХ, “Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь” төслийн ажилтан н. Нарантуяа
- Өмнөдэлгэр сумын 2-р багийн “Лаглуу” нөхөрлөлийн гишүүн И. Түмэндэмбэрэл
- Хэнтий аймгийн худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга Д. Батболд нар хүндэт индэрээс оролцогчидод амжилт хүсьч, баяр хүргэж мэндчилгээ дэвшүүллээ.

Наадмын үйл ажиллагааг үзэж сонирхох, туршлага судлахаар ирсэн зочид болох Булган аймгийн 4 сум, Ховд аймгийн 2 сум, Хөвсгөл аймгийн 2 сум, Дорнод аймгийн 1 сум, Сүхбаатар аймгийн 1 сум, Хэнтий аймгий 4 сум, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн нөхөрлөлийн холбоодтой ОГСГ-ын сумдын Нөхөрлөлийн Холбоод ажил хэргийн уулзалт хийж цаашид хамтарч ажиллах талаар ярилцлаа. Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимтай нөхөрлөлийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх зах зээлийг бий болгох талаар ОМННХолбоо хамтын ажиллагааны гэрээ, санамж бичигт гарын үсэг зурлаа. Энэхүү санамж бичиг нь 2 жилийн хугацаатай байгуулав.

“НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” уриатай “ДЭВЖЭЭ” тэмцээн зохион байгуулсан. Энэхүү дэвжээ тэмцээнд 6 сумдын нөхөрлөлийн холбоо, нөхөрлөлүүдийн гишүүд оролцсон Өмнөдэлгэр, Батширээт, Хурх тосгон, Биндэр, Баян-Адарга, Дадал, Норовлин сумдын 7 баг авъяас чадвар, авхаалж самбаагаа сорьж оролцсон.

2.Хэнтий аймагт байгаль орчин болон хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төсөл хөтөлбөрүүдийн нэгдсэн уулзалтыг зохион байгууллаа.

“Хэнтий аймгийн ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026” бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаль орчин, хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах зарим зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, уялдаа холбоог сайжруулах зорилгоор 2017.05.23-ны өдөр Чингис хотод уулзалт зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Зөвлөгөөнийг аймгийн Засаг дарга Н.Ганбямба үг хэлж нээв. Зөвлөгөөнийг аймгийн ЗДТГ газрын дарга Ж.Ганбаатар удирдан явууллаа.

Хэнтий аймагт Байгаль орчин болон хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төсөл хөтөлбөрүүдийн нэгдсэн уулзалтанд: Аймгийн Засаг дарга Н.Ганбямба, ЗДТГ-ын дарга Ж.Ганбаатар, ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ, мөн хэлтсийн мэргэжилтнүүд, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Энх-Амгалан, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Б.Дархантөр, БОАЖГ-ын мэргэжилтнүүд, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Захирал Д.Батболд, ДБХСМХГ-н Амар мөрний хөтөлбөрийн менежер Д.Мөнхчулуун, Зүүн бүсийн салбарын Захирал Б.Баясгалан, Болортуяа ТНС төслийн Захирал О.Энхтуяа, төслийн ажилтан Б.Ганхуяг, Ой бүхий аймгуудын биологийн олон янз бүхий хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлал нэмэгдүүлэгч GCP/MON/008/GFF төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Ц.Солонго,

төслийн зөвлөх Д.Энхбилэг, Хэнтий аймаг дахь орон нутгийн зохицуулагч З.Ууганбаяр, Мерси Кор Монгол Олон улсын байгууллагын суурин төлөөлөгч Рамеш Сингх, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Г.Энхцэцэг, төслийн менежер Б.Энхтуяа, хөтөлбөр хариуцсан зохицуулагч Н.Баярцэцэг, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын төслийн удирдах нэгжийн Захирал Д.Далантайням, бүрэлдэхүүн хэсгийн зохицуулагч Б.Цэцэнбаатар, Ц.Алтанцэцэг, Д.Уранчимэг, Каритас Чех Репаблик ОУБ-ын Хэнтий аймаг дахь газар тариалангийн салбарын иргэний нийгэм, орон нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх төслийн менежер Ч.Даваадамдин, Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь МОН/12/301 төслийн ажилтан Д.Цогнамсрай, Хэрлэн голын сав газрын захиргааны дарга Д.Жамбаа, ХХААГ-ын албаны дарга Ц.Мөнхзул, УЦУОШГ-ын дарга Л.Чулуун гээд нийт 30-аад оролцогч оролцсон.Зөвлөгөөнд оролцогч дээрх төсөл хөтөлбөрүүд Ногоон хөгжлийн төлөөх “Хэнтийнхэн” тунхаг бичигт нэгдэн хамтран ажиллахаар гэрээг аймгийн Засаг дарга Н.Ганбямбатай байгуулав.



НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ “ХЭНТИЙН” ТУНХАГ БИЧИГ

2017.05.23

Хэнтий аймагт байгаль орчин болон хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төсөл хөтөлбөрүүдийн нэгдсэн уулзалтанд оролцогсад бид “Хэнтий аймгийн Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026” баримт бичгийн хүрээнд байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн чиглэлээр ногоон хөгжлийг дэмжиж хамтран хэрэгжүүлэхээр санал нэгтгэйгээр нэгдэж байна. Үүнд:


1. “Хэнтий аймгийн Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026” баримттай уялдуулан үйл ажиллагаагаа төлөвлөж, хэрэгжилтийг хангахад боломжтой дэмжлэг үзүүлнэ.
2. Тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх оновчтой бодлогод суурилж, эрүүл аюулгүй, ногоон орчинд хөдөлмөрлөж амьдрах боломжийг бүрдүүлэхийн төлөө ажиллана.
3. Санхүүгийн шийдвэр гаргахдаа хүрээлэн буй орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангасан хүртээмжтэй хөгжлийн зарчмыг баримтлана.
4. Байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалж, нөөцийг нөхөн сэргээх, тогтвортой ашиглалтыг дэмжиж, хууль бус ашиглалтыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийг бэлчээрийн менежменттэй нэгдмэл байдлаар хэрэгжүүлнэ.
5. Аймгийн хэмжээнд байгаль орчны салбарын тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлж, сайн туршлага бүхий орон нутаг, байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцоно.
6. Байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйд суурилсан, нэмүү өртөг шингэж инновацид түшиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
7. Бүх талуудтай хариуцлагатай, нээлттэй, ил тод, тэгш эрхийн зарчим баримтална.

ТУНХАГ БИЧИГТ НЭГДСЭН :



3. “Хэнтий аймгийн ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026” бодлогын баримт бичгээ батлуулан тохимол болгон хэвлүүллээ.

Хэнтий аймаг нь 2013 онд Монгол улсын ногоон хөгжлийн жишиг 5 аймгийн нэгээр сонгогдсон бөгөөд 2016 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёрдугаар хуралдаанаар "Хэнтий аймгийн ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026" бодлогын баримт бичгийг хэлэлцэж, баталсан. Энэхүү баримт бичиг нь нийт 17 зорилт, 103 дэд зорилттой бөгөөд уг зорилтуудыг хэрэгжүүлэх “Хэнтий аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилтын үйл ажиллагааны төлөвлөгөө 2016-2030” боловсрогдон Монгол, Англи хэл дээр хэвлэгдэн гарсан.



8.3 Байгаль орчны хяналт шалгалт арга хэмжээний хүрээнд

Уул уурхай:

Аймгийн засаг даргын 2017 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн хяналт шалгалт хийх удардамжын дагуу мэргэжлийн байгууллагатай хамтран Хэнтий аймгийн хэмжээнд уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжид 2017 оны 09 дугаар сарын 25-ны өдрөөс 10 хоногийн хугацаанд 10 сумын 13 аж ахуй нэгжид хяналт шалгаалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн Батширээт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Гансүрэнгийн аймгийн Засаг даргад 2017 оны 07-р сарын 31-ний өдрийн 53 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Засаг дарга 2017 оны 08 –р сарын 04-ний өдөр А/298 тоот

захирамж гарган аймгийн Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуунаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулсан, тус захирамжийн дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2017 оны 08-р сарын 16-ны өдрийн 231 тоот удирдамж батлагдан ажлын хэсэг Батширээт сумын “Гутайн даваа” орд газарт үйл ажиллагаа явуулж байгаа “Айвуун тэс” ХХК, “Ю энд Би” ХХК, “Гутайн даваа” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл, сумын Засаг даргын орлогч Б.Алтангэрэл нарыг байлцуулан хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар: MV-002247 ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаартай “Айвуун тэс” ХХК нь:

1. Уурхайн хилийн булангийн шав тэмдэгийн акт байхгүй;
2. Байгаль орчны менежментийн батлагдсан төлөвлөгөө байхгүй;
3. ТЭЗҮ-нд заагдсаны дагуу үйл ажиллагаа явуулаагүй;
4. Сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн 2017.06.13-ны өдрийн Зөвлөмжөөр өгсөн үүрэг даалгаврын хариуг ирүүлээгүй;
5. Газар ашиглалтын гэрээ хийгдээгүй, төлбөр төлөөгүй;
6. БОНБНҮ-ний хэрэгжилт хангалтгүй;
7. Усны гэрээний дагуу төлбөр төлөгдөөгүй;
8. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй;
9. Хаягдал баяжмал /эпил/-ын агуулгыг тодорхойлуулаагүй;
10. Баяжуулах тоног төхөөрөмжийн металл авалтыг тодорхойлох сорьцлолт хийлгээгүй;
11. Бохир усны шинжилгээ хийлгэсэн баримт байхгүй;
12. 2013 онд нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулсан; /6 с1 блокод 2.052 га-д техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд/

Авсан арга хэмжээ:

1. Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 7.1.2, 7.1.3, 7.11 дүгээр зүйлийн 7.11.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

MV-002810 ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаартай “Ю энд Би” ХХК нь:

“Ю энд Би” ХХК нь 2017 оны 06 дугаар сарын 05-наас 2017 оны 07 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацаанд 5.9 га талбайд олборлолтын үйл ажиллагааг явуулсан байна. 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс одоог хүртэл техникийн нөхөн сэргээлтийг 13 ажилтан, 2 экскаватор, 2 автосамасволтойгоор явуулж байгаа ба нийт эвдрэлд орсон газрын 25 орчим хувьд дүүргэлтийн ажлыг хийж гүйцэтгээд байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил:

1. 2017 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг хяналт шалгалт явуулж, улсын байцаагчийн 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 7 заалт бүхий 22/04/328/01 дугаартай албан шаардлагыг тус компанид өгсөн ба биелэлт 50%-тай гаргаж, албан шаардлагын биелэлтийг сумын улсын байцаагчид өгсөн

2.2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Сумын Засаг даргын баталсан удирдамжаар хяналт шалгалт хийж, тухайн өдрийн 22/04/328/02 дугаартай улсын байцаагчийн 4 заалт бүхий актаар үйл ажиллагааг бичиг баримтын бүрдэл дутуу үндэслэлээр зогсоож, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалтаар 720.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, арга хэмжээ авсан, “Ю энд Би” ХХК нь улсын байцаагчийн үйл ажиллагаа зогсоосон актыг хэрэгжүүлээгүй ба үйл ажиллагаа нь хэвийн үргэлжилсэн байна

3.БОНБНУ болон БОМТөлөвлөгөө байхгүй;

4.2017 оны Уулын ажлын төлөвлөгөө байхгүй;

5.Усны дүгнэлт гаргуулахаар Онон, улз голын сав газрын захиргаанд хүсэлт гаргаж хүргүүлсэн, хариу ирээгүй, дүгнэлт гараагүй, ус ашигласан;

6.Газар ашиглах гэрээ хийгдээгүй /төлбөр төлсөн/;

7.Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн металл авалтыг тодорхойлуулаагүй;

8.Хаягдал металл дахь агуулгыг шинжилгээнд хамруулаагүй, тодорхойлуулаагүй;

9.Усны шинжилгээ болон бохир усны шинжилгээ хийлгээгүй;

Шалгалт хийсэн талбай Зураг-36



Авсан арга хэмжээ:

Сумын улсын байцаагчийн 2017.06.20-ны өдрийн 22/04/328/02 дугаартай бичиг баримтын бүрдэл дутуу үндэслэлээр зогсоосон актыг хэрэгжүүлээгүй, олборлолтын үйл ажиллагаа явуулсан тул эвдэрсэн газрын экологи эдийн засгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар тооцуулах шаардлагатай.

“Ю энд Би” ХХК –ий 2016-2017 оны олборлолтын улмаас эвдрэлд орсон 6.5 га талбайд нөхөн сэргээлтийн болон хамгаалалтын асуудлыг Шүүхэд маргаан эцэслэн шийдвэрлэтэл тус компани хариуцна.

“Ю энд Би” ХХК-ий зүгээс нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх баталгааг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэгт ирүүлэх талаар тохиролцлоо.

MV-019023 ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаартай “Гутайн даваа” ХХК:

Тус компаний геологийн туслах ажилтан Г.Манлай, гэрээт хамгаалалтын асуудал хариуцсан “Алдар тосон” ХХК-ий OBS хамгаалалтын албаны ажилтан Л.Мөнхбаяр, Г.Оргилбат, Э.Сандагдорж, Б.Баатар нар харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулж байв.

Аймгийн Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн удирдамжийн дагуу Батширээт сумын нутаг дэвсгэр Гутайн орд газарт үйл ажиллагаа явуулж буй “Ю-энд-Би” ХХК, “Айвуун тэс” ХХК, “Гутайн даваа” ХХК-иудад уурхайн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллаа.

“Гутайн даваа” ХХК:

Гутайн даваа орд газарт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Гутайн даваа” ХХК-ий хувьд сүүлийн 3-5 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй хамгаалалтын 3 ажилтан компаний төлөөлөл нэг иргэн талбай дээрээ байсан, босоо амыг бетондон тагласан байдалтай байлаа.

“Айвуун тэс” ХХК:

“Айвуун тэс” ХХК-ий хувьд 2010 онд “Гол мөрний урсац бүрэлдэх эх,усан бүхий газрын хамгаалалтын бүс,ой сан бүхий газарт ашигт малтмал хайх,ашиглахыг хориглох тухай” хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл нь цуцлагдаж энэ хуулийн дагаж мөрдөх хуулийн журманд өөрчлөлт орсноор 2016 онд ашиглалтын тусгай зөвшөөрлөө сэргээн авсан. Өнөөгийн байдлаар тус компани нь 17 ажилтантай,эксватор 4,ковш 2,угаах төхөөрөмж 1, ачааны 6 Нордвенз машинтайгаар дотоод овоолгоо угааж цаашид уулын ажлын төлөвлөгөөний дагуу үндсэн шороон ордод уулын ажил болон олборлолтын ажил явуулахаар ажиллаж байлаа. Уул уурхайн холбогдолтой бичиг баримтын бүрдэл сайн. 2017 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө БОАЖЯаман дээр батлагдахаар хүлээгдэж /гарын үсэг дутуу/ байгаа талаар тус уурхайн менежер Л.Алтангэрэл танилцуулсан болно. Энэ талаар тус сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчид хугацаатай улсын байцаагчийн зөвлөмж өгөх үүрэг даалгавар өгч ажиллаа.

Зөрчил: 2017 оны БОМТөлөвлөгөө байхгүй.

“Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль /9.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах болон нөхөн сэргээлт хийх журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нөхөн сэргээлтийн стандартыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага тус тус батална./

Хариуцлага:

“Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль /19.1.3.байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд

гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох/

2. Ус ашиглах дүгэлт байхгүй.

“Усны тухай хууль” 28.4. /Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоо метр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана./

“Усны тухай хууль” 28.5 /Энэ хуулийн 28.4-т заасан этгээд ус ашиглах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор дүгнэлт гаргана/

3. Усны гэрээ хийгдээгүй.

“Усны тухай хууль” 29.1 /Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна./

“Ю-энд-Би” ХХК:

Ю-энд-Би ХХК-ий хувьд 2016 оны 09 дүгээр сард 2 удаа хяналт шалгалт хийгдэж байсан ба шалгалтаар уулын ажлын холбогдолтой бичиг баримтын бүрдэл дутуу байсан учир тус сумын Засаг дарга, холбогдох мэргжилтнүүд, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний хөдөлгөөний төлөөлөлүүд, иргэдийн төлөөлөл, тус компаний удирдлагыг оролцуулсан үүсээд байгаа асуудлын талаархи ярилцлагыг аймгийн Цагдаагийн газрын эдийн засгийн ахлах төлөөлөгчтэй хамтран зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч улсын байцаагчийн зөвлөмж өгч ажиллаж байсан болно. Гэвч тус компани нь улсын байцаагчийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй учир зөрчил арилгах хүртэл түр хугацаагаар үйл ажиллагааг нь зогсоож экологид учруулсан хохирлыг тооцуулж эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр Цагдаагийн газарт шилжүүлж байсан.

Тус компани нь газар дээрээ 48 ажилтантай үүнээс 12 ажилтанг орон нутгаас авч ажлуулж байгаа, ковш 2, эксватор 4, угаах төхөөрмж 1, ачааны 5 машинтайгаар уулын ажил явуулж байлаа.

Батширээт сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдөр 22/04/328/01 тоот 7 заалт бүхий хугацаатай улсын байцаагчийн албан шаардлагыг өгч биелэлтийг 2017 оны 06 дугаар сарын 14 –ний өдөр гаргаж ирүүлэхээр хүргүүлсэн байна. Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдөр ажлын хэсэг компаний захирал О.Батулгад танилцуулж улсын байцаагчийн албан шаардлагын хариу ирүүлээгүй, албан шаардлагад дурдагдсан зөрчлийг арилгаагүй тохиолдолд дараагийн

шатны арга хэмжээ авагдахыг танилцуулж хууль эрх зүй, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан болно.

Тус компаний захирал О.Баттулгын 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 10/17-16 тоот БОАЖЯ-нд Байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгүүлэх хүсэлт гаргасан боловч ерөнхий үнэлгээ болон яман нэгэн хариу ирүүлээгүй. 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 10/17-16 тоот БОАЖЯ-нд хандсан албан бичиг, Батширээт сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 22/04/328/01 дугаартай 7 заалт бүхий хугацаатай улсын байцаагчийн албан шаардлага болон улсын байцаачийн албан шаардлагын хариуг хавсаргав.

Ю-энд-Би ХХК-ий 2017 онд олборлолтон өртсөн талбай:

Нийт 0.7 га талбай дундаж гүн 3-4.5 м

Зөрчил:

БОНБЕрөнхий үнэлгээ байхгүй.

“Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль /14.1.1.бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд хийх стратегийн болон төслийн нөлөөллийн үнэлгээтэй холбогдол бүхий баримт бичгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж өгөх/

/18.4.Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцадаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна./

Хариуцлага: “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль /20.1.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэлгүйгээр төслийг хэрэгжүүлснээс буюу үнэлгээгээр тавигдсан шаардлагыг зөрчсөний улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан аргачлалын дагуу тооцож, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ. /

2017 оны БОМТөлөвлөгөө байхгүй.

“Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль /9.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах болон нөхөн сэргээлт хийх журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нөхөн сэргээлтийн стандартыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага тус тус батална./

Хариуцлага:

“Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль /19.1.3.байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох/

2017 уулын ажлын төлөвлөгөө хийгдээгүй.

“Ашигт малтмалын тухай” хууль /35.3.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь баримт бичгийг уурхай дээр байлгана:/

Ус ашиглах дүгэлт байхгүй.

“Усны тухай хууль” 28.4. /Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоо метр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана./

“Усны тухай хууль” 28.5 /Энэ хуулийн 28.4-т заасан этгээд ус ашиглах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор дүгнэлт гаргана/

Усны гэрээ хийгдээгүй.

“Усны тухай хууль” 29.1 /Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна./

Хариуцлага:“Усны тухай хууль” 33.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Амьтны чиглэлээр:

1.2017 оны 4-р сарын 11-ний өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын удирдамжийн дагуу Хэрлэн голын сав газрын захиргаа, Онон Балжийн байгалийн цогцолборт газрын захиргаа болон Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн, сумдын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчид хамтран Хэрлэн, Онон гол дагуу болон Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал, Баян-Адарга сумдын нутаг дэвсгэрт хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан.

Нэгдсэн шалгалтыг нийт 25 удаа явуулж 10 зөрчил илрүүлэн хууль бусаар 25 толгой зэвэг барьсан 3 иргэнд 1200000 төгрөгний торгууль, 850000 төгрөгний нөхөн төлбөр ногдуулсан. Ховор амьтан болох 1 толгой тул барьсан 1 иргэний хэргийг аймгийн Цагдаагийн газарт шилжүүлээд байна.

Эргүүл шалгалтын явцад амьтны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг 120 иргэнд сурталчлан таниулсан.

Эргүүл шалгалтын үед Зураг-37




2.2017 оны 10-р сарын 17-ний өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын удирдамжийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн, сумдын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчид, Онон голын загасчдын холбоо хамтран Онон гол дагуу болон Батширээт,

Биндэр, Дадал, Баян-Адарга, Норовлин, Батширээт сумдын нутаг дэвсгэрт хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан.

Нэгдсэн шалгалтыг нийт 20 удаа явуулж 4 зөрчил илрүүлэн хууль бусаар 7 толгой зэвэг барьсан 1 иргэнд 300000 төгрөгний торгууль, 68000 төгрөгний нөхөн төлбөр ногдуулсан. 15ш зэвэг, 2ш амарын цурхай, ховор амьтан болох 3 толгой тул барьсан ОХУ-н 1 иргэний хэргийг аймгийн Цагдаагийн газарт шилжүүлээд байна. Эргүүл шалгалтын явцад Амьтны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг 554 иргэнд сурталчлан таниулсан

Эргүүл шалгалтын үед Зураг-38



3. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 245 толгой идлэг шонхор соёлын зориулалтаар бариулах зөвшөөрөл гарсантай холбогдуулан 2017 оны 9-р сарын 8-ний өдрийн аймгийн Засаг даргын А/336 тоот захирамжаар” Идлэг шонхор амьдаар барих, тээвэрлэх, арчлах үйл ажиллагаанд болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих” ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү ажлын /Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Санчир, Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч С.Амгаланбаатар, Тагнуулын хэлтсийн ажилтан н.Дөлгөөн, Хэрлэн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч Д.Буянбат, Өлзийт тосгоны байгаль орчны хяналтын улсын байцаагч н.Батбилэг / хэсэг нь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2017.10.12-ний өдрийн 1 тоот удирдамжийн дагуу 2017.10.13-ны өдөр Хэрлэн сумын Өлзийт тосгоны Жимбэгэрийн ам /110°04'11"23,3¹, 47°28'11"33¹/ гэх газарт байрлах 2017010 гэрээтэй Бахрены Вант улсын отог, Мөрөн сумын Овоот /110°27'11"51,7¹, 47°18'11"45,8¹/ гэх газарт байрлах 2017001 гэрээтэй Кувейт улсын отог, 2017008 гэрээтэй Бахрены Вант улсын отгуудад хяналт шалгалтыг хийн зөрчилтэй отгуудын зөрчлийг арилгуулсан.

Отогт шалгалт хийж байгаа байдал Зураг-39



1.Хэрлэн сумын Өлзийт тосгонд байрлах 2017010 гэрээтэй Бахрены Вант улсын отогт ажлын хэсэг очиход 1 гадаад анчин/Hasan Al Mohamed Aldanash/ 2 туслах Монгол ажилтан нийт 3 иргэн 1 гэрт байрлаж байсан . УНР-1951 дугаартай машинтай .Өгөөшинд хэрэглэх 20 тагтаануудыг 2 майханд байрлуулсан.

Дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:Хэрлэн сумын Засаг даргатай идлэг шонхор барих гэрээ байгуулаагүй.Гэрээгүйгээр 2 толгой идлэг шонхор барьсан байсан. 20 толгой тагтаа зөвшөөрөлгүй өгөөшинд хэрэглэхээр барьсан . Машин дээрээ өөр отгийн/2017005/ наалт наасан.

Иймд ажлын хэсэг зөвшөөрөлгүй барьсан 2 толгой идлэг шонхорыг тавьсан тэмдэглэл үйлдэн байгальд нь буцаан тавьж 1 500 000 төгрөгний торгууль ногдуулсан. Хэрлэн сумын Засаг даргатай гэрээ байгуулж, 20 толгой тагтаанд зөвшөөрөл авахыг албан ёсоор мэдэгдсэн.

2.Мөрөн сумын Овоотод байрлах 2017001 гэрээтэй Кувейт улсын , 2017008 гэрээтэй Бахрены Вант улсын отгууд нь нийт 3 гэртэй нэг дор байрлаж байсан. Өгөөшинд хэрэглэг тагтаануудыг 3 майханд байршуулсан байсан.Кувейтын отог нь Ibrahim Alelewi Owaijan,Ahmad Abo Hossin Kassoum,Ahmad Almathan Awayjan гэх гадаад 3 анчинтай, 4604-УБЗ, 5995-УБА машинуудтай, Бахрейны Вант улсын отог нь Rached Alahmad гэх гадаад 1 анчинтай, 30-30УБА,3901-УНБ машинуудтай. 7 идлэг шонхор суултанд байсан бөгөөд 1 идлэг шонхорыг нисгэсэн. Эдгээр идлэг шонхорын 2 нь Бахрейны Вант улсын, 5 нь Кувейт улсын нэр дээр бичигдсэн бөгөөд Мөрөн сумын Засаг даргатай гэрээ байгуулсан байв. Дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:Зөвшөөрөлгүй 40 толгой тагтаа өгөөшинд хэрэглэхээр барьсан. Шонхор барих машинууд наалтгүй.Барьсан идлэг шонхорыг зориулалтын суултанд суулгаагүй.

Ажлын хэсгийг үл хүндэтгэн хяналт, шалгалт хийлгэхээс татгалзсан, хяналт шалгалтын явцад саад хийсэн. Иймд ажлын хэсэг дээрх хууль бус үйлдэлд 1 000 000 төгрөгний торгууль ногдуулсан. 40 толгой тагтаанд зөвшөөрөл авахыг албан ёсоор мэдэн зөвшөөрлийг олгосон.

Ойн чиглэлээр хийсэн хяналт:

Хэнтий аймгийн МХГ, аймгийн БОАЖГ-ын хамтарсан бүрэлдэхүүнтэй сум болон сум дундын ойн ангийн мод бэлтгэлийн талбай тусгаарлалт, ой бүхий Өмнөдэлгэр, Батширээт, Дадал, Биндэр, Баян-Адрага сумдын ойн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаа, мод бэлтгэлийн ажилд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах зорилгоор хяналт шалгалтын ажлыг 2017 оны 3 дугаар сард зохион байгуулсан.

Шалгалтанд хамрагдсан ойн мэргэжлийн байгууллагын жагсаалт Хүснэгт-19

Д/д	Сумын нэр	Ойн мэргэжлийн байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	Өмнөдэлгэр	Модон цаг ХХК	Үйлдвэрлэлийн ашиглалт, Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх
		Зоос булаг ХХК	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх
		Сайн Ундрах ХХК	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх
2	Батширээт	Оргил буман од ХХК	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх
		Үвгэн баавай ХХК	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх
		Хөвчийн нарс ХХК	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх
3	Биндэр	Хутагт өндөр шүтээн ХХК	Үйлдвэрлэлийн ашиглалт, Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх,
		Досанар ХХК	Үйлдвэрлэлийн ашиглалт, Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх,
		ХБ түнш ХХК	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх
		Дарьтбадрах ХХК	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх
4	Дадал	Балжхаан ХХК	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх
		Цагаан булаг андууд ХХК	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх
		Нарсан ой ХХК	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх

Шалгалтанд ойн мэргэжлийн 13 байгууллага хамрагдаж, үүнээс мод бэлтгэлийн ажил гүйцэтгэж байсан 8 ойн мэргэжлийн байгууллагын мод бэлтгэлийн талбайг газар дээр, мод бэлтгэлийн ажил нь эхлээгүй 5 ойн мэргэжлийн байгууллагын бичиг баримтыг тус тус шалгасан байна.

Хяналт шалгалтаар мод бэлтгэлийн талбайг шалгахад ойн мэргэжлийн байгууллагад дараах нийтлэг зөрчлүүд гарсан байна. Үүнд:

1. Ойд арчилгаа, цэвэрлэгээний огтлолтын төрлөөр мод бэлтгэлийн ажлыг явуулахдаа технологийн карт боловсруулдаггүй
2. Ойн мэргэжлийн байгууллагад ойн инженер, ойн техникч нь тогтмол ажилладаггүй

3. Мод бэлтгэлийн ажилчид нь хөдөлмөр хамгаалалын хувцасгүй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулдаггүй, бүртгэлийн дэвтэр хөтөлдөггүй
4. Ойн ангийн талбай тусгаарлалтаар тэмдэглэж өгсөн модыг авдаггүй
5. Цагааллагын зам гаргахдаа зулзган модыг гэмтээсэн
6. Талбай тусгаарласан газраас мод бэлтгэлийн ажлыг явуулахдаа зөвхөн хэрэгцээт модыг сонгон түүвэрлэн авч үзүүр, ёзоорыг мод бэлтгэсэн талбайд эмх замбраагүй тарааж үлдээсэн.
7. Мод бэлтгэлийн бригадын байрлаж байсан газрын ойр орчим хог хаясан.
8. Талбай тусгаарласан газраас дур мэдэн хэтрүүлэн мод бэлтгэсэн.
9. Мод бэлтгэсэн талбайг цэвэрлээгүй, үзүүр, ёзоорыг гишүү мөчиртэй нийлүүлэн ой дотор овоолж хаясан

Мод бэлтгэлийн талбай Зураг-40



Ойн ангийн талбай тусгаарлалт хийхэд гарсан зөрчлүүд:

Талбай тусгаарлалтын булангийн цэг, хил хязгаарын тэмдэг тэмдэглэгээг, дутуу хийсэн.

Талбай тусгаарлахдаа үйлдвэрлэлийн ашиглалт, арчилгааны огтлолтонд орох модыг тэмдэглэж өгөөгүй

Байгаль хамгаалагчтай холбоотой гарсан зөрчлүүд:

Ойн мэргэжлийн байгууллагын мод бэлтгэсэн талбайг цэвэрлэгээгүй байхад төсгөлийн актаар хүлээн авсан

Ойн мэргэжлийн байгууллагын мод бэлтгэлийн ажлын явцын хяналтыг тогтмол хийдэггүй

Сумын ИТХ-аар багын ахуйн хэрэгцээнд хувиарлагдан бэлтгэгдсэн түлээ болон хэрэглээний модонд хяналтын хуудас олгогдоггүй, гүйцэтгэлд байнгын хяналт тавьдаггүй

Дүгнэлт: Мод бэлтгэлийн үйл ажиллагаатай шууд холбоотой сум дундын ойн ангидад Ойн газрын даргын 2009 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 88 тоот тушаалын 4-р хавсралтаар батлагдсан “Ойгоос мод бэлтгэх талбайг тусгаарлах заавар”, ойн мэргэжлийн байгууллагуудад Ойн тухай хууль, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2013 оны 08 дугаар сарын 07 ны Журам батлах тухай А-223 тушаалын хавсралтаар батлагдсан Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага ажиллах журам, 2013 оны Ойд арчилгаа, цэвэрлэгээ А-244 журмыг танилцуулан мэргэжил зөвлөгөө өгөн арга зүйгээр туслах ажлыг гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 2.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын албан даалгаварын хэрэгжилт

1.Байгаль орчин ,аялал жуулчлалын сайдын 2017 оны А/70 албан даалгавар

2.Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017.06.06-ны өдрийн 01/3395 албан тоот

3.Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 3-р сарын 19-ны өдрийн 2 дугаар албан даалгавар

1.Байгаль орчин ,аялал жуулчлалын сайдын 2017 оны А/70 албан даалгавар

1.1 Орон нутагт байгалийн нөөц ашигласны төлбөрт төвлөрүүлсэн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах асуудлыг зохицуулсан хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байна. Иймд Байгаль орчин, аялал жуулчлалын газрууд 2017 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх талаар онцгойлон анхаарч ажиллах, гүйцэтгэлийн тайланг тухайн оны 12 дугаар сарын 10-ны дотор ирүүлж хэвших

2017 онд байгалийн нөөц ашигласны төлбөрөөс 1207862,0 мян.төгрөгний орлого орно гэж төлөвлөсөн

Хүснэгт-20

№	Орлогын төрөл	Мян.төг
1	Ойн нөөц ашигласны төлбөр	217160,3
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	158701,7
3	Газрын төлбөр	132000,0
4	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	700000,0
	Нийт	1207862,0

Энэхүү орлогоос байгаль хамгаалах зардалд 297000,8 мян.төгрөгийг зарцуулна гэж батлагдсан.

Хүснэгт-21

№	Хаана хувиарлагдсан	Зардал/мян.төг
1	Аймгийн хэмжээнд хувиарлагдсан /60%/	177644,0
2	Сумдад хувиарлагдсан /40%/	119356,8
	Нийт /100%/	297000,8

Аймаг болон сумын хэмжээнд олгогдсон байгаль хамгаалах зардал, гүйцэтгэл. Хүснэгт -22-26

1.2 Зарим аймгийн нутгаар өвөлжилт хүндэрч, цас ихтэй, цаашид хавар уртсах төлөвтэй байгааг анхаарч нэн ховор, ховор амьтныг хамгаалах био техникийн арга хэмжээг цаг тухайд нь авах талаар орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах;

Аймгийн Галшар, Баянхутаг, Баянмөнх, Дархан, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дадал, Норовлин, Мөрөн, Бор-Өндөр сумдын нутагт нутагших ховор амьтдын байршил 29 газарт сумдад олгосон байгаль хамгаалах зардал болох 8390,0 мян.төгрөгөөр нийт 12 шуувай шүү, 6 шуудай хийвэг, 400кг улаан буудай, 500кг давс, 1320 боодол өвс, 18,1тн хужир тавьсан.Үүнд:

- Галшар сумын Галшар уул, Их Арт уул, Бага Арт уулд нутагшдаг ховор амьтан болох аргальд 2тн хужир, 60 боодол өвс сумын ЗДТГазар иргэдтэй хамтран тавьсан./335,0 иян.төгрөг/
- Баянхутаг сумын Тогоотын суврагатай ам, Завсар, Бага баян, Баян гэх газруудад 100 боодол өвс, 12 шуудай шүүг сумын ЗДТГазар иргэдтэй хамтран тавьсан./1233,0 мян.төг/
- Баянмөнх сумын Язаар ууланд нутагшдаг аргальд 50 боодол өвс,1,4тн хужирыг Язаарын гурван овоот нөхөрлөл сумын ЗДТГазар хамтран татсан./400,0 мян.төг/
- Дархан сумын Дархан ууланд 6 цэгт 8тн хужир 8 иргэд тавьж гүйцэтгэсэн./602,0 мян.төг/
- Өмнөдэлгэр сумын Хар энгэр, Бөөн, Хавтгар, Өвөрцагаан, Нарийн гуя, Цагаан даваа гэх газруудад сумын байгаль хамгаалагчид 20 боодол өвс, 3 шуудай хивэг агнуурын амьтдад тавьсан./192,0 мян.төг/
- Биндэр сумын Ар, Өвөр тарвагатай гэх газар Амин нутаг нөхөрлөл 5тн өвс, 200 кг хужирыг агнуурын амьтдад тавьсан./1000,0 мян.төг/
- Баян-Адарга, Дадал,Норовлин сумдын нутагт Онон Балжийн БЦГазарт агнуурын амьтдад биотехникийн арга хэмжээг авч ажилласан.Үүнд 400кг улаан буудай,5200кг давс, 500кг хужир,8тн өвс тавьж өгсөн. /5000,0 мян. төг/
- Мөрөн сумын Өндөрхаан, Гамал, Салбар ууланд 6 тн хужир аргальд тавьсан./150,0 мян.төг/

Бор-Өндөр сумын ЗДТГазар иргэдтэй хамтран Бор Өндөр хайрханд 20 аргальд 30 боодол өвс тавьсан. /80,0 мян.төг/

Биотехникийн арга хэмжээ Зураг-41



1.3 Бэлчээрийн талхлагдалд орсон нэн ховор, ховор амьтны тархац, байршил нутгийг хамгаалах, бэлчээрийг чөлөөлөх, биотехникийн арга хэмжээ авах талаар орон нутгийн удирдлагад мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгч, хамтран ажиллах;

Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага сумдын хил дамансан “Хурх хүйтний хөндий” орчмын газрын 190332.9 га талбайг Улсын тусгай хамгаалаттай газрын байгалын нөөц газрын ангиллаар авах саналыг Аймгийн ИТХурын дөрөвдүгнээр хуралдааны 02 дугаар тогтоолоож дэмжүүлж, Батширээт, Биндэр сумдын хил дамансан “Гутайн даваа” орчмын газрын 39930.03 га талбайг Улсын тусгай хамгаалаттай газрын байгалын нөөц газрын ангиллаар авах саналыг Аймгийн ИТХурын Тавьдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоож дэмжүүлж “Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлээд

1.4 Тал хээр, говийн бүсүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас усан гадаргаас уурших ууршилтын хэмжээ нэмэгдэж байгаа тул усны ундаргыг малын хөлөөр талхлагдаж дарагдахаас хамгаалах, байгалиараа нөхөн сэргээгдэх боломжийг олгох зорилгоор гол, горхи, булаг, шанд, жижиг нуур тойрмыг хашиж хамгаалах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

Усны нөөц ашигласны төлбөрийн орлогоос шалтгаалан сумдад тодорхой хэмжээний төсөв хуваарилагдсаны дагуу Жаргалтхаан сум Хааны булаг, Батноров сумын “Ардын хөв”-ийг тэтгэгч булаг, Хэрлэн сум Нарангийн булаг, Галшар сум Хөөврийн бүрдний эх, Бор-Өндөр сум Далантүрүүний рашаан, Норовлин сум Цагаан хошууны булаг, Батширээт сум Бэлийн булаг, Биндэр сум 10 булгийн эхийг тус тус хашаажуулснаар ундаргыг малын хөлд дарагдах, нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлэн ажилласан. Нийт 8 сумын 17 булгийн эх хашигдсан

1.5 Ус ашиглагчдыг тоолууржуулах, хөв цөөрөм байгуулах, усны тоо бүртгэлийн ажлыг чанартай явуулах, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх, дэглэмийг мөрдүүлэх болон хог хаягдлыг цэвэрлэх ажлыг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарал хандуулж ажиллах;

Аймгийн ИТХ-ын 13 дугаар тогтоолоор Усны сан бүхий газар болох 129 гол, 943 булаг, 413 нуур, 83 худагт онцгой болон энгийн, эрүүл ахуйн бүсийг тогтоосон. Хэрлэн гол дагуу хамгаалалтын бүсээр тэмдэгжүүлэлт хийх ажлыг Баянмөнх, Дархан, Баян-Овоо сумдад эхлүүлээд байна.

Чингис хотын хүн амын ундны усны ашиглагдаж байгаа 3 эх үүсвэрийг онцгой хамгаалалтын бүсээр хашиж тэмдэгжүүлэлээд байна. Мөн Онон-Улз голын сав газрын захиргаа энэ онд усны тооллогыг зохион байгуулан ажиллалаа.

1.6 Усны сав газрын, усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх, иргэдэд хуулиа сурталчилж таниулах;

Хэнтий аймгийн нутаг дэвсгэр дэх Хэрлэн гол, Онон-улз голуудын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө батлагдаж хэрэгжиж эхлээд байна. Умард голын гүвээт-Халхын дундад талын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулагдсан. Аймгийн ИТХ-ын 13 дугаар тогтоолоор Усны сан бүхий газар болох 129 гол, 943 булаг, 413 нуур, 83 худагт онцгой болон энгийн, эрүүл ахуйн бүсийг тогтоосон. Хэрлэн гол дагуу хамгаалалтын бүсээр тэмдэгжүүлэлт хийх ажлыг Баянмөнх, Дархан, Баян-Овоо сумдад эхлүүлээд байна

1.7 2010 оны байдлаар уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын тооллогын дүнгээр тогтоогдсон улсын хэмжээнд 20 аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан 703 нэгж талбар бүхий 4320,5 га талбай эвдэрч нөхөн сэргээгдэлгүй орхигдсон байна. Иймээс Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасны дагуу нөхөн сэргээлтийн ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, аж ахуйн нэгж байгууллага тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх

Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан сумын Засаг дарга болон байгаль орчны хяналтын улсын байцаагч байгаль хамгаалагч нарт чиглэл өгч уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн орхигдсон талбайн урьдчилан судалгааг гаргуулах ажлыг эхлүүлээд байна. 2018 оны байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал төсвийг суулган эвдэрсэн газрын тооллого судалгааг хийхээр төлөвлөж байна.

2017 оны 12 дугаар сарын байдлаар Норовлин суманд үйл ажиллагаа явуулдаг "Дацан трейд" ХХК нь техникийн нөхөн сэргээлт 5.6 га, биологийн нөхөн сэргээлт 4.5 га, Батширээт суманд үйл ажиллагаа явуулдаг "Айвунтэс" ХХК нь техникийн эехөн сэргээлт 2,1 га, "Нутгийн мана" ХХК нь техникийн нөхөн сэргээлт 1,85 га, Цэнхэрмандал суманд үйл ажиллагаа явуулдаг "Шандын нуруу" ХХК нь техникийн нөхөн сэргээлт 4,2 га, "Шудрага андууд" ХХК нь техникийн нөхөн сэргээлт 0,3 га талбайд тус тус хөнхөн сэргээлтийн ажлыг хийж Аймгийн засаг даргын 2014 оны А/493 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгөөд байна. Нийт 5 аж ахуй нэгж техникийн нөхөн сэргээлт 14,05 га талбайд, Биологийн нөхөн сэргээлт 4,5 га талбайд хийж гүйцэтгэсэн байна.

1.8 Бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлож буй газар нутагт нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг аймаг сумын засаг дарга болон мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах;

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй "Тогтвортой бичил уурхай" төсөл болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрийн хүрээнд сургалт зохион байгуулахаар 2 ажлын хэсэг томилогдож 5 дугаар сарын 28-ны өдрөөс 5 хоногийн хугацаатай Галшар, Бор-Өндөр, Дархан, Цэнхэрмандал, Бэрх, Батноров, Баян-Адрага, Норовлин сумдад ажиллалаа.

Уул уурхайн чиглэлээр:

Аймгийн ЗДТГ-аас "Бүх нийтийн эрх зүйн боловсрол"-ын хүрээнд хийгдэж буй ажлууд, БОАЖГ-аас "Бичил уурхайн хууль эрх зүйн орчин", Татварын хэлтсээс "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, татвар төлөх, тайлагнах тухай", ЦГ-аас Цагдаагийн албаны тухай хууль, ЭМНДХ-ээс "Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол, эрүүл мэнд, сайн дурын даатгалын тухай", ЭМГ-аас Эрүүл ахуйн тухай хууль, "Элэг бүтэн монгол" хөтөлбөрийн мэдээлэл, ГБХЗХГ-аас "Тэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга", ХХҮГ-аас "Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн тухай", ГХБХБГ-аас Газрын тухай хууль, түүний хэрэгжилтийн талаар, "Хэрлэнгийн Цэнхэр алс" ТББ-аас "Архидалтгүй Хэнтийчүүд" зэрэг сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулж, мэдээлэл өглөө.

Сургалтад орон нутгийн бичил уурхай эрхлэгч нөхөрлөл, нөхөрлөл байгуулах сонирхол бүхий иргэд болон сумдын холбогдох зарим мэргэжилтнүүд зэрэг нийт 263 иргэн хамрагдсан байна.

1.9 Ойн нөөц бүхий Сзлэнгэ, Хөвсгөл, Хэнтий, Завхан, Төв, Булган, Дорнод зэрэг аймгууд ойн түймрээс байгаль орчинд учирсан хохирлыг тооцож, эзэн холбогдогчийг тогтоон, хохирлын төлбөрийг нэхэмжилж барагдуулсан байдал, уг төлбөрийг ойг нөхөн сэргээх, ойн бүтээмж, чанарыг сайжруулахад хэрхэн зарцуулсан талаарх мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн ирүүлэх

Аймгийн хэмжээнд 2017 оны 12 дугаар сарын 10 –ны өдрийн байдлаар нийт 8 суманд 14 удаагийн ой, хээрийн түймэр гарч түймэрт урьдчилсан байдлаар 57985 га ой, 10094,5 га хээр, нийт 67964,1 га ой, хээрийн бүс шатсан байна. Түймрийн улмаас ард иргэдийн 4 өвөлжөө, хашаа түймэрт өртөж, /урьдчилсан байдлаар/ түймрийг унтраахад 45.3 сая төгрөгийн зардал гарч, 173.4 сая төгрөгийн эд материалын хохирол, байгаль, экологид 12.3 тэрбум төгрөгийн хохирол, нийт 46 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

1.10 Орон нутгийн удирдлагууд ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх нь зөвхөн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажил мэтээр асуудалд ханддаг хандлагыгөөрчилж, Ойн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ойг хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусгуулах арга хэмжээ авна" гэсэн заалтыг бодитойгоор хэрэгжүүлж ажиллах;

Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт суулгадаг ба ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувийг ойг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний тудгамдсан асуудлуудыг шийдвэрлэх ажилд зарцуулдаг. 2017 онд нийт 3,5 сая төгрөгийг Биндэр сумын ойд хортон устгах ажилд зарцуулж 400 га талбайд устгал хийсэн. Гүйцэтгэгчээр Биндэр –Ой СДОА ажилласан.

1.11 Тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээг сум, дүүргээр тогтоохдоо Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталж байгаа нь ашиг, сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдэж байгааг хууль хяналтын байгууллагаас удаа дараа анхааруулж байгаа тул Ойн тухай хуульд заасны дагуу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлуулж ажиллах

Хэнтий аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Хэнтий аймгийн “2017 ойд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” 04 тоот тогтоолоор сум тус бүрээр хувиарлан баталсан. Уг тогтоолын дагуу ой бүхий 9 сумдын ИТХ-аас Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1.2 дэх заалтын дагуу ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллага, баг тус бүрээр хувиарлан баталсан.

1.12 Улсын тусгай хамгаалалтад авах газрын жагсаалтад орсон газруудад орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг хамруулах шинээр авах асуудлаар аймаг, сумын удирдлагуудад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага сумдын хил дамансан “Хурх хүйтний хөндий” орчмын газрын 190332.9 га талбайг Улсын тусгай хамгаалалттай газрын байгалын нөөц газрын ангиллаар авах саналыг Аймгийн ИТХурын дөрөвдүгнээр хуралдааны 02 дугаар тогтоолоож дэмжүүлж, Батширээт, Биндэр сумдын хил дамансан “Гутайн даваа” орчмын газрын 39930.03 га талбайг Улсын тусгай хамгаалалттай газрын байгалын нөөц газрын ангиллаар авах саналыг Аймгийн ИТХурын Тавьдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоож дэмжүүлж “Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлээд

байна. Мөн Мөрөн сумын “Зөөлөн” гэх газрын 7418.973 га талбайг Түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах, доройтсон орчныг нөхөн сэргээх зорилгоор Мөрөн сумын ИТХ-ын 02 дугаар тогтоолоор, “Өлзийт” орчмын газрын 2834.28 га талбайг Түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах, доройтсон орчныг нөхөн сэргээх зорилгоор Мөрөн сумын ИТХ ын 03 дугаар тогтоолоор, “Бүрээт” орчмын газрын 29301.233 га талбайг Байгалийн унаган төрх хадгалах зорилгоор Мөрөн сумын ИТХ-ын 04 дугаар тогтоолоор сумын хамгаалалтанд тус тус авч Ашигт малтмал, газрын тосны газрын кдастарын хэлтэст бүртгүүлэхээр хүргүүлээд байна.

1.13 Тусгай хамгаалалттай газар нутагт өмнө олгогдсон хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хууль тогтоомжийн хүрээнд цуцлуулах, зөвшөөрөл/йгээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг таслан зогсоож, цаашид зөрчил гаргуулахгүй байхад анхаарч ажиллах;

Ю энд Би” ХХК-ийн хууль бус үйл ажиллагаа явуулж, байгалийн нөөц баялагт их хэмжээний хохирол учруулж буй талаарх аймгийн мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 9/1134 тоот албан бичгээр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд уламжлаад байна

1.14 Байгаль орчин, аялал жуулчлалын газрууд аялал жуулчлалын оргил үед зохион байгуулагддаг аймаг, сумдын наадмын хуваарийг оны эхэнд гаргуулж, олон нийтэд мэдээлэх. аялал жуулчлалын чиглэлээр тогтмол зохион байгуулагддаг бусад арга хэмжээний хуваарийг өөрчлөхгүй байх талаар орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагатай нягт хамтарч ажиллах

Эзэн Чингис хааны өлгий нутгаар -2017 насанд хүрэгчдийн явган аялал :

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 30 жилийн ойн хүрээнд Монгол улсын Засгийн газрын 05 дугаар тогтоол Эрүүл мэнд-Хөдөлгөөн хөгжил хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах байгууллага хамт олны бие бялдрыг чийрэгжүүлэх, явган аялалын ач холбогдол, хүрээлэн буй байгалийн үзэсгэлэнт газар нутагтай танилцуулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, орон нутаг байгаль орчноо хамгаалах зорилгоор Биеийн тамир, спортын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран “ Эзэн Чингис хааны Өлгий нутгаар- 2017” насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах Явган аялалын тэмцээн 09 дүгээр сарын 07-09-ний өдрүүдэд Дадал суманд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 7 сумын / Биндэр, Дадал, Баян-Овоо, Бор-Өндөр, Жаргалтхаан, Цэнхэрмандал, / сумдын 50 гаруй тамирчид хурд хүч авхаалж самбаагаа дайчлан өрсөлдлөө.

Уралдаан тэмцээнийг 5 төрлөөр зохион байгууллаа.

- Цувааны дэг журам, сахилга бат
- Түүх соёлын дурсгалт газрын асуулт хариулт
- Бартаа саад туулах багийн буухиа тэмцээн
- Газрын зураг дээр зүг чиг тодорхойлох
- Багийн бэлтгэл техник хэрэгслийн үзлэг гэсэн төрлүүдээс гадна гэрийн даалгаврт өгсөн даалгаврыг

шалгаж цаг оноогоор байр эзлүүлэхэд Биндэр сум багийн дүнгээр 1- байр Аварга багаар шалгарч, Дэд байранд Баяновоо сумын баг, Гутгаар байранд Дадал сумын баг, Тусгай байранд Бор-Өндөр сумын багууд тус тус шалгарлаа.

Явган аялал Зураг-42



Хотын аялал :

Аймийн төв болон Чингис хотын ойролцоох аялал жуулчлалын анхаарал татсан түүх соёлын дурсгалт газруудад явганаар, унадаг дугуйгаар, автомашинаар аялах маршрутуудыг төрөл бүрийн аялах онцлогт нийцүүлж шинээр хийгээд байна.

Жил бүрийн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн нэгний өдрийг "Монгол бахархлын өдөр" болгон орон даяар тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Дээрх өдрийг угтан Хэрлэн сумын ЗДТГ, Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран “Соёлын өв-Бидний бахархал” танин мэдэхүйн тайлбарт аялалыг "Эрдэм-Баян" 4 дүгээр сургуулийн н.Энхбаяр багштай 10а ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Их эзэн Чингис хааны өлгий Хан Хэнтий нутгийн онцлог, түүхэн дурсгалт газрууд, Түүх, соёлын өвийг сурагчдад танин мэдүүлж, цаашид хайрлан хамгаалах, бахархах, олон нийтэд сурталчлах нь аялалын гол зорилго юм. Тайлбарт аялалын хүрээнд танилцуулсан мэдээллүүдээр Багийн тэмцээн, ганцаарчилсан “Асуулт, хариулт”-ын тэмцээнийг сурагчдын дунд зохион явуулж, манлайлсан сурагчдыг шагнаж, урамшууллаа.

“Соёлын өв-Бидний бахархал” аялалыг хамтран зохион байгуулсан Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар, Аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газар, "Хэнтий" телевиз, Хэрлэн 4 дүгээр сургууль, Гүндүгаварлин хийдийн хамт байгуулсан.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017.06.06-ны өдрийн 01/3395 албан тоот

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы хуралдаанаар “Хог хаягдлын тухай” хуулийн шинэчлэгдсэн найруулга батлагдсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2017.06.06-ны өдрийн 01/3395 албан тоотоор “Цэвэр сайхан орчин” сарын аянг зарласан.

/Хүснэгт-27/

3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 3-р сарын 19- ны өдрийн 2 дугаар албан даалгавар

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017.03.19-ны өдрийн 2 дугаар албан даалгаврын биелэлтээр:

1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиудыг Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолын хэрэгжилт, техник багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангуулан ажиллах

- Хэнтий аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслүүд дараах үзүүлэлттэй байна.

2. ИСС.mn цахим сайтанд хиймэл дагуулын сансрын зургийн мэдээллийг цаг уурын үндэсний төвөөс боловсруулан өдөрт 3-аас доошгүй удаа шинэчлэн гаргадаг ба үүнийг аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон нийт сумдууд үйл ажиллагаандаа тогтмол авч ашиглаж байна.

Хэнтий аймгийн хэмжээнд гарсан ой хээрийн түймрийн цагийн байдлын тухай мэдээ мэдээлэлийг БОАЖЯ-ны шуурхай утас 93028004 дугаарт 21 удаа өгч ажилласан байна.

3. Орон нутгийн төсвийн хөрөнгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 2017 онд 5,0 сая төгрөгийг цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсний дагуу аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газартай гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Хагас жилийн байдлаар үүлэнд зориудаар нөлөөлөх 11 удаагийн экспедиц гарч 34 удаагийн үүлэнд зориудаар нөлөөлөх харвалт хийж 3 удаа генеротар ажиллуулсан байна.

4. “Ойд арчилгаа цэвэрлэгээ хийх” чиглэлээр ойн мэргэжлийн байгууллагын эрх авахаар материалаа ирүүлсэн “Дуурлигийн овооХХК”-ны материалыг нягтлан шалгаж ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх багаж тоног төхөөрөмжтэй гэсэн дүгнэлтийг гарган БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 134 тоот албан бичгээр сумдад чиглэл өгсний дагуу ой бүхий 8 сумаас 7 суманд сумын Засаг даргын захирамжаар ойг хааж шийдвэр гарч ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах баялгийг ашиглах, аялал зугаалгаар явах, бусад үйл ажиллагааг тодорхой болгосон. Захирамжийн хэрэгжилтэнд сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хяналт тавьж ажиллаж байна.

5 Хаврын хуурайшилт ихсэж байгаатай холбогдуулан 2017 оны Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шуурхай бүлгийг Байгаль орчин аялал жуулчлалын газартай байгуулсан гэрээг үндэслэн 2017 оны 04-р сарын 11-ны өдөр Онцгой байдлын газрын даргын 2017 оны А/29 дүгээр тушаалаар Биндэр суманд, Дэлхийн Байгаль хагаалах сангийн дэмжлэгтэйгээр Бэрх тосгон, Дадал, Норовлин, Баян-Овоо, Батноров сумдад байршин ажиллаж, төв болон хөдөөгийн малчин айл өрх, ард иргэдэд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх хор уршгийг арилгах талаар мэдлэг олгож, заавар зөвлөгөө өгөх 22 бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажилласан.

Тус сумдын Онцгой комиссын гишүүд, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнд Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 онд шинэчлэн найруулагдсантай холбогдуулан хууль таниулах арга хэмжээ, болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт явуулж ой, хээрийн түймрээр цагийн байдал өгч дадлага сургууль хийлгэсэн байна.

Сумын төвийн аж ахуйн нэгж байгууллага, айл өрхөд гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, 332 иргэнд Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 онд шинэчлэн найруулагдсантай холбогдуулан хууль таниулах, болзошгүй гамшгаас өөрийгөө болон бусдыг хамгаалах, “Гал унтраах багаж хэрэгслийн ажиллах зарчим, техникийн үзүүлэлт”, “Гамшгийн үед холбоо зарлан мэдээллийг дамжуулах, хүлээн авах журам”, “Нэрвэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх арга ажиллагаа”, “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” зэрэг сэдвүүдээр сургалт явуулж, гал унтраагуураар гал унтраах дадлага сургууль хийлгэсэн.

Сумын багуудын малчин айл өрхүүдээр явж ой хээрийн түймэр, гамшиг ослын аюулаас урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж баталгаа гаруулан Биндэр сумын төвөөс гарах, орох төв замд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 2 ш самбар байршуулсан.

Шуурхай бүлгийг ой хээрийн түймрийн эрсдэл бүхий сумдад ажиллуулаж төвийн болон хөдөгийн малчин айл өрхүүдэд 8571 ширхэг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж анхааруулга тарааж, гал түймэр гарч болзошгүй 92 зөрчлийг газар дээр нь арилгуулан ажилласан байна.

6 .Хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2013-2016 онд хилийн бүс нутаг болох Дадал, Биндэр сумдад түймрээс хамгаалах 175 км урттай, 10 м өргөнтэй харлуулсан шороон зурвас байгуулагдсан билээ. Дээрх зурвасыг 2017 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр дараах байдлаар арчлан сэргээж, зурвасыг өргөнийг нэмэгдүүлэхээр Хилийн 0287 дугаар ангитай гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

1. 2013-2016 онд гаргасан дээрх 175 км урт, 10 м өргөнтэй харлуулсан шороон зурвасыг дээрх уртад 30 м-ийн өргөнтэй болгож шатаах аргаар арчлан сэргээсэн.
2. Дээрх түймрээс хамгаалах зурвастэй зэрэгцүүлэн 175 км газрыг 10 м-ийн өргөнтэйгөөр шинээр хагалж нийт зурвасны өргөнийг 40-60 м-ийн өргөнтэй болгохоор холбогдох газруудтай хамтран ажиллаж 86км газрыг шинээр хагалсан. Хэнтий аймаг нь 2017 онд ойн цэвэрлэгээний ажлаар 3716 га талбайгаас 77480 м³ модыг цэвэрлэгээний ажлаар бэлтгэхээр хуваарилагдсан ба ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүд болон сумын иргэд ойд цэвэрлэгээ хийж байна. Одоогийн байдлаар 20000 м.куб модыг цэвэрлэгээний ажлаар бэлтгэсэн.

Монгол улсын Засгийн газрын байгаль орчинтой холбоотой гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах

Шийдвэр ийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/
1	2	3	4	5
2017_36. 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 36 дүгээр тэмдэглэл - ЗГ-ын хуралдааны тэмдэглэл				
16	ХҮҮ.3. 2.	Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангуулах, эвдэрсэн газрын тооллого хийх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	Аймгийн ЗДТГ-аас “Бүх нийтийн эрх зүйн боловсрол”-ын хүрээнд хийгдэж буй ажлууд, БОАЖГ-аас “Бичил уурхайн хууль эрх зүйн орчин”, Татварын хэлтсээс “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох ЗГ-ын 151 журам, татвар төлөх, тайлагнах тухай”, ЦГ-аас Цагдаагийн албаны тухай хууль, ЭМНДХ-ээс “Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол, эрүүл мэнд, сайн дурын даатгалын тухай”, ЭМГ-аас Эрүүл ахуйн тухай хууль, “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн мэдээлэл, ГБХЗХГ-аас “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга”, ХХҮГ-аас “Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн тухай”, ГХБХБГ-аас Газрын тухай хууль, түүний хэрэгжилтийн талаар, “Хэрлэнгийн Цэнхэр алс” ТББ-аас “Архидалтгүй Хэнтийчүүд” зэрэг сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулж, мэдээлэл өглөө. Сургалтад орон нутгийн бичил уурхай эрхлэгч нөхөрлөл, нөхөрлөл байгуулах сонирхол бүхий иргэд болон сумдын холбогдох зарим мэргэжилтнүүд зэрэг нийт 263 иргэн хамрагдсан байна. Тус аймгийн хэмжээнд нийт 37 нөхөрлөлийн 170 иргэн үйл ажиллагаа эрхэлж байна.	100
17	ХҮҮ.3. 5.	Ашигт малтмалын ашиглалт дуусаж, нөхөн сэргээлтийг бүрэн хийж орон нутагт хүлээлгэн өгсөн талбайд нөхөн сэргээлт хийх нэрээр болон хууль бусаар алт олборлогчдод зөвшөөрөл олгож байгааг таслан зогсоох, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд батлагдсан хэмжээнээс хэтэрсэн хүчин чадлаар олборлолт явуулахыг хориглох, үйл ажиллагаанд хяналт тавих арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн хяналт шалгалт хийх удардамжын дагуу мэргэжлийн байгууллагатай хамтран Хэнтий аймгийн хэмжээнд уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжид 2017 оны 09 дугаар сарын 25-ны өдрөөс 10 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.Тус аймгийн хэмжээнд нөхөн сэргээлтийг бүрэн хийж орон нутагт хүлээлгэн өгсөн талбайд нөхөн сэргээлт хийх нэрээр болон хууль бусаар алт олборлогчдод зөвшөөрөл олгож байгааг таслан зогсоох, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд батлагдсан хэмжээнээс хэтэрсэн хүчин чадлаар олборлолт явуулсан аж ахуй нэгж байхгүй.	100

2017_23. 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 23 дугаар тэмдэглэл - ЗГ-ын хуралдааны тэмдэглэл				
31	IX.2.	Харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа бүртгэгдээгүй нөхөрлөл болон нөхөрлөл, хоршоодын гишүүдийг бүртгэн зохион байгуулалтад оруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт үүрэг болгов.	Тус аймгийн хэмжээнд нийт 37 нөхөрлөлийн 170 иргэн үйл ажиллагаа явуулж байгаа ба бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа бүртгэгдээгүй нөхөрлөл болон нөхөрлөл, хоршоодын гишүүдийг бүртгэн зохион байгуулалтад оруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллаж байна.	100
